

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12

— Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
— Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай
— Гэрээ соёрхон батлах тухай
— Конвенц соёрхон батлах тухай
— Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

1994 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ ,ЗАРЛИГ, ШИЙДВЭР, НИЙТЛЭЛ–ХУУЛИЙН ТАЙЛБАР)

Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар

№ 1994 оны 12 сар № 12 (31)

ГАРЧИГ

I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1063
2. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай 1069
3. Гэрээ соёрхон батлах тухай 1070
4. Гэрээ соёрхон батлах тухай 1070
5. Конвенци соёрхон батлах тухай 1071
6. Монгол Улсын 1995 оны улсын төвлөрсөн төсвийн тухай 1071

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

7. В. Алзахгүйг Байнгын хорооны гишүүнээр батлах тухай № 77 1074
8. Үнэт цаасны хорооны дарга, зарим гишүүнийг томилох тухай № 79 1074
9. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны Үндсэн чиглэлийг батлах тухай № 82 1075

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

10. Зарим ахмад дайчдыг шагнах тухай № 96 1097
11. Г. Ганболдыг Алтан гадас одонгоор шагнах тухай № 97 1099
12. Зарим ахмад дайчдыг шагнах тухай № 98 1100
13. Л. Гүнсэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 99 1101
14. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 100 1102
15. Д. Дамдиндоржийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай № 101 1103
16. Ц. Зандраад Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай № 102 1103
17. Архивын талаар авах арга хэмжээний тухай № 103 1104
18. Зарим шүүхийн ерөнхий шүүгч, шүүгчдийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай № 104 1107
19. Зарим шүүхийн шүүгчдийг томилох тухай № 105 1108
20. Ерөнхий шүүгчийг томилох тухай № 106 1108

21. Архидан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай № 151 1109

4. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС АРД ТҮМЭНДЭЭ ХАНДАЖ ГАРГАСАН ИЛГЭЭЛТ

22. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг хүчтэй болгох тухай 1111

5. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

23. Байнгын хорооны дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолтой холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай № 09 1114

6. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

24. Дүрэм батлах тухай № 106 118
25. Зөвлөл байгуулах тухай № 107 1133
26. Журамд өөрчлөлт оруулах тухай № 115 1137
27. Зааварт өөрчлөлт оруулах тухай № 116 1138
28. Дани Улсаас үзүүлэх буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх тухай № 117 1139
29. Журам батлах тухай № 121 1140
30. Зөвлөмж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай № 124 1146
31. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 125 1151
32. Шинээр байгуулагдсан аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, хот, тосгодын захирагчийн ажлын албаны тухай № 128 1152
33. Ахмад дайчдад нэг удаагийн тусламж олгох, тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай № 131 1155
34. Дүрэм батлах тухай № 139 1156
35. Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай № 141 1164
36. Суманг улсын баатар С. Төмөрбаатарын нэрэмжит болгох тухай № 142 1165
37. Заавар батлах тухай № 145 1166
38. Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай № 150 1168
39. Хорих байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай № 151 1170
40. Журам батлах тухай № 152 1171
41. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай № 153
42. Сургуулийг улсын баатар Д. Данзанваанчигийн нэрэмжит болгох тухай № 154 117[illegible]
43. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай № 155 1176
44. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийх хувьчлалын ажлыг дуусгахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай № 156 1176
45. Геологи, эрдэм баялгийн судалгааны албаны зохион байгуулалтын тухай № 161 1178
46. Хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай № 163 1180
47. Архивын талаар авах зарим арга хэмжээний тухай № 164 1181
48. Хаалттай бүсийн тухай № 165 1182
49. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай № 171 1188

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

«7. Аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийг түр буюу ажлын 12 өдрөөс дээш хугацаагаар эзгүйд түүнийг тухайн шүүхийн шүүгч; Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг түр эзгүйд түүнийг Улсын дээд шүүхийн аль нэг танхимын тэргүүн шүүгч тус тус орлоно. Энэ тухай шийдвэрийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гаргана.»

2/8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Аймаг, нийслэлийн шүүх хэрэг, маргааныг давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхэд 3 шүүгч оролцоно.»

3/13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Бүх шатны шүүхийн шүүх хуралдааны танхимд төрийн сүлд, төрийн далбааг байрлуулна.»

4/24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

«1) Улсын дээд шүүх аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэртэй хэрэг, маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэх;»

5/25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

«4) шүүх, түүний байгууллага, шүүгч, ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулалтын удирдлагаар хангах, тэдний шагнаж урамшуулах, шүүхийн төсвийн зарцуулалтад хяналт тавих;»

6/26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

«1) сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэртэй хэрэг, маргааныг давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх;»

7/27 дугаар зүйлийн 1, 2 дахь заалт:

«1) хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх аймаг, нийслэлийн шүүхийн шүүх бүрэлдэхүүнийг томилох;

2) аймаг, нийслэлийн шүүхийг тэргүүлж, түүнийг төлөөлөх, аймаг, нийслэл дэх шүүх, түүний байгууллага, иншүүгч ажилтнуудын үйл ажиллагааг зохион байгуулалтын уудирдлагаар хангах, тэднийг шагнаж урамшуулах, шүүхийнн тосвийн зарцуулалтад хяналт тавих;»

8/35 дугаар зүйлийн 5 дахь заалт:

5) шүүгчийг шилж олох, шалгаруулах, мэргэшлийнийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;»

9/35 дугаар зүйлийн 9 дэх заалт:

9) шүүгч, шүүхийн байгууллагын ажилтны ашиг сонирхол, эрхийг хамгаалах;»

10/39 дүгээр зүйл:

«39 дүгээр зүйл. Шүүгчийн сахилгын хороо

1. Сахилгын зөрчил гаргасан шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэх шүүгчийн сахилгын хороо Улсын дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхийн дэргэд тус тус ажиллана.

2. Аймаг, нийслэлийн шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороог аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдийн хуралдаанаас; Улсын дээд шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороог Улсын дээд шүүхийн хуралдаанаас 3—5 гишүүний бүрэлдэхүүнтэй (6 жилийн хугацаагаар тус тус сонгоно.

3. Аймаг, нийслэлийн болон сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчид үүсгэсэн сахилгын хэргийг тухайн аймаг, нийслэлийн шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо; Улсын дээд шүүхийн шүүгч, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчид үүсгэсэн сахилгын хэргийг Улсын дээд шүүхийн дэргэдэх шүүгчийн сахилгын хороо тус тус хянан шийдвэрлэнэ.

4. Шүүгчийн сахилгын хорооны даргыг уг хорооны гишүүд дотроосоо олонхийн саналаар сонгоно.

5. Шүүгчийн сахилгын хороо нь шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

6. Шүүгчийн сахилгын хорооны дүрмийг Ерөнхийлөгч батална.»

11/51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

«5) мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай дүгнэлтийг мэргэшлийн хороо гаргасан;»

12/52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

«1) шүүгчээс огцруулах тухай шүүгчийн сахилгын хорооны шийдвэр[1] хүчин төгөлдөр болсон;»

13/64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, зэрэг[1] дэвийн болон хууль тогтоомжид заасан бусад нэмэгдлээс бүрдэнэ. Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Улсын Их Хурал тогтооно. Улсын дээд шүүхийн шүүгч төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохирсон албан тушаалын цалин авна. Бусад шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг Улсын дээд шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээтэй зохистой харьцаатай байхаар тооцож тогтоно. Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг урьд тогтоосноос бууруулж болохгүй.»

14/64 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

«5. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүгчийн бие махбодид гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон тохиолдолд шүүгчид тэтгэвэр, тэтгэмж, албан тушаалын цалингийн зөрүүг хөдөлмөрийн чадвар түр алдсан, тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд олгоно. Хэрэв дээр дурдсан шалтгаанаар хохирсноос шүүгч хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлыг улсын төсвөөс олгоно.»

6. Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан шүүгчийн амь насыг хохироосон бол ар гэрт нь хохирогчийн 3 жилийн албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно."

2 дугаар зүйл. Шүүхийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/6[1] дүгээр зүйл:

«6[1] дүгээр зүйл. Шүүгчийг орлон ажиллах

1. Шүүгч түр буюу ажлын 12 өдрөөс дээш хугацаагаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон (өвчилсөн, чөлөөтэй зэрэг) тохиолдолд түүнийг Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйл, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг хангасан туслах шүүгч, энэ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэвэрт гарсан шүүгчдийн дотроос Ерөнхий зөвлөлийн шийдвэрээр түр орлуулж болно. Орлон ажиллах шүүгч нь шүүгчийн тангараг өргөнө.

2. Орлон ажиллах шүүгч тухайн шатны шүүхийн шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, цалин хөлс, дархан эрхэх, хараат бус байдлын бусад баталгаагаар нэгэн адил хангагдана. Харин насны тэтгэвэрт гарсан шүүгч орлон ажиллаж байгаа бол түүнд шүүгчийн албан тушаалын цалин, тэтгэврийг бүрэн хэмжээгээр олгоно.»

2/6[2] дугаар зүйл:

«6[2] дугаар зүйл. Шүүгчийн зэрэг дэв

1. Шүүгч Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гуравдугаар түшээ, дөрөвдүгээр түшээ, тавдугаар түшээ гэсэн зэрэг дэвтэй байна. Шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

2. Шүүгчид зэрэг дэв олгохдоо албан тушаал, шүүгчээр ажилласан хугацаа, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан үзнэ.»

3/7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Шүүгчээр ажиллаж байгаад насны тэтгэвэрт гарсан хүн нь тэтгэвэрт гарсан өдрөөс хойш 5 жилийн хугацаанд шүүгчийг орлон ажиллах эрхтэй.»

4/16 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Иргэдийн төлөөлөгч шүүхэд ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлсийг Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлан шүүхийн төсвөөс олгоно.»

5/39[1] дүгээр зүйл:

«39[1] дүгээр зүйл. Шүүгчийн мэргэшлийн хороо

1. Шүүгчийн мэргэшлийн хороог 9 гишүүнийг бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар Ерөнхий зөвлөл байгуулна.

2. Шүүгчийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд өндөр мэргэшилтэй, хуулийн болон шүүн таслах ажлын дадлагатай шүүгч, түүнчлэн хуульч, эрдэмтдийг оруулна. Шүүгчийн мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн гишүүн орохгүй.

3. Шүүгчийн мэргэшлийн хороо нь нэр дэвшигчийн, түүнчлэн Ерөнхий зөвлөл буюу энэ хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т заасан шүүх бүрэлдэхүүн албан тушаалтны хүсэлтээр шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварыг шалгаж дүгнэлт гаргана. Нэр дэвшигч болон шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадва-

рын талаар гаргасан мэргэшлийн хорооны дүгнэлт 6 сарын хугацаанд хүчинтэй байна.

4. Шүүгчийн мэргэшлийн хорооны даргыг гишүүдийнх нь дотроос Ерөнхий зөвлөл томилно.

5. Шүүгчийн мэргэшлийн хорооны дүрмийг Ерөнхий зөвлөл батална.»

6/49 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

«3. Шүүгч сахилгын шийтгэл ногдуулсан шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно.

4. Улсын дээд шүүх гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор түүнийг хянан шийдвэрлэнэ. Улсын дээд шүүх шүүгчийн сахилгын хорооны шийдвэрийг хянан хэлэлцээд түүнийг хэвээр үлдээх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгож сахилгын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх буюу хэргийг хэрэгсэхгүй болгон шүүгчийг цагаатгах шийдвэрийн аль нэгийг гаргана.»

7/53 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

«5. Дүүргийн шүүх, түүнчлэн аймгийн шүүхээс алслагдсан байрлалтай сум буюу сум дундын шүүхийн өдөр тутмын хэвийн ажиллах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулах үүрэгтэй шүүхийн тамгын хэлтсийн төлөөлөгчийг Ерөнхий зөвлөлийн шийдвэрээр томилон ажиллуулах буюу хавсарган ажиллуулж болно.»

8/54 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

«3. Шүүхийн тамгын газрын дарга нь үйл ажиллагаагаа Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий зөвлөлийн даргад хариуцан тайлагнана.»

9/55[1] дүгээр зүйл:

«55[1] дүгээр зүйл. Туслах шүүгч, түүний бүрэн эрх

1. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд туслах шүүгч ажиллана.

2. Туслах шүүгч нь хууль зүйн дээд боловсролтой, Монгол Улсын иргэн байна.

3. Туслах шүүгчийн орон тоо, цалингийн хэмжээг Ерөнхий зөвлөл тогтооно.

4. Туслах шүүгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62, 63, 65—69, 72, 74, 75 дугаар зүйлийн 1, 2 дахь заалт, 79, 126 дугаар зүйл, 134 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 141 дүгээр зүйл, 145 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг,

157 дугаар зүйл, 197, 200, 219 дүгээр зүйл, 225 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 226 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 228, 2229 дүгээр зүйлд заасан ажиллагааг шүүгчийн даалгавраар гүйцэтгэх;

2) Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 219 дүгээр зүйл, 222 дугаар зүйлийн 1—4, 7 дахь заалт, 223, 229, 230, 231, 233, 234, 350, 351 дүгээр зүйлд заасан байцаан шийтгэх ажиллагааг шүүгчийн даалгавраар гүйцэтгэх;

3) захиргааны зөрчилтэй хэргийн нотлох баримтын бүрдлийг хангуулах;

4) хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийг сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион;

5) хуульд заасан бусад бүрэн эрх.

5. Туслах шүүгч энэ зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2-т заасан ажиллагааг гүйцэтгэхдээ захирамж гаргах эрхтэй.

6. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 1, 2-т заасан туслах шүүгчийн бүрэн эрх нь шүүгч данган хянан шийдвэрлэх хэрэгт хамаарна.

10/64 дүгээр зүйлийн 9, 10, дахь хэсэг:

«9. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн орон сууцны хөлсийг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Улсын төсвөөс санхүүжүүлэх орон сууцны хөлсний дээд хэмжээг тухай бүр Улсын Их Хурал тогтооно.

10. Шүүгч хууль тогтоомжид заасан бусад баталгаагаар хангагдана.»

3 дугаар зүйл. Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 3, 4, 5 дахь хэсэг нэмж, 3 дахь хэсгийн дугаарыг «6.» гэж өөрчилсүгэй:

«3. Улсын дээд шүүх шүүн таслах ажлын төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Иргэний хэргийн танхим болон Эрүүгийн хэргийн танхимтай байна.

4. Танхимын бүрэлдэхүүнийг Ерөнхий шүүгчийн санал болгосноор Улсын дээд шүүх батална.

5. Танхимын тэргүүн шүүгчийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно.»

4 дүгээр зүйл. Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 11 дэх заалт нэмж, 11 дэх заалтын дугаарыг «12)» гэж өөрчилсүгэй:

«11) хууль тогтоомжийн дагуу шүүгч, шүүхийн байгууллагын ажилтнуудын зэрэг дэвийн болон бусад нэмэгдэл олгох;»

5 дугаар зүйл. Шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмж, энэ хэсгийн 3 дахь заалтын дугаарыг «4/» гэж өөрчилсүгэй;

«3) шүүгчийн албан тушаалын цалинг 3—6 сарын хугацаагаар 20 хүртэл хувиар хасах;»

6 дугаар зүйл. Энэ зүйлийн 1 дүгээр зүйлийн 10, 11, 12 дахь заалт, 2 дугаар зүйлийн 5, 6 дахь заалт, 5 дугаар зүйлийг 1994 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс, бусад зүйл, заалтыг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. «Хоёрдмол харьяаллын асуудлыг зохицуулах тухай БНМАУ, БНУАУ-ын хоорондын Хэлэлцээр»-ийг Унгарын тал цаашид дагаж мөрдөхгүй болсонтой холбогдуулан «Хэлэлцээр батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 215 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Вьентьян хотноо байгуулсан «Монгол Улс, Бүгд Найраамдах Ардчилсан Лаос Ард Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ»-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр
сарын 4-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Шинэ Дели хотноо байгуулсан «Монгол Улс, Бүгд Найраамдах Энэтхэг Улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ»-г Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулганаас 47/39 дүгээр тогтоолоор сайшаан баталж Францын нийслэл Парис хотноо 1993 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр гарын үсэг зурсан «Химийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх болон хэрэглэхийг хориглох, түүнийг устгах тухай» Конвенцийг Засгийн газраас өргөн мэдүүлснийг дагуу соёрхон батлсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1994 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 1995 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөгөөр)

Улсын төвлөрсөн төсвийн орлого -Бүгд	83605777,8
1. **Албан татварын орлого** . . .	67082228,0
1) орлогын албан татвар . . .	18904226,0
2) гаалийн албан татвар	7799678,0
3) худалдааны албан татвар . . .	10159523,0

4) онцгой албан татвар 76561338,0
5) бусад татвар 1325600,0
6) нийгмийн даатгалын шимтгэл . . 177355663,0
7) замын сангийн орлого 109116000,0
2. **Татварын бус орлого** 137235449,8
1) хувьцааны ногдол ашиг 35390552,8
2) бусад орлого 16000000,0
3) төсөвт байгууллагын өөрийн орлого . . 25644997,0
4) гадаад тусламжийн орлого . . . 60200000,0
3. **Хөрөнгийн орлого** 28000000,0
1) Өмч хувьчлалын сангийн орлого . . 28000000,0

2 дугаар зүйл. 1995 оны улсын төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, нийгмийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, Засгийн газраас тогтоосон төвлөрүүлэн захирагчийн төсвийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөгөөр)

Улсын төвлөрсөн төсвийн зарлага-бүгд . . 965091550,4
1) цалингийн сан 102285995,0
2) хөрөнгө оруулалт 73500010,0
Үүнээс: Шинээр эхлэх барилга, объектын нийт төсөвт өртөг 27288000,0
Үүний дотор 1995 онд санхүүжүүлэх хэмжээ 2802000,0
3) нийгмийн ерөнхий үйлчилгээний зардал 3979038,4
4) батлан хамгаалах арга хэмжээний зардал 9050867,6
5) Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын төсөв 62390,0
6) Монгол Улсын Их Хурлын төсөв . . . 237300,0
7) Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн төсөв 9740,0
8) шүүхийн төсөв 456760,8
9) Прокурорын төсөв 232371,4
10) Тагнуулын төв газрын төсөв 515804,6
11) Тэтгэврийн даатгалын санд олгох татаас 6000006,6
12) аймгийн төсөвт өгөх татаас 13481121,7

3 дугаар зүйл. Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар хуваарилан тогтоосугай:

(мянган төгрөгөөр)

Архангай	1059805,7
Баян-Өлгий	1092873,8
Баянхонгор	977831,2
Булган	314593,4
Говь-Алтай	885066,7
Дорноговь	607804,4
Дорнод	206539,4
Дундговь	712942,9
Завхан	1172450,7
Өвөрхангай	570883,7
Өмнөговь	654531,9
Сүхбаатар	958719,7
Сэлэнгэ	125344,3
Увс	961079,6
Ховд	1050657,6
Хөвсгөл	1284775,4
Хэнтий	845221,3

Монгол Улсын Их Хурлын
Дэд дарга **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 77

В. АЛЗАХГҮЙГ БАЙНГЫН ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Вандангийн Алзахгүйг Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 1994 оны 11 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 79

ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ ДАРГА, ЗАРИМ ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Жигжидсүрэнгийн Ядамсүрэнг Үнэт цаасны хорооны даргаар, Долгормаагийн Буянтогтох, Данзанбалжирын Энхжаргал нарыг тус хорооны гишүүнээр тус тус томилсугай.

2. Энэ тогтоолыг 1994 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1994 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 1995 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны Үндсэн чиглэлийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1995 оны Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 1995 оны гуравдугаар улиралд Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Дэд дарга **Ж. ГОМБОЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 1995 ОНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	2	3	4
1. Үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт идэвхжих орчин бүрдүүлэхэд чиглэсэн санхүү, мөнгө, үнэ, ханшны харилцан уялдаатай бодлогыг хэрэгжүүлнэ	**I. Макро эдийн засгийн бодлогын талаар:**		
	— Эдийн засаг дахь мөнгөний эрэлт, нийлүүлэлтийг оновчтой зохицуулан удирдах, банкны систем дэх дотоодын цэвэр активын нийт хэмжээг оны эцэст 70,5 тэрбум төгрөгөөс хэтрүүлэхгүй байлгах.	Жилдээ	Д. Даваасамбуу Ч. Улаан Д. Моломжамц
	— Төрийн болон төрийн өмчийн оролцоо бүхий аж ахуйн нэгж, байгууллагын ашиг орлого, цалингийн сан, валютын нөөц, хөрөнгө оруулалтын зарцуулалт, ашиглалтад тавих хяналтыг чангатган нэгдсэн бодлогод захируулах	Оны эхнээс	Э. Гомбожав Д. Даваасамбуу Ч. Улаан Д. Моломжамц
	— Үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх зорилгоор инфляцийн түвшинтэй уялдуулан зээлийн болон хадгаламжийн хүүг үян хатан уялдаатай тогтоох	—"—	Д. Моломжамц Д. Даваасамбуу Ч. Улаан

1	2	3	4
2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтвортой байлгана	— Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж эдийн засгийн дотоод чадавхийг сайжруулах, экспортоос орох валютын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар гадаад валютын эрэлт нийлүүлэлтийг тэнцүүлэх, валютын захын үйл ажиллагааг боловсронгуй болгох.	—"—	Д. Моломжамц Д. Даваасамбуу
3. Гадаад валютын цэвэр нөөцийг нэмэгдүүлэн төлбөрийн тэнцлийг сайжруулна	— Гадаад валютын цэвэр нөөцийг 6 долоо хоногийн импорттой тэнцэх хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх, хугацаа хэтэрсэн гадаад өрийг барагдуулах, экспортыг 390 сая ам. долларт хүргэх.	Оны эхнээс	Д. Моломжамц Д. Даваасамбуу Ц. Цогт
4. Төсвийн баазыг өртөжүүлж, орлогыг нэмэгдүүлнэ	— Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн ногдол ашиг, төрийн өмч худалдсаны орлогыг төсөвт төвлөрүүлэх, аж ахуйн нэгжүүдийн төсөвтэй харьцах харьяаллын асуудлыг дахин авч үзэж боловсронгуй болгох	Жилдээ	Д. Даваасамбуу
	— Аж ахуйн нэгжүүдэд үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх замаар татварын баазыг өргөтгөх, онцгой болон худалдааны татварын хэмжээ, хамрах хүрээг **өргөжүүлэх**	1 дүгээр улирлаас	Д. Даваасамбуу Ц. Цогт, Ц. Өөлд Р. Сандалхаан, Аймаг, нийслэлийн Засаг дарга

1	2	3	4
	— Худалдааны албан татварыг боловсруулах үйлдвэрүүдийн эцсийн бүтээгдэхүүнд ногдуулах асуудлыг судалж, шийдвэрлэх	—"—	Д. Даваасамбуу Ц. Цогт Н. Өлзийхутаг
5. Төсвийн зарлагын бүтцийг оновчтой болгож, зарцуулалтүр өгөөжийг дээшлүүлэх замаар төвлөрсөн төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувиас хэтрүүлэхгүй байлгана	— Удирдлага, боловсрол, эрүүл мэнд, соёл, батлан хамгаалах салбарт бүтцийн өөрчлөлт хийх замаар зардал хямдруулах, үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авах	1 дүгээр улиралд	П. Нямдаваа Ж. Жадамбаа Н. Энхбаяр Д. Даваасамбуу Э. Гомбожав Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Улсын төсвийн болон банкны зээлээр санхүүжих хөрөнгө оруулалтын ашиглалт, санхүүжилтэд төрөөс тавих хяналтын оновчтой механизм бий болгох	—"—	Д. Даваасамбуу Ч. Улаан Д. Моломжамц Р. Сандалхаан
6. Өмч хувьчлалыг эрчимжүүлж, хувьчлалын хоёр дахь шатны зорилтыг хэрэгжүүлнэ	— Үнэт цаасны хоёрдогч зах зээлийг нээн ажиллуулах, төсөл шалгаруулах замаар бэлэн мөнгөөр худалдан хувьчлах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх	—"—	Л. Энэбиш Д. Даваасамбуу
	— Орон нутгийн нүүрсний уурхай, эрчим хүчний үйлдвэрийг хувьчлах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх		Л. Энэбиш Б. Жигжид Аймаг, нийс-

1	2	3	4
		—"—	лэлийн Засаг дарга нар
	— Орон сууц хувьчлах хууль боловсруулан батлуулж, хөтөлбөр гаргаж, хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг хангах	1 дүгээр улирлаас	Л. Энэбиш
	— Ижил үйлчилгээтэй эрүүл мэндийн олон байгууллага бүхий томоохон хот, суурин газарт зарим эмнэлэг, эмийн сан, үйлчилгээний бусад цэг салбарыг хувьчлах боломжийг судалж хэрэгжүүлж эхлэх	1 дүгээр улирлаас	Л. Энэбиш П. Нямдаваа
	— Төрийн нөөлд байх театр, чуулга, музейнээс бусад урлагийн байгууллагыг хувьчлах арга хэмжээг ээлж дараатайгаар хэрэгжүүлэх	—"—	Н. Энхбаяр
7. Төрийн өмчийн оролцоот аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг чангатгахын хамт төрийн төлөөллийн тогтолцоог бүрдүүлж зүгшрүүлнэ	— Төрийн өмчийн болон түүний оролцоотой үйлдвэр, аж ахуйн нэгжийн удирдлага, зохицуулалт, хяналтад өмчийн төлөөллөөрөө дамжуулан оролцож байх, хувьцаат компаниудын үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, төрөөс оролцож дэмжлэг үзүүлэх механизм бий болгон хэвшүүлэх	—"—	Д. Даваасамбуу, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Арилжааны банкуудын дүрмийн сан		

1	2	3	4
	дахь төрийн өмчийн оролцоог тогтоож, төлөөллийн механизмыг бий болгон зүгшрүүлэх	—"—	Д. Даваасамбуу Д. Моломжамц
	— Арилжааны зарим банкны тогтолцоонд бүтцийн өөрчлөлт оруулах, Засгийн газрын банкны үйл ажиллагааг сайжруулах, шинээр банк байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх	1—2 дугаар улиралд	Д. Моломжамц Д. Даваасамбуу Ч. Улаан
8. Зах зээлийн харилцааны эрх зүйн үндсийг бүрдүүлнэ	— Эрх зүйн шинэчлэлийн эхний шатыг дуусгахад чиглэгдсэн иж бүрэн арга хэмжээ авах	Жилдээ	Н. Лувсанжав
	— Эрх зүйн сургалт, сурталчилгааны үр дүнтэй механизм бий болгох	—"—	Н. Лувсанжав
9. Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх нөхцөл бүрдүүлнэ	— Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалыг батлуулж, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх асуудлыг бүсийн хүрээнд шийдвэрлэж байх	2 дугаар улиралд	Ч. Улаан
	II. Үндэсний үйлдвэрлэлийг идэвхжүүлэх талаар:		
10. Үндэсний үйлдвэрлэлийг идэвхжүүлэн, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг	— Улсын төсвийн болон банкны зээлээр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийг дэд бүтэц, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой төслүүдэд зориулж үйлдвэр-	Оны эхнээс	Ч. Улаан Д. Даваасамбуу

1	2	3	4
өмнөх оныхоос 3,0-аас доошгүй хувиар өсгөх нөхцөл бүрдүүлнэ	лэл үйлчилгээ өргөжих нөхцөл бүрдүүлэх		Д. Моломжамц Ц. Цогт
	— Инфляцийн төвшинтэй уялдуулан банкны зээлийн хүүг уян хатан тогтоож тодорхой зориулалттай, хөнгөлөлттэй зээлийн тусгай сан бий болгож үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх, хүн амын хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжийг сайжруулах, ажлын нэмэгдэл байр бий болгоход чиглэсэн үр ашигтай төсөл, арга хэмжээг тэргүүн ээлжинд зээлжүүлэх	Оны эхнээс	Д. Даваасамбуу Д. Моломжамц Ц. Цогт Ц. Өөлд
	— Газар тариалангийн үйлдвэрлэлийн удирдлага, дотоод зохион байгуулалтыг сайжруулахын зэрэгцээ гурилаар өөрийн хэрэгцээг хангах зорилгоор түүхий эд, сэлбэг, шатахуун, техник худалдаж авахад зориулсан зээлийн санг арилжааны банкуудад бий болгох.	1 дүгээр улриласс	Д. Даваасамбуу Д. Моломжамц Ц. Өөлд
	— «Улаанбуудай» хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх улаанбуудайн улсын нөөцийг бүрдүүлэх, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглагдах зээлийн тусгай санг байгуулах асуудлыг шийдвэрлэж хэрэгжүүлэх	—"—	Ц. Өөлд Д. Даваасамбуу Д. Моломжамц

1	2	3	4
	— Мал аж ахуйн гаралтай гол түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийж экспортод гаргах эдийн засгийн механизм бий болгох, түүхий эдийг олон улсын жишигт тохирсон чанар, стандартын дагуу бэлтгэж, чөлөөт валютаар экспортлох эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх	Оны эхнээс	Ц. Цогт Д. Даваасамбуу Ц. Өөлд
	— Импортоор оруулж байгаа техник, тоног төхөөрөмжид ногдох гаалийн татварын хөнгөлөлтийг тэдгээрийг суурилуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа эхлүүлэх хугацаатай уялдуулан ялгавартай тогтоох	Оны эхнээс	Д. Даваасамбуу Ц. Цогт
	— Экспортын үйлдвэрлэлд зориулан импортолж байгаа арьс шир, ноос, ноолуурыг импортын гаалийн татвараас хөнгөлөх	—"—	Д. Даваасамбуу Ц. Цогт
	— Үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газраас 3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдийн дунд тендер зарлах журмаар худалдан авах	—"—	Ц. Цогт Р. Сандалхаан Ц. Өөлд
	— «Хүн амын хөөл тэжээл» хөтөлбөр, хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөтгөхөд чиглэгдсэн төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.	1 дүгээр улирлаас	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар

1	2	3	4
	— Сүү, гахай, шувууны аж ахуй, цөцгийн тосны үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх	—"—	Ц. Өөлд Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Мал эмнэлгийн арга хэмжээнд зарцуулж байгаа хөрөнгийн өгөөжийг дээшлүүлж ашиглалтад тавих хяналтыг сайжруулах замаар малын өвчлөлтийг бууруулах	—"—	Ц. Өөлд Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— «Алт» хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, олборлолтыг 60 хувиар нэмэгдүүлэх, алт олборлолт явуулах аж ахуйн нэгжүүдэд тавигдах шаардлагыг өндөрсгөн, өрсөлдүүлэх механизм бий болгох, томоохон орц газарт хүч хөрөнгийг төвлөрүүлэх	2 дугаар улирлаас	Б. Жигжид
	— Газрын тосны судалгааны ажлыг эрчимжүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, ТЭЗҮ боловсруулан, түүний үр дүнг харгалзан туршилтын олборлолт эхлэх	Жилдээ	Б. Жигжид
11. Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж,	— Уурхайнуудын хүч чадлын эзэмшилтийг ахиулах, техникээр сэлбэн тоноглоход хандивлагчдын зээл, тусламжийг ашиглан дэмжлэг үзүүлэх, нүүрсний уурхайнууд, Төвийн эрчим		

1	2	3	5
найдвартай ажиллагааг хангах арга хэмжээ авна	хүчний системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах	—"—	Б. Жигжид
	— Улаангом, Өлгий, Ховд хотуудыг ОХУ-ын эрчим хүчний системд, Мандалговийг Төвийн эрчим хүчний системд холбох, Завхан аймгийн Богд голын УЦС-ыг ашиглалтад оруулах	3 дугаар улиралд	Б. Жигжид
	— Баянмөнх-Өндөрхааны өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам барих ажлыг эхлүүлэх, Арвайхээр-Баянхонгор, Чойбалсан-Баруун Уртынхыг барих ажлын бэлтгэлийг хангах	Жилдээ	Б. Жигжид
	— Улсын төвлөрсөн төсвийн татаасын хэмжээнд багтаан орон нутгийн эрчим хүчний үйлдвэрүүдийг алдагдалгүй, жигд ажиллуулах, салбарын болон орон нутгийн хүч, хөрөнгийг ашиглан бэлтгэл хангагдсан зарим сум, суурин газрыг цахилгаан дамжуулах төвлөрсөн эх үүсвэрт холбох	Жилдээ	Б. Жигжид Аймгийн Засаг даргынар
	— Бага оврын усан болон салхин цахилгаан станц байгуулах, нарны батарей ашиглах үндсэн дээр орон нутгийн эрчим хүчний хангамжийг сайжруулах, малчдыг гэрэл, цахилгаантай болгоход чиглэгдсэн арга	1 дүгээр улирлаас	Б. Жигжид Аймгийн Засаг даргынар

1	2	3	4
	хэмжээг авах — Таван толгойн коксжих нүүрсний ордыг ашиглах, ТЭЗҮ боловсруулах бэлтгэл судалгааны ажлыг эрчимжүүлэх	Жилдээ	Б. Жигжид
12. Зам, тээвэр, холбооны салбарт техникийн шинэчлэлийг үргэлжлүүлж үйлчилгээг сайжруулна	— Төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, Буянт-Ухаагийн нисэх буудлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлэх, Замын-Үүдийн төмөр замын шилжүүлэн ачих байгууламжийн II ээлжийг ашиглалтад оруулах	Оны эхээс	Р. Сандалхаан
	— Гадаадын зээл, тусламжийн дэмжлэгтэйгээр нийслэлийн автобус, тролейбусны паркийн 20-иос доошгүй хувийг шинэчлэх	—"—	Р. Сандалхаан Нийслэлийн Засаг дарга
	— Авто замыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу Улаанбаатар-Чойрын чиглэлийн хатуу хучилттай авто замын техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлыг дуусгаж барилгын ажлыг эхлүүлэх	Оны эхээс	Р. Сандалхаан
	— Өвөрхангай-Баянхонгорын чиглэлийн хатуу хучилттай зам барих ажлыг үргэлжлүүлэх	—"—	Р. Сандалхаан
	— Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудыг холбосон тоон техноло-		

1	2	3	4
	гийн радио релейний шугам болон электрон АТС, кабель шугам тавих төслийг хэрэгжүүлж эхлэх	—"—	Р. Сандалхаан
13. Хэмнэлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, зохистой хэрэглээг хэвшүүлэх, тэдгээрт төрөөс нөлөөлөх хяналт тавих механизм бий болгоно	— Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн эзэмшилд байгаа барилга, байгууламжуудад үзлэг хийж, зардал хэмнэх зорилгоор ачааллыг нягтруулах чөлөөлөгдсөн байрны өмчлөлт, ашиглалтын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх	1 дүгээр улирлаас	Д. Даваасамбуу
	— Эрчим хүчний хэмнэлтийн судалгааг дуусгах хэрэглэгчид болон цахилгаан, дулааны эрчим хүчний алдагдлыг багасгах төслийг хэрэгжүүлж эхлэх	Жилдээ	Б. Жигжид
	— Хот суурины ус хангамжийн шугамын алдагдлыг багасгах, хэрэглээг оновчтой болгоход чиглэгдсэн арга хэмжээ авах	—"—	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Холбоо хэрэглэгчдийг тоолууржуулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх	1 дүгээр улирлаас	Р. Сандалхаан
14. Аялал, жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлно	— Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж жуулчны байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	2 дугаар улиралд	Ц. Цогт

1	2	3	4
	III. Шинжлэх ухаан, технологийн талаар:		
15. Шинжлэх ухааны салбарыг захзээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх эрхзүйн үндсийг бүрдүүлж, судалгаа, туршилшилтын ажлын үр дүнг дээшлүүлнэ	— Шинжлэх ухааны салбарын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт хийж шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын үзэл баримтлалыг батлуулж, судалгаа, технологийн тэргүүлэх чиглэлийн дагуу улсын төсвийн хөрөнгийг тэргүүн ээлжийн цөөн тооны төсөлд төвлөрүүлэх	Оны эхнээс	Н. Өлзийхутаг
	— 90-ээд төслийн судалгааг дуусгаж, үр дүнг нь үйлдвэрлэлд нэвтрүүлэх, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр хийх судалгааны ажлыг өргөжүүлж төслийн 20-иос доошгүй хувийг холбогдох аж ахуйн нэгжтэй гэрээлэх замаар санхүүжүүлэх	—"—	Н. Өлзийхутаг Д. Даваасамбуу
	— Дэвшилт техник, технологийг нэвтрүүлэх ажлыг урамшуулах механизм бүрдүүлж, түүнд хяналт тавих тогтолцоо бий болгох	—"—	Н. Өлзийхутаг Д. Даваасамбуу
16. Бага оврын техник тоног төхөөрөмж угсрах шинэ технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх аж-	— Бага оврын телевизор, радио хүлээн авагч, хуурай зай, сателлит антенн үйлдвэрлэн нийлүүлж малчдыг телевизжүүлэх, радиожуулахад чиглэгдсэн арга хэмжээг өргөжүүлэх	Жилдээ	Ц. Өөлд Аймгийн Засаг дарганар
	— Тэсрэх бодис үйлдвэрлэх технологи		

1	2	3	4
лыг өргөжүүлнэ	эзэмшиж дотоодын хэрэгцээг хангах	—"—	Б. Жигжид
	— Алслагдсан зарим сумдын эмнэлэг, сургуулийг нар, салхины эрчим хүч ашиглан гэрэлтүүлэх туршилтыг өргөжүүлэх	—"—	П. Нямдаваа Н. Өлзийхутаг
	— Уян дуран ашиглан мэс засал хийх, цус шүүж хордлого тайлах зэрэг шинэ арга, технологийг эмнэлгийн практикт нэвтрүүлэх	—"—	П. Нямдаваа Н. Өлзийхутаг
17. Экологи, байгаль орчныг хамгаалахад төр, олон нийт, иргэдийн хяналтыг хүчтэй болгох арга хэмжээ авна	— Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиудыг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	—"—	З. Батжаргал Н. Лувсанжав
	— «Монгол Улсын экологийн хөтөлбөр»-ийн төсөл боловсруулах, 4000 га талбайг ойжуулах, хортон, түймрээс хамгаалах, мод бэлтгэлийн хэмжээг багасгах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх арга хэмжээ авах	—"—	З. Батжаргал
	— Тариалалт хийгдэхгүй орхигдсон болон элэгдэл орсон талбайг олон наст ургамал тариалан, атаршуулан бэлчээрт шилжүүлэх, сайжруулах арга хэмжээ авах	Жилдээ	Ц. Өөлд З. Батжаргал
	— Тариалангийн талбайг иргэд, аж ахуйн нэгжид эзэмшүүлэх арга хэмжээ авах	—"—	Ц. Өөлд

1	2	3	4
	— Багахангай, Багануур, Даланзадгадын бохир усны цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Их тэнгэрийн цогцолборынхыг эхлүүлж байгальд хаягдаж буй бохир усны хэмжээг багасгах	—"—	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	IV. Нийгмийн бодлогын талаар:		
18. Боловсролын салбарын бүтцийг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх ажлыг эрчимжүүлнэ	— Монгол улсад боловсролыг хөгжүүлэх төрийн бодлогын үндсийг тодорхойлж, «Боловсрол, хүний хүчин зүйл» ерөнхий төлөвлөгөөний хүрээнд холбогдох төслийн судалгааг дуусгаж, тодорхой төслүүдийг хэрэгжүүлж эхлэх	—"—	Н. Өлзийхутаг
	— Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн материаллаг баазыг түшиглүүлэн жижиг үйлдвэрлэл зохион байгуулж орлогоороо зарлагаа нөхөх зарчим дээр ажиллах	—"—	Н. Өлзийхутаг
	— Боловсролын салбарын санхүүжилтийг зах зээлийн нөхцөлд зохицуулан өөрчлөн зохион байгуулна	—"—	Н. Өлзийхутаг Д. Даваасамбуу
19. Хүн амын эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээм-	— Нялхсын эндэгдлийг улсын хэмжээнд өмнөх 5 жилийн дунджаас 20 хувиар бууруулж, 1000 төрөлтөд (амьд) 50-иас дээшгүй хэмжээнд		П. Нямдаваа Аймаг, нийс-

1	2	3	4
жийг дээш-лүүлнэ	байлгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Жилдээ	лэлийн Засаг дарга нар
	— Эсэн мэнд амаржихуйн үндэсний бодлогыг тодорхойлж, аймаг, сумдын эхчүүдийн төрөхийн өмнөх амрах байрыг сэргээн ажиллуулах, төрөх насны эмэгтэйчүүдэд тавих эмнэлгийн хяналтыг сайжруулах, эх барихын тусламжийг чанаржуулах	—"—	П. Нямдаваа Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Сумдын эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авах	—"—	П. Нямдаваа Ч. Улаан Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Дархлалын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, өргөн вакцинжуулалтад хамрагдах гол гол өвчний гаралтыг бууруулах, татран, халдварт саа, сахуу өвчний тохиолдлыг гаргахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх	—"—	П. Нямдаваа Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Иодын дутагдалтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж эхлэх	—"—	—"—
20. Эрүүл мэндийн байгууллагуудын эдийн зас-	— Өөрийн орны нөхцөлд тохирсон эрүүл мэндийн анхан шатны тусламжийн иж бүрдлийн нормативыг үйлчилгээ-		

1	2	3	4
гийн болон анагаах ухааны үйл ажилла-гааны үр дүнг дээшлүүлнэ	ний шатлалаар тогтоон нэг иргэнд ногдох зардлаар төсвийг төлөвлөх журамд шилжих	3 дугаар улиралд	П. Нямдаваа Д. Даваасамбуу
	— Нэг удаа хэрэглэх зүү, тариурын болон уламжлалт эмийн жижиг үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх	Жилдээ	П. Нямдаваа
	— Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх мэргэжлийн боловсон хүчний хангалтийг сайжруулах	—"—	П. Нямдаваа
	— Сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлтийн практик үйл ажиллагааны нэгдлийг хангах бүтэц, зохион байуулалтын өөрчлөлт хийх	—"—	П. Нямдаваа Н. Өлзийхутаг
21. Хүн ам, зүйн талаар баримтлах төрийн бодлогыг тодорхойлж хүн амын өсөлтийн хандлагыг хадгалах нөхцөл бүрдүүлнэ	— Монгол улсын хүн амын бодлогын үзэл баримтлалыг боловсруулан, хэрэгжүүлж эхлэх	2 дугаар улиралд	Э. Гомбожав
	— Иргэдийн овог сэргээх, ургийн бичиг хөтлүүлэх ажлыг зохион байгуулах	жилдээ	Э. Гомбожав
22. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дээш-	— Хүн амын хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ажлын шинэ байр бий болгоход		

1	2	3	4
лүүлж, ажил идэвхтэй эрж байгаа хүмүүсийн ажилгүйдлийг хөдөлмөрийн нөөцийн 5 хувиас хэтрүүлэхгүй байх	чиглэгдсэн үр ашигтай төслүүдийг дэмжин хэрэгжүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо тариалах арга хэмжээг өргөжүүлж ажлын байр шинээр бий болгох, зам байгуулах, орон сууц барих ажил эхлүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах асуудлыг судалж шийдвэрлэх	Оны эхнээс	Ч. Улаан Э. Гомбожав Д. Моломжамц Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— «Ажил эрхлэлтийн сан»-г гадаадын тусламжтайгаар өргөтгөж хувиараа хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх	жилдээ	Э. Гомбожав
	— Хөдөлмөр эрхлээгүй хүн ам, ажилгүйчүүдийн талаар үзлэг явуулж, шалтгааныг судлан тогтоох, ядуурлын шалгуур үзүүлэлтүүдийг Монголын онцлог нөхцөлд тохируулан боловсруулж, түүний дагуу ядуурлын төвшинг тогтоож, түүнийг бууруулах арга хэмжээ авах	2 дугаар улиралд	Э. Гомбожав Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Нийгмийн чиглэлтэй буюу ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх хөрөнгийг Засгийн газрын банкаар дамжуулан хэрэгжүүлэх	1 дүгээр улирал	Д. Даваасамбуу Э. Гомбожав
	— Аймаг, нийслэлийн Засаг дарга нарыг нөөц бололцоогоо дайчлан ажил-		

1	2	3	4
	гүйдлийг бууруулах тодорхой даалгавартай ажиллуулах	1 дүгээр улиралд	Д. Даваасамбуу Э. Гомбожав
	— Өмч хувьчлалын сангийн орлогын 30 хүртэлх хувийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн эмзэг хэсгийн хөдөлмөрийн чадвартай иргэдийг ажлаар хангах, иргэдийн орон сууцны барилга барих, арга хэмжээний баталгаат эх үүсвэр болгох	—"—	Л. Энэбиш Д. Даваасамбуу
23. Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, туйлын ядуурлыг бууруулж, ажил эрхлэх боломжтой ядуучуудын 20 хувийг хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдүүлнэ	— Ядуурлыг бууруулахад хүний хүчин зүйлийг идэвхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төслүүдийг Дэлхийн банк, АХБ, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, АНУ, хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжүүлж эхлэх	Оны эхнээс	Э. Гомбожав Ч. Улаан Ц. Цогт
	— Хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ядуу хүмүүсийг малжуулах арга хэмжээ авч өрхийн аж ахуй эрхлэх арга барилд сургах	—"—	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Ядуурлыг бууруулах сангуудыг нэгдсэн тогтолцоонд оруулах, сангийн удирдлагыг олон нийтийн төлөөлөлтэй болгох арга хэмжээ авах	—"—	Э. Гомбожав Д. Даваасамбуу
24. Хүн амд төрөөс үзүүлэх нийгмийн халамжийн тогтолцоо-	— Монгол улсын нийгмийн халамжийн тухай хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих	Оны эхнээс	Э. Гомбожав
	— Завхан, Сүхбаатар аймгийн төв,		

1	2	3	4
ны эрх зүйн үндсийг бий болгож, нийгмийн хамгаалын тогтолцоог зүгшрүүлнэ	нийслэлийн зарим дүүргийн халамжийн төв байгуулж, нийгмийн эмзэг хэсгийн хүмүүст үзүүлэх халамжийн хүрээг өргөтгөх	Жилдээ	Э. Гомбожав Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	— Амьжиргааны баталгаажих доод түвшинг үнэ, тарифын өсөлттэй уялдуулан шинэчлэн тогтоож, түүнийг хангах, оюутан сурагчдад тээврийн хөлсний хөнгөлөлт үзүүлэх	—"—	Э. Гомбожав Д. Даваасамбуу
	— Оны эхнээс төсөвт байгууллагын ажиллагчдын цалинг 25 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг дунджаар 30 хувь нэмэгдүүлэх арга хэмжээ авах	1 дүгээр улирлаас	Э. Гомбожав
	— Цаашид бүтцийн өөрчлөлт хийх, хэмнэлт гаргах замаар төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг судалж Улсын Их Хуралд танилцуулах	1 дүгээр улирлаас	Э. Гомбожав
	— Төрийн албаны тухай хуулийг батлуулж төсөвт байгууллагад ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулах талаар арга хэмжээ авах	—"—	Л. Энэбиш Э. Гомбожав
5. Соёл урлагийн талаар төрөөс баримтлах бод-	— Соёл, урлагийн салбарын санхүү-жилтийн төсвийн болон бусад эх үүсвэрийн зохистой харьцааг тогтоох		

1	2	3	4
логыг тодорхойлж, соёл урлагийн байгууллагуудын санхүүжилтийн оновчтой арга хэлбэрийг тогтооно	үндсэн дээр санхүүжилтийн оновчтой хэлбэрийг тогтоох	2 дугаар улирлаас	Н. Энхбаяр Д. Даваасамбуу
	— Соёл, урлагийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулан төрийн ивээлд байх нэгжийг тогтоох	—"—	Н. Энхбаяр Д. Даваасамбуу
	— Радио, телевизийн байгууллагад сурталчилгаа, үйлчилгээний орлогоороо зардлаа нөхөх хэмжээг нэмэгдүүлэх	1 дүгээр улирлаас	Д. Даваасамбуу Б. Өвгөнхүү
26. Батлан хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжуудыг биелүүлэх батлан хамгаалах үйл ажиллагаа, зэвсэгт хүчин, бусад цэргийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ	— Хилийн цэргийн бие бүрэлдэхүүний тоог нэмэгдүүлж хил хамгаалалтыг бэхжүүлэх, хилийн мөр хянах зурвас, торон саадыг сэргээх	—"—	Ш. Жадамбаа П. Сүндэв
	— Хилчдийн уналгыг нэмэгдүүлэх, зарим салбаруудын цахилгаан хангамжийг сайжруулж, үндэсний нэвтрүүлэг үздэг болгох	—"—	Ш. Жадамбаа П. Сүндэв
	— Зэвсэт хүчин, хилийн цэргийн зарим техникийг сэргээн засварлах, хураагууруудын тодорхой хэсгийг шинэчлэх, бие бүрэлдэхүүний хувцас, хүнсний хангамжийг сайжруулах	Жилдээ	Ш. Жадамбаа
27. Хүн амын боловсрол, үндэсний удирдлагын чадавхийг дээшлүүлнэ	— Үндэсний удирдлагын чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр, техникийн туслалцааны хамтын ажиллагааны хүрээнд улсын болон хувийн секторт		

1	2	3	4
	ажиллагчдыг шинээр бэлтгэх, давтан сургах арга хэмжээ авах	Жилдээ	Л. Энэбиш Н. Лувсанжав Б. Пүрэв
8. Нийгмийн дэг журмыг хангаж ард түмний амгалан тайван аж төрөх эрхийг баталгаажуулахыг чухалчилна	— Нийгэмд сахилга, дэг журмыг бэхжүүлэх хууль тогтоомжийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг сайжруулах	—"—	Аймаг, нийслэлийн Засаг дарга
	— Шүүх, прокурор болон хуулийн бусад байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах боломцоог бүрдүүлэх, тэдгээрийн материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчний хангалтыг сайжруулах	—"—	Н. Лувсанжав Д. Даваасамбуу

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

ЗАРИМ АХМАД ДАЙЧДЫГ ШАГНАХ ТУХАЙ

1939 оны Халхын голын байлдаанд оролцон эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан эрэлхгээр байлдаж явсныг тэмдэглэж Халх голын ялалтын 55 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан ахмад дайчдыг одонгоор шагнасугай.

Нэг. **Сүхбаатарын одонгоор:**

1. Жамъянгийн Зундуй — Нийслэлийн Баянгол дүүргийн 13-р хорооны иргэн
2. Гэндэнгийн Дорж — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7-р хорооны иргэн
3. Балдангийн Дэмчиг — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4-р хорооны иргэн

Хоёр. **Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор**

1. Дэмчигийн Жамъян — Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4-р хорооны иргэн
2. Гэмпилийн Мунахүү — Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2-р хорооны иргэн
3. Цэвээний Гэндэн — Хэнтий аймгийн Дадал сумын иргэн
4. Гэндэнгийн Дарьсүрэн — Архангай аймгийн Хайрхан сумын иргэн
5. Ганжуурын Тогтох — Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 3-р хорооны иргэн
6. Жавхүүгийн Гомбо-Очир — Нийслэлийн Хан-Уул дүүрдүүргийн 5-р хорооны иргэн

Гурав. **Цэргийн гавьяаны одонгоор:**

1. Даваагийн Пүрэв — Увс аймгийн Зүүнговь сумын иргэн
2. Нямтарын Балдан — Нийслэлийн Баянзүрх дүүргийн 13-р хорооны иргэн
3. Гэлэгийн Паламдорж — Нийслэлийн Баянзүрх дүүргийн 18-р хорооны иргэн
4. Цоожийн Дээд — Өмнөговь аймгийн Баяндалай сумын иргэн
5. Лонхын Лхагважав — Хөвсгөл аймгийн Цагаannуур сумын иргэн
6. Чадраабалын Шарав — Нийслэлийн Баянгол дүүргийн иргэн
7. Гэндэнгийн Пүрэв — Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын иргэн
8. Насангийн Баатарчулуун — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2-р хорооны иргэн
9. Балжидын Ерөөлт — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5-р хорооны иргэн
10. Учралтын Чойсүрэнжав — Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5-р хорооны иргэн
11. Мажигийн Данзанням — Дорнод аймгийн Матад сумын иргэн
12. Баримидын Банзрагч — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5-р хорооны иргэн
13. Пэрэнлэйн Самдан — Нийслэлийн Хан-Уул дүүргийн 2-р хорооны иргэн
14. Галтмаагийн Бэхбат — Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1-р хорооны иргэн
15. Жигжиджавын Дагва-Осор — Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 6-р хорооны иргэн
16. Ермолаев Георгий Александрович — Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4-р хорооны иргэн

17. Жамбалдоржийн Ринчин — Завхан аймгийн Ургамал сумын иргэн

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Г. ГАНБОЛДЫГ АЛТАН ГАДАС ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Монголын залуучуудын байгууллагад үр бүтээлтэй ажиллаж оюутан, залуучуудын дунд зохиогдсон олон чухал арга хэмжээг чадамгай зохион байгуулж, залуучуудын байгууллагыг шинэ нөхцөлд төлөвшүүлэн бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын залуучуудын холбооны зөвлөх Галсангийн Ганболдыг Алтан гадас одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

ЗАРИМ АХМАД ДАЙЧДЫГ ШАГНАХ ТУХАЙ

1939 оны Халхын голын байлдаанд оролцон эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалан эрэлхгээр байлдаж явсныг тэмдэглэж Халх голын ялалтын 55 жилийн ойг тохиодуулан дор дурдсан ахмад дайчдыг одонгоор шагнасугай.

Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор

1. Чадраабалын Янсанжав — Говь-Алтай аймгийн Цогт сумын иргэн
2. Ерэнтэйн Цэдэн-Иш — Дорнод аймгийн Чойбалсан сумын иргэн

Цэргийн гавьяаны одонгоор

1. Раднаагийн Галданжамц — Булган аймгийн Булган сумын иргэн
2. Луузангийн Цэд-Очир — Өвөрхангай аймгийн Тарагт сумын иргэн
3. Нурмаагийн Жамъянхорлоо — Дорноговь аймгийн Мандах сумын иргэн
4. Зэвэгийн Сэдбал — Нийслэлийн Багануур дүүргийн иргэн
5. Ваанчигийн Чилхаасүрэн — Сүхбаатар аймгийн Асгат сумын иргэн
6. Чимидийн Дамиран — Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын иргэн
7. Бат-Очирын Доржсүрэн — Ховд аймгийн Жаргалан сумын иргэн
8. Дамбын Наваан — Нийслэлийн Багахангай дүүрийн 1 хорооны иргэн
9. Рэндоогийн Ёндоншарав — Баянхонгор аймгийн Баянхонгор сумын иргэн
10. Бямбажавын Рагчаа — Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 хорооны иргэн

11. Пагамын Гэндэнжамц	— Өмнөговь аймгийн Даланзадгад сумын иргэн
12. Түдэвийн Жигжидсүрэн	— Нийслэлийн Сүхбаатар дүүргийн IV хорооны иргэн
13. Идшингийн Лувсан-Иш	— Хэнтий аймгийн Өмнөговь сумын иргэн
14. Пунцагийн Норов	— Ховд аймгийн Алтай сумын иргэн
15. Амгалангийн Нацаг	— Дорноговь аймгийн Зүүнбаян сумын иргэн
16. Жамбалын Пүрэвжав	— Завхан аймгийн Алдархаан сумын иргэн
17. Шагдарын Баасанжав	— Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн
18. Гомбосүрэнгийн Найданжав	— Нийслэлийн Баянзүрх дүүргийн иргэн

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар Улаанбаатар

Дугаар 99

сарын 22-ны өдөр хот

Л. ГҮНСЭНД МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ОЛГОХ ТУХАЙ

Монголын радиод олон жил үр бүтээлтэй ажиллаж ирсэн, улс төрийн амьдралд гарч байгаа үйл явдлыг олон түмэнд шуурхай мэдээлэн сонсогчдын талархал хүлээж радиогийн урын санг баяжуулсан олон найруулал, нийтлэл бичин нийтийн хүртээл болгож радиогийн гол редакци албадыг зохион байгуулж бэхжүүлэх, боловсон хүчнийг сургаж дад-

лагажуулахад оруулсан хувь нэмрийг үнэлж Монголын радиогийн тоймч, сэтгүүлч Лувсандоогийн Гүнсэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар Улаанбаатар
сарын 22-ны өдөр Дугаар 100 хот

ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монголын радиод олон жил үр бүтээлтэй ажиллаж олон нийтийг шуурхай мэдээллээр хангаж радио нэвтрүүлгийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор

Цэнд-Аюушийн Нямжав — Монголын радиогийн сурвалжлагч, редактор

Алтан гадас одонгоор

Содовын Буянжаргал — Монголын радиогийн хариуцлагатай редактор

Хөдөлмөрийн хүндэт медалиар

Чулууны Цэндбазар — Радио телевизийн Хэрэг эрхлэх газрын ахлах инженер

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 101

Д. ДАМДИНДОРЖИЙГ ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Цэрэг-эх оронч сэдвээр олон арван нийтлэл өгүүлэл бичиж туурвин ахмад дайчид болон нэр нь тодроогүй дайчдын баатарлаг үйлсийг олон түмэнд мэдээлэн алдаршуулахад оруулж буй хувь нэмрийг нь үнэлж сэтгүүлч Дашийн Дамдиндоржийг Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 102

Ц. ЗАНДРААД СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монголын залуучуудын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, өөрийн орны болон олон улсын залуучуудын удаа дараагийн чуулга уулзалт, урлаг, спортын арга хэмжээ зохион явуулахад техникийн найдвартай үйлчилгээгээр хангаж, төв, орон нутгийн малчид хөдөлмөрчид, тариаланч механикжуулагчдын дунд соёл, урлаг, ухуулга сурталчилгааны ажлыг тогтмол чанартай зохион байгуулж, өөрийн

эзэмшсэн олон төрлийн мэргэжлийн ажилд залуучуудыг сурган дадлагажуулж залуучуудын байгууллагын ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын залуучуудын холбооны гүйцэтгэх хорооны техникч, кино механикч Цэдэнгийн Зандраад Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 8 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 103

Улаанбаатар хот

АРХИВЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Архивын салбарт шинэчлэл хийх төрийн бодлого боловсруулах, архивын албыг бэхжүүлэх талаар дор дурдсан зүйлийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1) архивын салбарт шинэчлэл хийхдээ энэ зарлигийн хавсралтад дурдсан үндсэн чиглэлийг баримтлах;

2) архивын салбарт баримтлах төрийн бодлого, архивын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлсон Архивын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, архивын албаны тогтолцоог боловсронгуй болгож, бэхжүүлэх, төрийн төв архивуудын баримтыг сэргээн засварлах, хамгаалалтын хувийг бий болгох, мэдээллийн эрэл хайгуулын системийг боловсронгуй болгохын зэрэгцээ үндэсний мэдээллийн тогтолцоонд архивын мэдээллийн сүлжээг хамааруулж орчин үеийн техник хэрэгслээр хангахад шаардагдах зардлыг 1995 оноос эхлэн жил жилийн төсөвт тусган санхүүжүүлэх, архивын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх тогтолцоог бий бол-

гох, төрийн архивын байгууллагын ажилтнуудын нийгмийн баталгааг дээшлүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 103 дугаар зарлигийн хавсралт

АРХИВЫН САЛБАРТ ШИНЭЧЛЭЛ ХИЙХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Архивын салбарт шинэчлэл хийхэд дор дурдсан үндсэн чиглэлийг баримтална:

1) Монгол Улсын архивын үндэсний сан хөмрөг нь монголын ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйл, үндэсний баялаг мөний хувьд төрийн хамгаалалтад байх.

Архивын үндэсний сан хөмрөг нь байгалийн гамшиг, гал, усны болон гэнэтийн бусад аюул, гэмт халдлага, үрэгдэж устах болзошгүй нөлөөнөөс найдвартай хамгаалагдсан байхыг архивын аюулгүй байдлын баталгаа гэж үзэх.

Архивын үндэсний сан хөмрөгийн баримтын ашиглалтыг төрийн хуулиар зохицуулах.

Төрийн архивын байгууллагуудыг улсын төсвөөс санхүүжүүлэх.

2) Архивын үндэсний сан хөмрөг нь төрийн архивын сан хөмрөг, төрийн бус архивын сан хөмрөгөөс бүрдэх.

Төрийн архивын сан хөмрөг нь төр, захиргааны байгууллага, улсын үйлдвэрийн газар, төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгж, улсын төсвөөс санхүүждэг байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой баримт, түүнчлэн төрийн бус архив, хувь хүнээс харилцан зөвшилцсөний үндсэн дээр шилжүүлсэн, гэрээслэсэн, бэлэглэсэн, худалдаж авсан баримтаас бүрдэх.

Төрийн архивын сан хөмрөгийн баримт нь төрийн өмч учир сан хөмрөгийн баримтыг зөвхөн төрийн архивуудад байнгын хадгалалтад авах журмыг хуульчлан тогтоох.

Улс төрийн нам, олон нийтийн байгууллага, сүм хийдийн болон хувийн архив нь төрийн бус архивын сан хөмрөгт хамаарагдах.

Архивууд төрийн захиргааны зохих байгууллагаас зөвшөөрөл авч, бүртгэгдсэн байна. Төрийн ба төрийн бус архивын хоорондын харилцааг хуулиар зохицуулах.

3) төрийн архивуудын статусыг шинэчлэн тогтоож, архивын албаны бүтэц, зохион байгуулалтыг нийгмийн шинэ харилцаанд нийцүүлэн өөрчилж, нэгдсэн удирдлага, тогтолцоог бий болгож, архивын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгож бэхжүүлэх.

4) төрийн архивын баримтыг найдвартай хадгалах нөхцөлийг бүрдүүлж, архивын байгууллагыг зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаж, архивын ажилд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, архивын шинэ барилгыг 1995 онд ашиглалтад оруулах.

Архивын үндэсний сан хөмрөгийн баримтын нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, хосгүй үнэт, үнэт баримтыг төрийн бүртгэл хяналтад авах.

5) төр нь үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлаа хангах үүднээс архивын нэн чухал баримтыг төрийн архивын сан хөмрөгт төвлөрүүлэн авч, татан буугдсан, хувьчлагдсан байгууллагуудын баримтыг төрийн архивт шилжүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах.

Архивын үнэт баримтыг гадаадад гаргах, төрийн архивын сан хөмрөгт хамаарагдах эх баримтаар төрийн бус архивууд нөхөн бүрдүүлэлт хийхийг хориглох, төрийн бус архивын баримтыг худалдаж авах төрийн давуу эрхийг тогтоох зэрэг асуудлыг хуулиар зохицуулах.

Хилийн чанад дахь Монгол Улсын түүхэнд холбогдох баримтыг эрж сурвалжлах, судлах, эх болон хуулбар хувийг эргүүлж авахад төрөөс зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

6) төрийн архив нээлттэй байх. Чингэхдээ төр, байгууллага, хувь хүний нууцыг тогтоон хамгаалсан хуулиудыг баримтлах.

7) баримт бичиг зохион бүрдүүлэх ажлыг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх, байгууллагын архив, албан хэргийн үйл ажиллагааны нэгдлийг хангах, түүхэн уламжлалаа орчин үеийн ололттой хослуулах үндсэн дээр албан хэрэг хөтлөлтийн ажлыг сайжруулах.

8) архив судлал, археограф, баримт судлалыг хөгжүүлж, эрдэм шинжилгээ-арга зүйн бүтээл, архивын баримт бичгийг хэвлэн нийтлэх ажлыг өргөжүүлэх.

9) архив, албан хэрэг хөтлөлтийн талаар гарсан хууль тогтоомж, улсын стандарт болон бусад эрхийн актын хэрэгжилтэд тавих төрийн захиргааны байгууллагын хяналтыг сайжруулах.

10) архивын албаны боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх тогтолцоог бий болгож, төрийн архивын байгууллагын ажилтан, ажилчдын нийгмийн баталгааг хангах.

11) төрийн архивын албаны гадаад харилцааг өргөжүүлж, архивын салбар дахь олон улсын хамтын ажиллалагаанд идэвхтэй оролцох.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 104

ЗАРИМ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ, ШҮҮГЧДИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Намсрайн Ваанчигийг Чойр хот дахь сумын шүүхийн ерөнхий шүүгчийн, Баасанжавын Лхагвацэрэнг мөн шүүхийн шүүгчийн, Цэдэвийн Туяаг мөн хотын хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Цэдэнгийн Нанжидыг Говь-Алтай аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 105

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Намсрайн Ваанчиг, Баасанжавын Лхагвацэрэн, Хаянхярваагийн Оюунсүрэн нарыг Говь-Сүмбэр аймгийн шүүхийн шүүгчээр, Нямжавын Баярааг мөн аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 106

ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Намсрайн Ваанчигийг Говь-Сүмбэр аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1994 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 151 | Улаанбаатар хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ХИЙХ ТЭМЦЛИЙГ ХҮЧТЭЙ БОЛГОХ ТУХАЙ

Архидан согтуурах явдал манай оронд газар авч гэмт хэрэг, зөрчил гарах, хариуцлага, алдах, сахилга дэг журам гажуудуулах үндсэн нөхцөл болж байна.

Архидан согтуурахтай тэмцэх талаар гарсан хууль тогтоомжийг төв, орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хангалттүй биелүүлж байгаагаас нийгэмд ноцтой хор уршиг тарьж байна.

Архидан согтуурахтай тэмцэх ажлыг хүчтэй болгох, олон түмнээс тавьж байгаа санал шаардлагыг үндэслэн Монгол Улсын Засгийн газарт дор дурдсан чиглэл өгсүгэй.

1. Холбогдох хуульд дараахь чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн барих:

а) гудамж талбай, орон сууц, үзвэрийн болон зөвшөөрөгдсөнөөс бусад үйлчилгээний газар, түүнчлэн албан байгууллагын байранд согтууруулах ундаа худалдахыг хориглох, энэ журмыг зөрчсөн этгээдэд захиргааны журмаар барихчлах хүртэл шийтгэл хүлээлгэж байх;

б) удаа дараа эрүүлжүүлэгдсэн этгээдэд захиргааны журмаар баривчлах хүртэл шийтгэл оногдуулж байх;

в) албадан эмчилгээ давтан хийлгэсэн этгээд архидан согтуурч зөрчил гаргасан тохиолдолд түүнийг нийгмээс тодорхой хугацаагаар тусгаарлах;

г) хурал, зөвлөлгөөн, семинар, бүх шатны сургууль төгсөлт болон аливаа ойг тэмдэглэхдээ зохион байгуулалттайгаар архидан согтуурах явдлыг таслан зогсоох;

д) Засгийн газар согтууруулах ундаа үйлдвэрлэх зөвшөөрөл олгохдоо согтууруулах ундааны тухайн үеийн хэрэгцээ, шаардлага болон бусад нөхцөлийг харгалзан үзэх;

е) согтууруулах ундааны онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлэх.

2. Архидан согтуурахтай тэмцэх асуудлаар гарсан хууль тогтоомжийн биелэлтийг төр, олон нийтийн болон бусад бүх шатны байгууллагад өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр шалган дүгнэлт хийж архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах.

3. Нийслэл болон аймгийн төв, зарим суурин газруудад согтууруулах ундаа борлуулдаг шөнийн цэнгээний газруудыг (баар) нэгбүрчлэн шалгаж, зохих шаардлагыг хангаагүй газруудыг хаах хүртэл арга хэмжээ авах, цаашид ийм цэнгээний газар ажиллуулах зөвшөөрөл олгоход баримтлах нарийн журам тогтоох.

4. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг идэвхтэй өнгөрүүлэхэд чиглэсэн клубүүд байгуулж ажиллуулах, ерөнхий боловсролын сургуулиуд дээр төрөл бүрийн дугуйлан зохион байгуулж сурагчдыг хичээлийн бус цагаар хамруулах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5. Согтууруулах ундааны үйлдвэрлэл, улсын хилээр орж ирж буй согтууруулах ундаанд тавих чанар, гаалийн болон бусад хяналт шалгалтыг эрс сайжруулах.

6. Архидах донтой болсон хүмүүсийг эмчлэх ажлыг эрчимтэй явуулах.

7. Архидан согтуурахын хор аюул, түүнтэй тэмцэх арга замын тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон бусад аргаар ухуулан сурталчлах ажлыг өргөн зохиох.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨС АРД ТҮМЭНДЭЭ ХАНДАЖ ГАРГАСАН ИЛГЭЭЛТ

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ХҮЧТЭЙ БОЛГОХ ТУХАЙ

Манай улсад нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын амьдралыг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийн их үйл явц өрнөж, Монголчууд бид аливаа саад тотгор бүхнийг даван туулж зорьсон хэргээ бүтээхийн төлөө тэмцэж байгаа энэ үед ололт амжилтын зэрэгцээ дутагдал гажуудал багагүй гарч байна. Архидан согтуурах хэмээгч бидний бүтээн босгох, урагшлан хөгжих хурдыг сааруулахаар барахгүй зогсоож, нэгэнт хийж бий болгосон бүхнийг устган арчиж чадаж нэгэн бодит аюул эрчимтэйгээр түгэн дэлгэрч байна.

Хаа ч хамаагүй архидан согтуурч хэрэг төвөг тарьж явдаг эр, эм, хөгшин, залуу хүмүүсийн тоо олширчээ. Ийнхүү архидан согтуурч байгаагийн гол учир шалтгаан нь төрийн хууль тогтоомжийг биелүүлэх, нийгмийн дэг журам хангах үйл ажиллагаа, энэ талаархи төр засаг, олон түмний хяналт, тэднээс явуулах тэмцэл сул байгаа явдал мөн гэж би үзэж байна. Ингэтлээ архидан согтуурч байгаагийн учрыг зарим хүмүүс нийгэм, эдийн засгийн байгууллын өөрчлөлттэй холбон үзэх нь бий. Шилжилтийн үед гарсан эдийн засаг, ёс суртахууны зарим хямрал үүнд нөлөөлсөн тал бий боловч бүхэлд нь авч үзвэл тэр үндсэн шалтгаан нь биш юм. Аль ч нийгэмд архидан согтуурах явдлыг зөвтгөн дэмждэггүй нь бүхэнд илэрхий байна. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн хийсэн судалгаанаас үзэхэд архидан согтуурсан хүмүүсийн 49 хувь нь зочноо хүндэтгэн дайлах гэж, 27 хувь нь онцын шалтгаангүйгээр найз нөхдөө даган дарьвиж, 20 хувь нь ажил бүтээх гэж, 2 хувь нь ерөөсөө архи уух дур хүсэлдээ захирагдан ууж согтуурдаг байна.

Архидан согтуурах явдал нь улсын хууль тогтоомж, нийгмийн дэг журам зөрчих, танхайрахаас эхлэн хүний амь нас бүрэлгэх хүртэл элдэв гэмт хэрэг үйлдэх, хүн ардын эрүүл мэндийг хөнөөх, аливаа алдагдал, тасалдал, осол эндэгдэл гарах, өмч хөрөнгө сүйтгэх зэрэг муу муухай болгоны эх булаг болж байгаа нотлох гэж баримт дурдах нь илүүц зүйл

гэж бодож байна. Үүнийг та бүхэн тэртэй тэргүй өдөр бүр сонсч, үзэж, мэдэрч байгаа.

Манай нийгмийг нөмөрч байгаа архидан согтуурах аюулын учир холбогдлыг ухаан билэгт ард түмэн, иргэн бүр сайтар тунгаан бодож өөр хоорондоо шүүн хэлэлцэж гүн гүнзгий ухамсарлахын хамт түүнтэй тэмцэх эрхэм чухал бөгөөд үйлсэд оюун санаа, хүч чадлаа дайчлан зохих хувь нэмэр оруулах цаг хэдийнээ болжээ.

Би энэ талаар үүний өмнө хэд хэдэн ч удаа ярьж, олон түмний анхаарлыг төвлөрүүлж далайцтай, үр дүнтэй арга хэмжээ авах үүрэг чиглэлийг төрийн холбогдох байгууллагуудад өгсөн боловч тэр бүр амьдралд бүрэн хэрэгжихгүй, байдал олигтой сайжрахгүй байна.

Учир иймд дор дурдсан зүйлийг чин сэтгэлээсээ анхаарч хэрэгжүүлэхийг бүх ард түмэндээ дахин хүсч энэ илгээлтийг гаргаж байна.

Нэг. Архидан согтуурахтай тэмцэх асуудалтай холбогдуулж гаргасан төрийн хууль, Засгийн газар, орон нутгийн төр, захиргааны байгууллагын шийдвэрийг иргэн бүр, төр, олон нийт, аж ахуйн бүх байгууллагын удирдах нөхөд тус тусын шатанд хэлбэрэлтгүй биелүүлэн амьдрал ахуй, үйл ажиллагаандаа хэвшил болгох.

Хоёр. Төр, засгийн болон аж ахуйн дээд, төв байгууллагын удирдлагаас эхлэн баг, хороо, анхан шатны байгууллагын дарга хүртэл бүх удирдах хүмүүс улс орон, орон нутаг, байгууллага, хамт олноо «согтуугаар удирдахгүй» гэсэн зарчмыг хэрэгжүүлэн олон түмний архидан согтуурахгүй байх явдалд биеэр үлгэрлэн дагуулах.

Гурав. Бүх шатны удирдах ажилтан нар болон аливаа ажил, мэргэжил, албан тушаалын хүмүүс төв, орон нутагт хурал зөвлөлгөөн, семинар, ярилцлага, бусад үйл явдал, арга хэмжээнд оролцохоор цугларах үедээ, түүнчлэн хүмүүс «идэвхтэй амралт», элдэв «нийллэг», «зугаалга» зохиох нэрээр бөөгнөрөн хамтарч архидан согтуурахыг эцэс болгох.

Дөрөв. Ямар нэгэн баяр ёслол, ой, бусад тэмдэглэлт үйл явдлыг архидан согтуурахгүйгээр тэмдэглэж хэвших.

Тав. Айл өрх, байгууллага бүр гэр орон, албан ажлын газраа архидан согтуурах байр буюу согтуурагчдын үүр болгохгүй байх, архидан согтуурдаг хүнгүй айл өрх, хамт олон болох хөдөлгөөн, үйл ажиллагаа өрнүүлэх. Иймд болоход айл өрхийн тэргүүн, насанд хүрэгсэд, аливаа байгууллагын удирдах хүмүүс их үүрэг гүйцэтгэх ёстой гэж би бодож байна.

Зургаа. Иргэн бүр «Хэн хэзээ ч архидан согтуурч нийгмийн хэв журам зөрчихгүй» гэсэн зарчмыг тууштай хэрэгжүүлэх. Үүний тулд:

1) зочноо ямар ч нөхцөлд ялгаагүй заавал согтууруулах ундаагаар дайлахыг урьтал болгох, түүнийг архи дарсаар шахах, өөрөө зочинтойгоо хамтран архидах, танил дотно хүмүүс уулзаж учрахдаа нийлж архидан согтуурах зэргээс татгалзан зайлсхийж занших.

2) ажил бүтээх гэж архи уух гэдэг бол алба амины ямар нэгэн хүсэлтийг хэн нэг этгээдэд тавихдаа архи дарс барьж хандах, улмаар түүнийг согтоож байж санаснаа хийлгэх, өөрөөр хэлбэл нэгэн маягийн хээл хахууль өгч, түүнээсээ өөрөө хувь хүртэн архидаж байгаа хэрэг мөн бөгөөд энэ нь цаашдаа гэмт хэрэг болон даамжирч болзошгүй тул ийм явдлыг хэн ч үйлдэхгүй байх.

3) архи дарсанд хорхойтон дурлах гэмийг хүмүүс өөрөө өөртөө өндөр шаардлага тавин тэвчих замаар гэтлэн давж байх, тийнхүү согтууруулах ундаанд хорхойтон дурлах явдлаас бүрэн чөлөөлөгдөхийн тулд эмнэлгийн байгууллагуудад даруй хандаж эмчлүүлэх.

4) хүүхэд багачуудыг архидан согтуурах жигшүүрт дадал заншил руу уруу татахыг хатуу цээрлэх.

Долоо. Архидан согтуурахтай тэмцэх хууль тогтоомж, захирамж, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах ажлыг байнгын бөгөөд хүчтэй болгож, тэдгээрийн биелэлтийг хангуулахад тавих шаардлагыг бүх нийтээр өндөржүүлэх.

Найм. Хамт олон өөрийн байгууллагадаа, оршин суугчид өөрийн байшин сууцандаа, оюутан сурагчид дотуур байрандаа хэв журам сахиулах ажлыг эрхлэн зохион байгуулдаг болох.

Манай ухаант мэргэн ард түмэн арвин ёс суртахууны хэмжээлшгүй баян өв уламжлалтайн дотор архи дарсыг хэрэглэх нарийн ёс журам, гоо зүйтэй, түүнийгээ ихэд эрхэмлэн хүндэтгэж биелүүлдэг байсан билээ. Монголын ард түмний сэцэн цэлмэг, эрүүл саруул ухааны илрэл болсон

«Балай их уувал өвчин биш үү
Бахархан шунавал эргүү биш үү
Балмад их согтвол галзуу биш үү
Үргэлж уувал улиг биш үү»

гэсэн сургаал монгол хүн бүрийн сэтгэл зүрхэнд хадаатай байж амьдралын нэгэн хэм хэмжээ болж ирсэн шүү дээ.

Архидан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгохтой холбогдуулан авах арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргасныг ард түмэндээ мэдэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1994 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 09

«БАЙНГЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ» УЛСЫН ИХ ХУРЛЫН 70 ДУГААР ТОГТООЛТОЙ ХОЛБОГДСОН МАРГААНЫГ ХЯНАН ХЭЛЭЛЦСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг 1994 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 18 цагт Төрийн ордны 251 дүгээр тасалгаанд үйлдэв. Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Г. Нямдоо даргалж гишүүдэд Н. Жанцан (илтгэгч), С. Жанцан, Д. Чилхаажав, Ч. Энхбаатар нар оролцов.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Хуралдаанд маргагч талыг төлөөлж Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Б. Цэрэндорж, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж, М. Зэнээ нар тус тус оролцов.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. Очирбат 1994 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж тавьсан хүсэлтдээ-

Монгол Улсын Ерөнхийлөгч Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 60 дугаар тогтоолд бүхэлд нь хориг тавьсан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45[1] дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх, шийдвэр гаргах,, харин өгөх журмыг тодорхой заасан. Гэтэл Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурал Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу одоо хүртэл хэлэлцээгүйгээр үл барам Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэхийн оронд уг асуудлаар Хууль зүйн байнгын хорооны гаргасан дүгнэлтийг л хэлэлцдэг боллоо.

«Байнгын хорооны дүгнэлтийн тухай» Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгөхийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс хүсэж байна» гэжээ.

Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Б. Цэрэндорж Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа: Ерөнхийлөгчөөс хориг тавих түүнийг Улсын Их Хурлаас хэлэлцэх нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын хоорондын шууд харилцааны нэг хэлбэр.

Ерөнхийлөгчийн хоригийг хуулиар тогтоосон журмын дагуу хэлэлцэхгүйгээр байнгын хорооноос Ерөнхийлөгчийн хоригийн талаар гаргасан санал дүгнэлтийг бие даасан асуудал болгон хэлэлцэж байгаа нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийг зөрчиж байгаа хэрэг.

Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд Ерөнхийлөгчөөс тавьсан хориг хуульд заасан хугацаандаа тавигдсан эсэх тухай асуудал анхаарлын голд байгаа юм. Энэ асуудлаар Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхийн байр суурь зарчмын зөрүүтэй байгаа.

. . . Амралтын цагийг хасч тооцвол Ерөнхийлөгч Улсын Их Хурлын 66 дугаар тогтоолыг хүлээн аваад 54 цаг 20 минутын дараа буюу хориг тавих хугацаа дуусахаас 17 цаг 40 минутын өмнө уг хоригийг тавьсан юм гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж. Бямбадорж Үндсэн хуулийн цэцэд өгсөн тайлбартаа:

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 70 дугаар тогтоол Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын шийдвэрийг Ерөнхийлөгчид илгээснээс хойш 72 цагийн дотор тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьж болохыг хуульчилсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч дээрх заалт ёсоор 72 цагийн дотор Улсын Их Хурлын 1994 оны 66 дугаар тогтоолд хориг тавиагүй байна. Нэгэнт хуулийн хугацаанд багтааж Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавиагүй байх тул энэ удаагийн хориг гэж үзэх хууль зүйн үндэсгүй юм.

Маргааны гол зүйл нь 72 цагийн асуудал юм. Монгол Улсад өнөөдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид хугацааг цагаар заасан зүйл, заалт олон байгаа. Энэ нь ямар ч тайлбаргүйгээр хугацаа эхэлсэн мөчөөс тасралтгүй тоолно гэсэн хуулийн хоёрдмол утгагүй ойлголт гэжээ.

«Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай» Улсын дээд шүүхийн 1994 оны 8 дугаар сарын 11-ний 86 дугаар тогтоолд Ерөнхийлөгч хориг тавих эрх бүхий 72 цагийн хугацаа нь ажлын бус цагт дуусаж байвал энэ хугацаа нь түүний дараагийн ажлын өдрийн мөн цаг, минутад дуусгавар болно гэжээ.

Цэцийн хуралдаан дээр Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б. Цэрэндорж хэлэхдээ:

Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Бага Хурлаас батлагдсан Улсын Их Хурлын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Бага Хуралд танилцуулахаас өмнө энэ хуулийн зарим заалт, тухайлбал 52 дугаар зүйлд заасан 72 цагийн хугацаа нь ямар үндэслэлтэй вэ? хагас сайн, баяр, амралтын өдрийн өмнө тохиовол яаж тооцох вэ? гэсэн асуудлаар тайлбар өгөхийг Улсын Бага Хуралд албан ёсоор хүссэн юм. Үүний хариу болгож Улсын Бага Хурлын дарга Р. Гончигдорж албан бичгээр хариу өгөхдөө «Хэрэв 72 цагт хагас сайн, амралт, баярын өдөр тохиовол түүнийг хасч тооцох нь зүйтэй гэж үзнэ» гэсэн юм. Энэ бол хууль тогтоогчоос тухайн зүйлийг батлахдаа ямар агуулга шингээснийг тод харуулж байгаа нэг баримт юм гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж. Бямбадорж Цэцийн хуралдаан дээр хэлэхдээ: Ерөнхийлөгчийн хориг хугацаандаа тавигдаагүй тул зүй нь байнгын хорооогоор ч хэлэлцэхгүй буцаж болох байсан бид хүндэтгэл үзүүлж хэлэлцсэн юм. Цаг тоолох нэг л журам Монгол Улсын хуульд

байгаа. Аливаа хугацааг цагаар тодорхойлсон бол тэр нь тасрахгүй тоолно гэдэг нь тайлбар шаардахгүй ойлгомжтой зүйл. Улсын Их Хурлын 70 дугаар тогтоол бол үндсэндээ 72 цаг гэдгээ агуулгаар нь тайлбарлаж байгаа юм гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч М. Зэнээ хэлэхдээ: Хугацаа тоолох журам хуулийн практикт тогтсон зүйл. 72 цаг гэсэн хугацааг тасралтгүй тоолох ёстой гэдэг нь ойлгомжтой. Үндсэн хуулийн цэц хуулиа баримталж асуудлаа шийднэ гэдэгт найдаж байна гэжээ.

Хянавал:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66 дугаар тогтоолд тавьсан хориг нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан хугацаанд тавигдаагүй тул «Байнгын хорооны дүгнэлтийн тухай» Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны тогтоолын заалтыг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон гаргах дүгнэлт:

1. «Байнгын хорооны дүгнэлтийн тухай» Улсын Их Хурлын 1994 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 70 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

Дарга **Г. НЯМДОО**

Гишүүд **Н. ЖАНЦАН**

С. ЖАНЦАН

Д. ЧИЛХААЖАВ

Ч. ЭНХБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 106 | Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1, 48 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Цагдаагийн эргүүл, харуулын дүрмийг 1 дүгээр хавсралтын, Цагдаагийн хүрээний дүрмийг 2 дугаар хавсралтын, Цагдаагийн туслах ажилтны дүрмийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЦАГДААГИЙН ЭРГҮҮЛ, ХАРУУЛЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гудамж, талбай, үйлчилгээний цэг зэрэг олон нийтийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зорилгоор ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг цагдаагийн эргүүл гэнэ.

2. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагчид нэр зааж хариуцуулсан газрыг эргүүлийн чиглэл гэнэ.

3. Эргүүлийн нэг чиглэлд ажиллах үүрэгтэй эргүүлийг хэв журмын эргүүл гэнэ.

4. Эргүүлийн хоёр ба түүнээс дээш чиглэлийн хооронд явж ажиллах эргүүлийг хөдөлгөөнт эргүүл гэнэ.

5. Тээврийн хэрэгслээр болон аялагчдыг дагаж ажиллах эргүүлийг явуулын эргүүл гэнэ.

6. Цагдаагийн алба хаагч гудамж, талбай, үйлчилгээний газар, тээврийн буудал зэрэг олон нийтийн газрын тодорхой хэсэгт хяналт тавих, олъект хамгаалах, шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэхийг цагдаагийн харуул гэнэ.

7. Цагдаагийн харуулын хариуцан ажиглалт хийж байгаа газрыг хяналтын цэг гэнэ.

8. Тодорхой объектод байнгын хяналт тавьж гаднын халдлага, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх үүрэгтэй харуулыг объект хамгаалах харуул гэнэ.

9. Гудамж, талбай, үйлчилгээний газар, тээврийн буудал, олон нийтийн бусад газарт хяналт тавьж, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэх, таслан зогсоох үүрэгтэй харуулыг хэв журмын харуул гэнэ.

10. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, баривчлагдсан этгээдийг харгалзан хүргэх үүрэгтэй харуулыг хуяглан хүргэх харуул гэнэ.

11. Гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал өөрчлөгдөх үед болон нийтийг хамарсан арга хэмжээний үед хүч нэмэгдүүлэн ажиллуулах бэлтгэл хүчийг эргүүл, харуулын нөөц хүч гэнэ.

12. Цагдаагийн хоёр ба түүнээс дээш алба хаагч хамтарч эргүүлийн үүрэг гүйцэтгэхийг эргүүлийн хэсэг гэнэ.

13. Эргүүлийн хэсэг бүрт ахлагчийг томилно.

14. Цагдаагийн байгууллага бүр хариуцсан нутаг дэвсгэрийхээ эргүүлийн болон хэв журмын нөхцөл байдал, хүн ам, тээврийн хэрэгслийн нягтрал, бусад онцлог, тухайн үед шийдвэрлэвэл зохих зорилтуудыг харгалзан эргүүл, харуул ажиллуулах төлөвлөгөө хийх ба түүнийг нэгдсэн байршилт гэнэ.

15. Нэгдсэн байршилтыг жил бүрийн 10 дугаар сарын 1-нээс 4 дүгээр сарын 1 хүртэл (хүйтний), 4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1 хүртэл (дулааны) жилд хоёр удаа боловеруулж цагдаагийн тухайн байгууллагын даргын тушаалаар батална.

16. Хот, суурин газарт цагдаагийн хэв журмын эргүүлийг цаг агаарын болон хариуцан ажиллах чиглэлийн байдлыг харгалзан явган эргүүл 1—1,5 км, мотоциклтой эргүүл 3—5 км, машинтай эргүүл 6—8 км, ердийн хөсөгтэй эргүүл 2—4 км газар хариуцаж ажиллахаар зохион байгуулна.

17. Энэ дүрмийн 5, 10, 11 дүгээр зүйлд зааснаас бусад эргүүл, харуулын ажиллах чиглэл, байрлалыг эргүүл, харуулын нэгдсэн байршилтаар, эсхүл тухайлан зааж тогтооно.

18. Үүргээ гүйцэтгэж байгаа эргүүл, харуулыг татан буулгах, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах эрхийг зөвхөн тухайн эргүүл, харуулыг томилсон дарга эдэлнэ.

19. Удирдах дээд тушаалын дарга энэ дүрмийн 18 дугаар зүйлд заасан өөрчлөлтийг хийх бол өөрийн шийдвэрээ эргүүл, харуулыг томилсон албан тушаалтанд мэдэгдэнэ.

Хоёр. Эргүүл харуулыг үүрэгжүүлэх, алба хаагчийг томилох

20. Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх алба хаагчдийг шууд удирдах дарга нар жагсаан ирцийг бүртгэж, дор дурдсан албаны ба хувийн бэлтгэлийг нь шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулна:

а) эргүүл, харуулын чиглэл, цагийн байдлын тухай мэдлэг;

б) мөрдөж ажиллах хууль тогтоомжийн болон холбогдох бусад хууль эрхийн актын мэдлэг;

в) ашиглах зэвсэг, тээвэр, холбооны болон тусгай хэрэгслийн хангамж, бэлэн байдал, алба хаагчийн үнэмлэх болон зайлшгүй байх бусад бичиг баримтын бүрдэл;

г) улирлын болон гүйцэтгэх үүрэгт тохирсон хувцас;

д) эрүүл мэндийн хувьд үүрэг гүйцэтгэх чадвар;

е) ажиллах хугацаа, завсарлагыг төөцөж хооллосон байдал.

21. Албаны ба хувийн бэлтгэлийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулсны дараа зааварчилга өгнө. Зааварчилгыг хэрхэн ойлгож мэдсэнийг шалгасны дараа үүрэг гүйцэтгэх зөвшөөрөл олгоно.

22. Байнгын чиглэл ба хяналтын цэгт ажиллах эргүүл, харуул нь ажлаа хүлээлцэнэ. Хүлээлцэх журмыг цагдаагийн тухайн байгууллагын дарга тогтооно.

23. Эргүүл, харуул хүлээлцэх үед ноцтой зөрчил илэрсэн буюу шинээр гарах эргүүл, харуул (ээлж) нь тогтоосон хугацаанд ирээгүй тохиолдолд анги, байгууллагын дарга, жижүүрт мэдэгдэж, тэдний шийдвэрээр ажиллана.

24. Эргүүл, харуулын дүрмийн шаардлагыг ноцтой зөрчсөн, биеийн эрүүл мэнд болон бусад шалтгааны улмаас үүрэг гүйцэтгэх чадваргүй алба хаагчийн талаар тэдгээрийн дарга,

жижүүрт мэдэгдэж, үүрэг гүйцэтгүүлэхийг зогсоох, нөхөн гаргуулах арга хэмжээ авна.

25. Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа албаа хаагчид тусламж шаардлагатай болбол холбооны хэрэгслээр болон бололцоотой бусад аргаар цагдаагийн байгууллага, албаа хаагчид мэдэгдэнэ.

26. Тусламж хүссэн тухай мэдээг хүлээн авсан цагдаагийн байгууллага, албаа хаагч зэвсэг, тусгай хэрэгслээ хэрэглэхэд бэлтгэж, нэн даруй хүрэлцэн очиж тусална.

27. Эргүүл, харуул үүргээ гүйцэтгэж дуусмагц шууд удирдах дарга нь тэдгээрийн ажлыг дүгнэнэ.

Гурав. **Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх үед хориглох зүйл**

28. Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэх үед дор дурдсан зүйлийг хориглоно:

а) тухайн эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа албаа хаагчийн ажлыг шалгах эрх бүхий албан тушаалтнаас бусад хүнд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, эргүүлийн чиглэл ба харуулын цэгийн зураглалыг танилцуулах, шилжүүлж өгөх;

б) автомашин, мотоциклтой үүрэг гүйцэтгэхдээ албанд үл хамаарах хүн, ачаа тээвэрлэх;

в) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр харицуцсан чиглэлээс гарах, хяналтын цэгээ орхих, ном хэвлэл унших, телевиз үзэх;

г) бусадтай албаны бус ярианд хоёр минутаас удаан хугацаагаар ярих;

д) зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд галт зэвсгийг задлах, сумлах зэргээр оролдох;

е) иргэдээс гэмт хэрэг, зөрчлийн тухай гаргасан мэдэгдлийг хүлээн авахаас болон цадаагийн байгууллагад дамжуулахаас татгалзах.

Дөрөв. **Цагдаагийн гэрээт хамгаалалт**

29. Байгууллага, аж ахуйн нэгж, объектыг цагдаагийн байгууллагаар нэг жилээс дээш хугацаагаар хамгаалуулах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газар олгоно.

30. Байгууллага, аж ахуйн нэгж, объектыг цагдаагийн байгууллага 3 сараас дээш нэг жилээс илүүгүй хугацаагаар хамгаалах зөвшөөрлийг цагдаагийн төв байгууллага олгоно.

31. Байгууллага, аж ахуйн нэгж, объектыг гурван сар хүртэл түр хугацаагаар хамгаалах зөвшөөрлийг аймаг, нийслэл, дүүргийн цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн

Цагдаагийн ерөнхий газрын албад олгоно.

32. Цагдаагийн байгууллага нь хамгаалуулах байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулна. Гэрээ хүчин төгөлдөр болоогүй үед байгууллага, аж ахуйн нэгж, объектыг цагдаагийн хамгаалалтад авахыг хориглоно.

Тав. **Бусад зүйл**

33. Объект хамгаалах харуул нь үүрэг гүйцэтгэх үед болсон үйл явдлын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

34. Шөнийн (22—06 цаг) ээлжийн эргүүл, харуулд 6 цагаас илүү хугацаагаар үүрэг гүйцэтгэвэл цагдаагийн байгууллага нэг удаа хооллох зардлыг харицуна.

35. Эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийг шалгахдаа объектод нууцаар нэвтрэх, гэмт халдлага хийж байгааг дүрслэх зэрэг ноцтой хохирол гарч болох аргыг ашиглахыг хориглоно.

Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ЦАГДААГИЙН ХҮРЭЭНИЙ ДҮРЭМ

Нэг. **Нийтлэг үндэслэл**

1. Тухайн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байнга буюу түр байрласан цагдаагийн анги, байгууллагыг хамруулан цагдаагийн хүрээ байгуулна.

2. Цагдаагийн хэд хэдэн байгууллагын алба хаагчид тодорхой хугацаагаар цугларч хамтран үүрэг гүйцэтгэх үед түр хугацаагаар цагдаагийн хүрээ байгуулж болно.

3. Цагдаагийн хүрээг цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар байгуулна.

4. Эрх хэмжээнийхээ асуудлаар хүрээний даргын гаргасан тушаалыг хүрээнд байгаа анги, байгууллага, цагдаагийн алба хаагч биелүүлэх үүрэгтэй.

Хоёр. **Цагдаагийн хүрээний зорилго, зохион байгуулалт**

5. Цагдаагийн хүрээний зорилго нь:

а) цагдаагийн дотоод албаны дүрэм, цагдаагийн байгууллагын эргүүл, харуулын дүрэм, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм, цагдаагийн дүрэмт хувцас өмсөх журмыг алба хаагчид хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

б) цагдаагийн алба хаагчаас гаргасан сахилгын болон захиргааны зөрчлийг шалгах;

в) цагдаагийн хүрээний хэмжээнд явуулах баяр ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулахад оршино.

6. Цагдаагийн хүрээ бүрт хүрээний дарга болон дэд дарга, ерөнхий зохицуулагч, гишүүдээс бүрдсэн зөвлөл ажиллана. Зөвлөл нь хүрээний даргад зөвлөх эрхтэй байна.

7. Цагдаагийн хүрээний дарга, Нийслэлийн цагдаагийн хүрээний дэд дарга болон ерөнхий зохицуулагчийг Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар, зөвлөлийн бусад бүрэлдэхүүнийг хүрээний даргын тушаалаар тус тус томилно.

8. Цагдаагийн хүрээний даргын зөвлөл хагас жил тутамд 1-ээс доошгүй удаа хуралдаж, зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, хүрээний эрх хэмжээний бусад асуудлыг хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Гурав. **Цагдаагийн хүрээний удирдах албан тушаалтнуудын эрх хэмжээ**

9. Цагдаагийн хүрээний дарга дор дурдсан үүрэг хүлээнэ:

а) цагдаагийн хүрээний ажлыг удирдаж даргын зөвлөлийг толгойлох;

б) бие бүрэлдэхүүн цагдаагийн хүрээний дүрэм, дотоод албаны дүрэм, эргүүл харуулын дүрэм, алба хаагчийн сахилгын дүрэм, хувцас өмсөх журмыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах;

в) хүрээний бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай тушаалыг биелүүлэх ажлыг зохион байгуулах;

г) хүрээний алба хаагчид өвөл, зуны улирлын дүрэмт хувцсанд шилжих хугацааг тогтоох;

д) цагдаагийн хүрээний баяр ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг удирдан зохион байгуулах.

10. Хүрээний дарга дор дурдсан эрх эдэлнэ:

а) эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг хангуулах;

б) цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн дагуу цагдаагийн алба хаагчид сайшаал хүртээх, сахилгын шийтгэл ногдуулах;

в) цагдаагийн хүрээний эрх хэмжээнд хамаарах асуудлаар хүрээнд байдаг цагдаагийн анги, байгууллагын дарга, захирагч, алба хаагчид шаардлага тавьж биелэлтийг хангуулах;

г) цагдаагийн хүрээнээс зохиох тодорхой ажил үүргийг гүйцэтгүүлэхээр цагдаагийн алба хаагчийг шууд захирах даргатай нь зөвшилцөн томилон ажиллуулах;

д) цагдаагийн хүрээнд хариуцуулсан үүргийг биелүүлэх, үүний дотор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай тушаалыг биелүүлэх бэлтгэл сургууль зарлан хийлгэх.

11. Цагдаагийн хүрээний дэд дарга дор дурдсан эрх эдэлнэ:

а) бие бүрэлдэхүүнд цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, хүрээний дүрэм, алба хаагчийн сахилгын дүрэм, эргүүл, харуулын дүрэм, хувцас өмсөх журмын мэдлэг олгох, энэ талаар хүрээний анги, байгууллагаас зохиох ажлыг уялдуулан зохицуулж хяналт тавих;

б) цагдаагийн хүрээний ажлын төлөвлөгөө, даргын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

в) цагдаагийн хүрээний анги, байгууллагын бичгийн тамирын танхим, сургалтын болон буудлагын талбайд хичээллэх хуваарийг гарган батлаж мөрдүүлэх;

г) эрх хэмжээнийхээ асуудлаар хүрээний анги, байгууллага, алба хаагчид үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах;

д) эрх хэмжээнийхээ хүрээнд алба хаагчид сайшаал хүртээж, сахилгын шийтгэл ногдуулах.

12. Хүрээний ерөнхий зохицуулагч нь цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, эргүүл харуулын дүрэм, албан хаагчийн сахилгын дүрэм, дүрэмт хувцас өмсөх журмын биелэлтэд хяналт тавьж, ёс журам сахиулах албаны эргүүлийг удирдана.

Дөрөв. Цагдаагийн хүрээний ёс журам сахиулах эргүүл

13. Цагдаагийн хүрээний ёс журам сахиулах эргүүлийг хүрээний дарга томилно. Эмэгтэй алба хаагч ёс журмын эргүүлийн үүрэг гүйцэтгэхгүй.

114. Нийслэлд ёс журам сахиулах эргүүл 24 цагаар томилогдох ба хүрээнд багтдаг аль нэг анги, байгууллагын дарга, эсхүл дэд даргаар ахлуулан 2-оос доошгүй офицерын бүрэлдэхүүнтэй байна.

115. Аймагт цаг үеийн шаардлагаар хэрэгцээтэй газруудад ёс журам сахиулах эргүүл томилон ажиллуулна.

116. Ёс журам сахиулах эргүүлийн тавьсан хууль ёсны шаардлагыг цагдаагийн алба хаагчид албан тушаал, цол харгалзахгүйгээр биелүүлж захирагдана.

117. Ёс журмын эргүүл дор дурдсан эрх эдэлнэ:

а) цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, эргүүл, харуулын дүрэм, алба хаагчийн сахилгын дүрэм, дүрэмт хувцас өмсөх журмын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн дутагдлыг шалган шийдвэрлэх буюу эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх;

б) цагдаагийн алба хаагчаас гаргасан олон нийтийн хэв журмын болон захиргааны бусад зөрчлийг шалгаж шийдвэрлэхээд цагдаагийн хүрээний даргыг төлөөлөн оролцох;

в) согтуугаар олон нийтийн газар хэвийн бус яваа цагдаагийн алба хаагчийг эрүүлжүүлэх байр, албан газар, хамгаалах хүнд хүлээлгэн өгөх.

Тав. **Хүрээний алба хаагчийн оролцоотойгоор зохиох баяр, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ**

118. Ардын хувьсгал болон цагдаагийн байгууллагын ойн баярыг тэмдэглэхэд нийслэлд Цагдаагийн ерөнхий газрын, орон нутагт цагдаагийн хүрээний даргын тушаалаар хүрээний анги, байгууллагууд баяр ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд оролцоно.

119. Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэмд заасснаар угтан жагсах хүндэтгэлийн жагсаалыг хүрээний даргын тушаалаар гүйцэтгэнэ.

120. Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнол, ард иргэдийн амь нас, амгалан тайван байдлыг хамгаалах үүрэг гүйцэтгэж яваад амь үрэгдэгсдийн хөшөө, булшинд Цагдаагийн ерөнхий газрын даргын болон цагдаагийн хүрээний даргын шийдвэрээр хүндэтгэл үйлдэж цэцэг өргөнө.

Зургаа. **Цагдаагийн ёслолын жагсаал**

121. Цагдаагийн ерөнхий газрын болон цагдаагийн хүрээний даргын тушаалаар ёслолын жагсаалд оролцох бүрэлдэ-

хүүн, хүүхэд, жагсах дараалал, газар, дүрэмт хувцас, явж өнгөрөх зам, журмыг тогтоож, ёслолын жагсаал командлагчийг томилно.

22. Ёслолын жагсаалд оролцох анги, байгууллага заасан газарт байраа эзэлж, дарга, дэд дарга нар анги, байгууллагынхаа баруун (зүүн) гарт нэг эгнээ жагсана. Тэдний зүүн (баруун) гарт хоёр алхам зайтай тугчид жагсана.

23. Хүрээний хөгжмийн удирдаачийн мэдэлд хөгжимчид нэгдэж жагсана.

24. Цагдаагийн анги, байгууллага ёслолын жагсаалд галт зэвсэг, тусгай хэрэгслээр зэвсэглэх эсэхийг ёслолын жагсаал хийх тушаал гаргасан дарга шийдвэрлэнэ.

25. Анги, байгууллагын жагсах газар, жагсаалын үзүүр, гүн болон ёслолын жагсаалаар явж өнгөрөх шугамыг тэмдэглэх шугамчдыг хүрээний ерөнхий зохицуулагчийн мэдэлд томилно. Шугамчдыг жагсаал эхлэх талаас дугаарлана.

26. Ёслолын жагсаал командлагч болон ёслолын жагсаал хүлээн авагчид илтгэл өгөх үед жагсаалын гадна байгаа алба хаагчид «Номхон» зогсож ёсолж хүндэтгэнэ. Энэ заалт хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид хамаарахгүй.

27. Ёслолын жагсаал командлагчийг угтахдаа цагдаагийн хүрээний орлогч, эсхүл ерөнхий зохицуулагч «Номхон, зэргэц!» гээд зэрэгцэх чигийг хэлж команд өгч, ёслолын жагсаалд оролцох бүрэлдэхүүн бэлэн жагсаныг илтгэнэ. Ёслолын жагсаал командлагч илтгэл хүлээн аваад «Болно» команд өгнө.

28. Ёслолын жагсаал хүлээн авагчийг угтахдаа ёслолын жагсаал командлагч «Ёслолын жагсаал, Номхон!» гээд зэрэгцэх чиглэлийг хэлж команд өгнө.

Жагсаалд байгаа анги, байгууллагын дарга, дэд дарга нар ёсолж, хөгжимд угтах аялгуу тоглоно.

29. Ёслолын жагсаал командлагч ёслолын жагсаал хүлээн авагчийг угтан очиж илтгэл өгнө. Илтгэл өгөх үед хөгжим тоглолтоо зогсооно. Ёслолын жагсаал командлагч илтгэл өгч дуусаад ёсолсон гараа буулгахгүйгээр ёслолын жагсаал хүлээн авагчийн араас жагсаалын гадна талд нь дагаж явна.

30. Ёслолын жагсаал хүлээн авагч илтгэл авсны дараа ёсолсон гараа буулгаж жагсаалын өмнүүр явж бие бүрэлдэ-

хүүнтэй мэндчилж, баяр хүргэнэ. Мэндчилэх, баяр хүргэх үед хөгжим тоглолтоо түр зогсооно.

Мэндчилэхэд анги, байгууллагуудын жагсаан бие бүрэлдэхүүн цагдаагийн дотоод албаны дүрмийн дагуу хариу мэндчилж, баяр хүргэхэд гурвантаа «Ура» гэж уухайлна.

31. Ёслолын жагсаал хүлээн авагч индэр дээр гарах хүртэл хөгжимд «Алдар» аялгуу тоглоно.

32. Ёслолын жагсаал хүлээн авагчийн командаар ёслолын жагсаал командлагч «Болно» команд өгнө. Уг командын дараа бүрээчид «Бүгд анхаар!» дохио өгнө.

33. Ёслолын жагсаал хүлээн авагч уг хэлж дуусмагц анги, байгууллага командгүйгээр «Номхон» болж гурвантаа «Ура» цуурайтуулна. Энэ үед анги, байгууллагын дарга, дэд дарга нар ёсолж, «Номхон» зогсоно.

34. Бүрээчид «Бүгд сонс!» дохио өгмөгц ёслолын жагсаал командлагч команд өгч жагсаалыг эхлүүлнэ.

35. Ёслолын жагсаал командлагч «Ёслолын жагсаал! Номхон!» команд өгч, жагсагчдын хоорондын зай, зэрэгцэх ба эргэх чигийг зааж команд өгөөд, «Жагсаалын алхаагаар!», «Алх!» командууд өгнө.

36. «Ёслолын жагсаал! Номхон!» командаар тугчид тугаа өргөж, ишний доод үзүүрийг тогтоогчид хийж барина.

37. «Жагсаалын алхаагаар! командаар анги, байгууллагын дарга, дэд дарга нар, тугчид, хамгаалагчид жагсаалаас урагшаа тогтоосон зайд гарч зогсоно.

Шугамчид жагсаалын алхаагаар явж тогтоосон (15—20 алхам) зайд зогсож, жагсаалын зүг эргэн буугаа ёсолгоонд авна.

38. Ёслолын жагсаал командлагчийн «Алх!» командаар хөгжим тоглож, эхний анги жагсаалыг эхэлж, бусад нь дарга нарынхаа командаар эргэн, тогтоосон зайг баримталж, түрүүчийн ангийн араас явна. Ёслолын жагсаал явах үед эгнээ бүрийн индрийн талын нэгдүгээр хүнээс бусад нь бүгд хараа гаргаж явна. Тугчин, хамгаалагчид ёслолын жагсаалаар явах үед хараа гаргахгүй.

39. Ёслолын жагсаалын нэгдүгээр эгнээнээс ёслолын тугчин, хамгаалагчид 6. ахлах албан тушаалтнууд 2 алхмын жагсаал командлагч 18, ангийн дарга 10 дэд дарга нар 8, зайд тус тус явна.

40. Ёслолын жагсаал командлагч «Алх» команд өгч, өөрөө ёсолж, жагсагчид хоёр дахь шугамчнаас ёсолгоонд шилжинэ. Ангийн эхний эгнээ төгсгөлийн шугамчинг өнгөр-

мөгц дарга ёсолгоог буулгаж, жагсагчид гараа хаяж, жагсаалын алхаанд шилжинэ.

41. Сүүлчийн ангийн араас нэгдсэн найрал хөгжим явдал дундаа аялгуу тоглон ёслолын жагсаалаар явж өнгөрнө.

42. Ёслолын жагсаал командлагч ёслолын жагсаалаар явж өнгөрмөгц жагсаалаас гарч индрийн баруун (зүүн) талд зогсож ёсолно.

Долоо. **Цагдаагийн хүндэт харуул**

43. Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар хүндэтгэл үйлдэхээр томилогдсон цагдаагийн хүрээний салбарыг цагдаагийн хүндэт харуул гэнэ. Хүндэт харуулын бүрэлдэхүүнд салаа буюу суманг цагдаагийн найрал хөгжимтэй томилно.

44. Цагдаагийн хүндэт харуулыг баярын хурал, ёслол хүндэтгэлийн арга хэмжээний үеэр залсан Монголын цагдаагийн байгууллагын тугийн дэргэд болон цагдаагийн төв байгууллага болон хүрээний даргын шийдвэрээр хөшөө, дурсгал, булшинд хүндэтгэл үзүүлэх үед гаргана.

Найм. **Хөшөө, булшинд хүндэтгэл үзүүлэх**

45. Цэцэг өргөхийн өмнө дурсгалын хөшөө, булшны дэргэд цагийн мананаг гаргаж, өмнө нь хүндэт харуулыг жагсаана. Монголын цагдаагийн байгууллагын Туг жагсаалын баруун (зүүн) үзүүрт, хөгжим Тугийн зүүн (баруун) талд байрлана.

46. Цэцэг өргөх төлөөлөгчид тогтоосон зайд ойртож ирмэгц хүндэт харуулын дарга «Харуул! Номхон!» гээд зэрэгцэх чигийг хэлж команд өгнө. Төлөөлөгчдийн өмнө 2—3 алхам зайд цэцэг баригчид (1 цэцгийг 2 хүн барих) явна.

47. Харуул төлөөлөгчийн явах чиглэлийг дагуулан хараа гаргаж, хөгжим хүндэтгэлийн аялгуу тоглож, Монголын цагдаагийн байгууллагын Тугийг бөхийлгөнө.

48. Төлөөлөгчид цэцгээ өргөөд дурсгалыг хүндэтгэн нэг минут дуугүй зогсоно. Энэ үед хөгжим тоглолтоо зогсооно.

49. Дурсгалын хөшөө, булшны цагийн мананаг ёслол дууссаны дараа хүрээний даргын тогтоосон цагт буулгана.

Ес. **Нас барагчийг нутаглуулах үед цагдаагийн хүндэтгэл үзүүлэх**

50. Монгол Улсын баатар, гавьяат цолтон, дээд офицер, албан үүргээ гүйцэтгэж яваад гавьяа байгуулж нас барсан

цагдаагийн алба хаагчийг нутаглуулах үед цагдаагийн хүндэтгэл үйлдэхээр хүндэт бараа бологчийг хүрээний дарга томилно.

51. Хүндэт бараа бологч нь цагдаа, ахлах, дунд офицер нарт тасгийн; гавьяат цолтон, дээд офицер нарт салааны; Монгол Улсын баатарт сумангийн бүрэлдэхүүнтэй байна.

52. Салаа, сумангийн бүрэлдэхүүнтэй бараа бологчид Монголын цагдаагийн байгууллагын Тугийг гэргүй, гашуудлын туузтай авч явах бөгөөд найрал хөгжим дагалдана.

53. Бараа бологчдоос гадна:

а) шарилын дэргэд зогсох хүндэт харуул 8 хүн (дөрөв, дөрвөөр 2 ээлж);

б) шарилыг өргөх, байрлуулахад 8—10 хүн;

в) талийгаачийн одон, медаль бүхий жинтүү тус бүрт 1 хүн (одон бүрийг нэг жинтүүнд, харин медалийг хэд хэдээр нийлүүлэн жинтүүнд хадна).

54. Шарил гаргах, оршуулах цаг, газрыг цагдаагийн хүрээний дарга талийгаачийн ар гэрийнхний саналыг харгалзан тогтооно.

55. Цагдаагийн хүрээний даргаас томилогдсон алба хаагч хүндэт бараа бологчдын үйл ажиллагааг удирдана.

56. Нутаглуулахад оролцох бүрэлдэхүүн өдөр тутмын хувцастай, зүүн гартаа гашуудлын туузтай, эсхүл зүүн энгэртээ гашуудлын тэмдэг хадсан байна.

57. Хүндэт бараа бологчид нь талийгаачийн шарилыг гаргах хаалганд ойролцоо дэлгээ жагсаалаар жагсана. Хөгжим хүндэт бараа бологчийн баруун гар талд жагсана.

58. Шарил гаргахад эхлээд талийгаачийн зураг, араас нь цэнгийн баглаа, одон медаль, шарилын хайрцагны таг, шарил авч яваа хүмүүс, хүндэт харуул, дагалдагсад, хөгжим, хүндэт бараа бологч явна.

59. Шарилыг гаргах үед хүндэт бараа бологчийн дарга жагсаалаас гаралгүй «Номхон» команд өгч, өөрөө ёсолно. Хүндэт бараа бологч шарилыг дагуулж хараа гаргана. Хөгжимд гашуудлын ая тоглоно. Шарил гаргах үед жагсаалын гадна байгаа цагдаагийн алба хаагчид «Номхон» зогсож ёсолно.

60. Нутаглуулах цуваа явганаар явах үед хөгжимд гашуудлын ая завсарлагагүйгээр тоглоно.

61. Нутаглуулах газарт очмогц хөгжим тоглолтоо зогсоож, хүндэт бараа бологчийн хамт шарил руу харж жагсана.

62. Зураг, цэцгийн баглаа, одон медалийг шарилын толгой талд барьж зогсоно.

63. Шарилыг нутаглуулахын өмнө гашуудлын цуглаан хийнэ. Шарилыг нүхэнд тавих үед тугийг бөхийлгөж, хөгжим гашуудлын ая тоглож, хүндэт бараа бологчийн бүрэлдэхүүнээс томилогдсон хэсэг сургуулийн сумаар 3 удаа ёслолын буудлага үйлдэнэ.

64. Оршуулгын эцэст хүндэт бараа бологчид ёслолын жагсаал хийж хүндэтгэнэ.

Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ЦАГДААГИЙН ТУСЛАХ АЖИЛТНЫ ДҮРЭМ

Нэг. **Нийтлэг үндэслэл**

1. «Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хууль»-ийн 48 дугаар зүйлийн дагуу иргэнийг цагдаагийн туслах ажилтнаар авч ажиллуулахтай холбогдсон харилцааг энэ дүрмээр зохицуулна.

2. Туслах ажилтан үүргээ биелүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг чанд сахин ажиллана.

3. Цагдаагийн туслах ажилтнууд (цаашид «туслах ажилтан» гэж) 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэнийг өөрийнх нь зөвшөөрснөөр авч ажиллуулна.

4. Туслах ажилтан авч ажиллуулахдаа гэрээ байгуулна. Гэрээнд туслах ажилтны гүйцэтгэх үүрэг, түүнд олгох хөлс, туслах ажилтнаас үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах болон гэрээг сунгах ба цуцлах үндэслэлийг заана.

Гэрээнд нэг талаас цагдаагийн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан хаагч, нөгөө талаас туслах ажилтнаар ажиллах иргэн өөрөө гарын үсэг зурах ба гэрээг нэг жил хүртэл хугацаагаар байгуулна.

Гэрээг биелүүлэхтэй холбогдсон маргаан, гомдлыг цагдаагийн зохих дээд шатны байгууллага хянан шийдвэрлэнэ. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл цагдаагийн төв байгууллагад гомдол гаргаж болно.

5. Туслах ажилтанд гүйцэтгэх үүрэгтэй нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг зааж сургалт явуулна. Сургалтын хөтөлбөрийг цагдаагийн анги, байгууллагын дарга батална. Иймд сургалтад хамрагдаагүй иргэнийг туслах ажилтнаар ажиллуулахыг хориглоно.

6. Туслах ажилтнаар ажиллах хүний сургалтын дүн, хийсэн гэрээг үндэслэн цагдаагийн байгууллагын дарга тушаал гарган томилж, цагдаагийн тухайн байгууллагын бие бүрэлдэхүүнд танилцуулна.

7. Туслах ажилтныг цагдаагийн тодорхой алба хаагчид хариуцуулна. Хариуцсан алба хаагч нь туслах ажилтныг мэргэшүүлэх, дадлагажуулах үүргийг хүлээж, гэрээ болон энэхүү дүрмийг биелүүлэхэд тусална.

8. Цагдаагийн байгууллагаас туслах ажилтан бүрт үнэмлэх олгоно. Үнэмлэхийн загварыг цагдаагийн төв байгууллага батлаж, нийтэд зарлана.

Хоёр. **Туслах ажилтны эрх зүйн байдал**

9. Туслах ажилтныг нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, замын хөдөлгөөний болон галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажиллуулна. Тэгэхдээ дор дурдсан үүргийг гүйцэтгүүлэхийг хориглоно:

а) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

б) захиргааны зөрчил шалгуулах ба шийдвэрлүүлэх;

в) гүйцэтгэх ажил эрхлүүлэх, эсхүл нууц мэдээлэгчээр ажиллуулах;

г) цагдаагийн алба хаагчийг орлуулан ажиллуулах.

10. Туслах ажилтан үүргээ гүйцэтгэхдээ дор дурдсан эрх эдэлнэ:

а) гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан газар, ул мөрийг хамгаалах.

б) гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн болон гэрч болох хүмүүсийн бичиг баримтыг шалгаж хаягийг тогтоох;

в) гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэн этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэх;

г) хэв журам сахих талаар гэрээгээр хариуцсан үүргийнхээ хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад шаардлага тавих;

д) гэмт хэрэг, захиргааны зөрчил гарсан тухай төрийн зохих байгууллагад яаралтай мэдээлэх үед байгууллага, ир-

гэдийн холбооны хэрэгслийг дараалал харгалзахгүй ашиглаж хөлсийг нөхөн төлөх.

11. Туслах ажилтан албан үүргийн дагуу иргэдтэй харилцахдаа үнэмлэхээ үзүүлнэ. Олон нийтийн газар ажиллахдаа туслах ажилтан болохыг илэрхийлсэн хантуйн тэмдэг, энгэрийн зүүлт зэргийг хэрэглэж болно. Ийм тэмдэг, зүүлтийг цагдаагийн байгууллагаас олгож, загварыг нийтэд мэдээлнэ.

12. Цагдаагийн туслах ажилтанд галт зэвсэг, тусгай хэрэгсэл тавьж олгохгүй.

13. Цагдаагийн туслах ажилтны үйл ажиллагааны талаар гарсан гомдлыг цагдаагийн байгууллага 14 хоногийн дотор шалгаж хариу өгнө. Уг шийдвэрийг эс зөвшөөрвөл цагдаагийн дээд шатны байгууллагад гомдол гаргах буюу хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад аргыг сонгон авч болно.

14. Туслах ажилтан Монгол Улсын хууль тогтоомж, энэ дүрмийг зөрчвөл хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 107

ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсаас гадаадын иргэдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх үүрэг бүхий Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай:

Зөвлөлийн дарга — Хууль зүйн сайд

Зөвлөлийн орлогч дарга — Хүн амын бодлого, хөдөлмөрийн дэд сайд

Гишүүд:

— Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ерөнхийлөгчийн Тамгын газартай зөвшилцсөний үндсэн дээр);

— Гадаад харилцааны яамны Консулын газрын дарга;

— Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны гадаадад ажиллагчид, гадаадын байгууллага, иргэдэд зуучлах товчооны дарга;

— Худалдаа, үйлдвэрийн яамны Аж үйлдвэр, гадаадын хөрөнгө оруулалтын газрын ерөнхий захирал;

— Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын ерөнхий захирал;

— Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга;
— Татварын ерөнхий газрын дэд дарга;
— Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
— Хууль зүйн яамны Олон улсын эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга;
— Шинжлэх ухаан, боловсролын яамны Хамтын ажиллагаа, мэдээллийн хэлтсийн дарга;
— Статистикийн газрын Нийгмийн статистикийн хэлтсийн дарга;
— Тагнуулын төв газрын Сөрөх тагнуулын хэлтсийн дарга;
— Хилийн цэргийг удирдах газрын Хилийн шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга;
— Цагдаагийн ерөнхий газрын Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн дарга.

Нарийн бичгийн дарга — Орон тооны (Яам, тусгай газрын даргатай адил эрх хэмжээтэй)

2. Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөлийн дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

3. Хууль зүйн яамны 1994 оны зардлын төсвийн хязгаарыг 200,0 (хоёр зуун) мянган төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

Сангийн сайд **Д. ДАВААСАМБУУ**

Засгийн газрын 1994 оны 107 дугаар тогтоолын хавсралт.

ГАДААДЫН ИРГЭДИЙН АСУУДАЛ ЭРХЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. **Нийтлэг үндэслэл**

1. Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл (цаашид «Зөвлөл» гэнэ)-ийн үндсэн зорилт нь Монгол Улсаас гадаадын иргэдийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж, төрийн захиргааны төв байгууллагуудын гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон үйл ажиллагааг уялдуулан чиглүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд оршино.

2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Зөвлөлийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлж, Зөвлөлийн зорилт, үүргийг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газрын өмнө хариуцна. Зөвлөлийн даргын эзгүйд түүний үүргийг Зөвлөлийн орлогч дарга гүйцэтгэнэ.

Зөвлөл ажлаа хагас жил тутам Засгийн газарт тайлагнаж байна.

Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь орон тооны байх бөгөөд зөвлөлийн дотоод ажлыг эрхлэн гадаадын иргэдийн холбогдолтой судалгаа, дүн шинжилгээг нэгтгэх ажлыг зохион байгуулна.

4. Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргаж, биелэлтийг хангуулна. Зөвлөлийн тогтоолыг холбогдох байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.

5. Зөвлөл нь гадаадын иргэд, цагаачлалтай холбогдсон асуудлыг хэрэгжүүлэхдээ холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй харилцан ажиллана.

6. Зөвлөл нь тогтоосон журмаар хийлгэсэн тамга, тэмдэг болон албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. **Зөвлөлийн үүрэг, эрх**

7. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) Монгол улсад удаан хугацаагаар болон байнга амьдран суугаа гадаадын иргэд, цагаачдын талаар төрөөс ба-

римтлах ойрын болон хэтийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг чиг үүргийн дагуу зохион байгуулах;

б) түс улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон асуудлыг нэгдсэн удирдлагаар хангаж зохицуулах;

в) Монгол Улсын хүн амын тоо, нягтрал, газар зүйн байршил, хөгжлийн түвшин зэрэг хүчин зүйлтэй уялдуулан цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, хөдөлгөөний талаар санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

г) цагаач гадаадын иргэнд оршин суух зөвшөөрөл олгох, түүнийг сунгах, хүчингүй болгох асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

д) гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон шаардлагатай мэдээ, судалгаа, баримт материалыг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авах, дүгнэлт, шинжилгээ хийх;

е) гадаадын иргэний оршин суух хугацааг богиносгох, тэднийг Монгол улсаас албадан гаргах тухай шийдвэр гаргах;

ж) гадаадын иргэдийн тухай мэдээ, тайланг холбогдох яам, түсгай газраас улирал бүр авах.

8. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а) гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдсон асуудлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд түс түсын чиг үүргийн дагуу хэрхэн гүйцэтгэж байгаад хяналт тавьж, шаардлагатай асуудлаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх;

б) гадаадын иргэдийн эрх зүйн байдал, цагаачлалтай холбогдолтой хууль тогтоомжийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хийгээд холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж зохих байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь шуурхай хангуулах, шаардлагатай мэдээ, судалгаа, дүгнэлт, баримт материалыг гаргуулах;

в) холбогдох асуудлаар санал боловсруулах, цагаач гадаадын иргэдийн талаар баримтлах ойрын болон хэтийн бодлого, чиглэлийг тодорхойлох ажилд урьдчилан тохиролцсоны үндсэн дээр холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах;

г) Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Зөвлөлийн гишүүд холбогдох байгууллагад нэвтэрч, зохих хүмүүстэй уулзаж, мэдээ, баримт авах;

д) Монгол Улсын хууль тогтоомжоор олгосон бусад эрхийг эдэлнэ.

Гурав. **Зөвлөлийн ажиллах журам**

9. Зөвлөл нь сард нэгээс доошгүй удаа хуралдана. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно. Хуралдааныг зөвлөлийн дарга удирдана.

10. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Зөвлөлийн гишүүн бүр нэг санал өгөх эрхтэй бөгөөд хэрэв санал хуваагдвал даргалж буй хүний саналаар шийдвэрлэнэ. Тогтоолд Зөвлөлийн дарга, хуралд оролцсон гишүүд гарын үсэг зурна.

11. Зөвлөл нь хурлын явцын талаар тэмдэглэл хөтөлнө. Энэхүү тэмдэглэлд Зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурна.

12. Зөвлөлөөс шалгалт, судалгаа хийлгэх, гишүүдийн албан томилолтын болон бичиг хэргийн зэрэг бусад зардалд шаардагдах хөрөнгийг Хууль зүйн яамны жилийн төсөвт тусгайлан тусган баталж санхүүжүүлнэ.

13. Зөвлөлийн гишүүн нь зохих журмаар хийлгэсэн үнэмлэхтэй байна. Үнэмлэхийн загварыг Зөвлөлийн дарга батална

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 115

ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«БНМАУ-ын Өмч хувьчлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 169 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан «Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулах нийтлэг журам»-д дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

а) 1 дүгээр зүйлийн «. . . дуудлагын худалдаанаас . . .», 5 дугаар зүйлийн «г» заалтын «. . . анхны үнийг . . .», 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн «. . . үнийг илэрхийлсэн . . .», болон «. . . хувьтай тэнцэх . . .», 11 дүгээр зүйлийн «. . . барьцаанд өгсөн . . .», 15 дугаар зүйлийн «. . . харьяалалгүй хүмүүс . . .» гэж заасны дараа тус тус «. . . бэлэн мөнгө,» гэсэн хэсэг нэмсүгэй;

б) 6 дугаар зүйлийн нэг дэх хэсгээс «. . . тооны . . .» 9 дүгээр зүйлийн нэг дэх хэсгээс «. . . ногоон тасалбарын тоогоор илэрхийлэн . . .», 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс «. . . тасалбараар . . .» гэснийг тус тус хассугай;

в) 6 дугаар зүйлд заасан дуудлагын худалдаанд оролцох хүсэлтэй этгээдийн уг худалдаанд оролцон эд хөрөнгө худалдан авах эрх олж авахад төлөх хураамжийн хэмжээг 2000 төгрөг, ажиглагчаар оролцох этгээдийн төлөх хураамжийн хэмжээг 200 төгрөг болгон өөрчлөн тогтоосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 116

ЗААВАРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 13 дугаар тогтоолоор баталсан «Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар»-ын 12 дугаар зүйлийн «Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, тэдгээрийн Тамгын

газар, Засгийн газар, түүний Хэрэг эрхлэх газар, шүүхийн байгууллагын хэвлэмэл хуудас төрийн сүлдтэй, тамга хэрэглэх эрх бүхий бусад байгууллагын хэвлэмэл хуудас соёмботой байна» гэсэн хэсгийг «Монгол Улсын Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 9-д зааснаас бусад тамга хэрэглэх эрх бүхий байгууллагын хэвлэмэл хуудас соёмботой байна» гэж өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

ДАНИ УЛСААС ҮЗҮҮЛЭХ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Дани Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар «Монголын мал аж ахуйн хөгжилд дэмжлэг үзүүлэх» төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэл ажлыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дани Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгийг шинээр сүүний жижиг аж ахуй бий болгох, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зориулан ашиглахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД)-д зөвшөөрсүгэй.

2. Сүүний аж ахуйн өмч хөрөнгийн хувьчлал, өмчлөлтэй холбогдсон асуудлыг зохистой шийдвэрлэх чиглэлийг энэ оны 7 дугаар сард багтаан гаргахыг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-т даалгасугай.

3. Дор дурдсан асуудлыг хамтарч шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), Үндэсний хөгжлийн газар

(Ч. УЛААН), Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай:

а) Данийн талаас тавих нөхцөл, шаардлагыг харгалзан үзсэний үндсэн дээр Засгийн газарт олгох буцалтгүй тусламжийн хөрөнгийг зээлдүүлэх нөхцөл, журам, зээлийн хугацаа, хүүгийн оновчтой хэмжээг тооцож тогтоох;

б) Дани Улсын буцалтгүй тусламжийг хэрэгжүүлэх хүрээнд шинээр байгуулагдах хувийн фермерийн аж ахуйнуудад хуучин ферм, компаний үндсэн хөрөнгө (малаас бусад), зээл, өрийг шилжүүлэхгүй байх чиглэл баримталж, зээлийн өрийн асуудлыг зохистой шийдвэрлэх;

в) аж ахуй эрхлэн хөтлөх найдвартай хүмүүсийг өрсөлдүүлэн сонгон шалгаруулсны үндсэн дээр тэдэнтэй гэрээ байгуулж, тусламжийн хөрөнгөөр аж ахуй байгуулж ажиллах зөвшөөрөл олгож, тэдний авсан зээлийн төлбөр, тооцоог ажилд тогтмол хяналт тавьж ажиллах.

4. Шинээр байгуулагдах сүүний жижиг аж ахуйд бэлчээр хадлан, тариалангийн талбайг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуваарилан эзэмшүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), холбогдох аймаг, сумын болон нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын сайд бөгөөд
Үндэсний хөгжлийн газрын
дарга **Ч. УЛААН**

Хүнс, хөдөө аж ахуйн сайд **Ц. ӨӨЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 6 дугаар сарын 29-ний өдөр — Дугаар 121 — Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. «Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх журам»-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх журмыг мөрдөхтэй холбогдсон аргачлал, зааврыг 1994 онд багтаан батлан гаргахыг Байгаль орчны яам (З. БАТЖАРГАЛ), Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН)-т даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Байгаль орчны сайд **З. БАТЖАРГАЛ**

Засгийн газрын 1994 оны 121 дүгээр тогтоолын хавсралт

ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх аливаа төслийн байгаль орчинд хэрхэн нөлөөлөх байдлыг үнэлж, уг төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэхэд энэ журмыг мөрдлөг болгоно.

2. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх (цаашид «нөлөөлөх байдлыг үнэлэх» гэнэ) зорилго нь уг төслийг хэрэгжүүлсний улмаас байгалийн төлөв байдал өөрчлөгдөх, тэнцвэр нь алдагдах, байгаль орчинд болон хүн амын эрүүл мэндэд хохирол учрахаас сэргийлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

3. Нөлөөлөх байдлыг үнэлэх нь уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчинд учруулж болох аливаа нөлөө, хохирол, үр дагаврыг урьдчилан тогтоож, түүнээс сэргийлэх арга хэмжээг төсөлд тусгах, төслийн экологи-эдийн засгийн үр дүнг дээшлүүлэх, улмаар байгаль орчинд болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар төслийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд туслах тэднийг учирч болох алдагдал, хохирлоос сэргийлэхэд чиглэнэ.

4. Аж ахуйн нэгж, байгууллага энэ журмын дагуу харуцан хэрэгжүүлэх төслийнхөө байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлүүлж, зөвшөөрөл авсан байна.

5. Энэ журмын дагуу нөлөөлөх байдлыг үнэлэхэд хамаарагдах төслийн ангиллыг Байгаль орчны, яам, Үндэсний хөгжлийн газар хамтран гаргана.

Хоёр. **Нөлөөлөх байдлыг үнэлэх, шийдвэр гаргах зарчим**

6. Нөлөөлөх байдлыг үнэлэх ажлыг ерөнхий, нарийвчилсан гэсэн хоёр түвшинд хийнэ. Ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ гаргах заавар, аргачлал, шалгуур үзүүлэлтийг Байгаль орчны яамнаас тогтооно.

7. Ерөнхий үнэлгээг төслийн төлөвлөлтийн эхний үе шатанд хөрөнгө оруулалтын өмнөх судалгааны анхдагч мэдээлэлд тулгуурлан хийх бөгөөд тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдал, сөрөг үр дагаврыг урьдчилсан байдлаар тодорхойлж, цаашид нарийвчлан үнэлэх шаардлагатай эсэхийг тогтооно.

8. Ерөнхий үнэлгээгээр тухайн төслийн байгаль орчинд нөлөөлөх байдал, түүний үр дагаврыг урьдчилан тогтоож дүгнэлт гаргасны үндсэн дээр дор дурдсан шийдвэрийг гаргана:

а) төслийн эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагавар нь тухайн үед мөрдөж буй байгаль орчны болон эрүүл ахуйн стандарт, норм, дүрэм, журмаар зөвшөөрсөн хэмжээтэй нийцэж байвал цаашид уг төсөлд нарийвчилсан үнэлгээ, хийх шаардлагагүй гэж үзэж түүнийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох;

б) төслийн сөрөг нөлөөлөл, үр дагавар онц ноцтой биш бөгөөд удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах замаар уг нөлөөллийг багасгах, арилгах боломжтой нь тогтоогдвол тухайн төсөлд нэмж тусгах арга хэмжээ болон заавал хангасан байвал зохих шаардлага, биелүүлэх хугацааг зааж тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлэх зөвшөөрөл олгох;

в) төслийн сөрөг нөлөөлөл, үр дагавар ноцтой ноцтой биш болох нь тогтоогдвол түүнийг цаашид нарийвчилсан үнэлгээнд хамруулахаар шийдвэрлэх.

9. Нарийвчилсан үнэлгээг төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг-төсөл боловсруулалтын үе шатанд хийж, байгаль орчинд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөө, үр дагавар, учруулах хохирлын хэмжээг зохих аргачлал, зааврын

дагуу тогтоох, тэдгээрийг багасгах, арилгах арга хэмжээ, технологийн шийдлийг төсөлд тусгах талаар судалгаа хийж зөвлөмж гаргана.

10. Нарийвчилсан үнэлгээ нь төслийн байгаль орчинд болон эрүүл мэндэд нөлөөлөх эерэг, сөрөг нөлөө, үр дагавар, хамрах хүрээ, учруулах хохирлын байдлаас шалтгаалан хэсэгчилсэн, иж бүрэн гэсэн хоёр хэлбэртэй байна.

11. Ерөнхий үнэлгээгээр төслийн нөлөөлөл, түүний үр дагавар нь байгаль орчны тодорхой нэг бүрэлдэхүүн зарим шинж байдалтай холбоотой бол хэсэгчилсэн үнэлгээ хийх бөгөөд байгаль орчинд ноцтой хор уршигтай байж болзошгүй бол төсөлд иж бүрэн үнэлгээ хийнэ.

12. Төсөл хэрэгжүүлэгч ерөнхий үнэлгээний дүгнэлт, шийдвэрийг үндэс болгон эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тохиролцож нарийвчилсан үнэлгээг хийлгэнэ.

13. Нарийвчилсан үнэлгээ хийхэд Байгаль орчны яамнаас баталсан аргачлал шалгуур үзүүлэлт түүнчлэн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, тайлан гаргана.

14. Нарийвчилсан үнэлгээний тайланд Байгаль орчны яам, аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохих албад шүүмж хийнэ. Шаардлагатай гэж үзвэл шүүмж хийхэд холбогдох эрдэмтэн, мэргэжилтнийг шинжээчээр оролцуулж болно. Шинжээч нь дүгнэлтийнхээ үнэн зөвийг хариуцна.

15. Шүүмжийн дүгнэлтийг үндэслэн тухайн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар эрх бүхий байгууллагууд энэ журамд заасны дагуу шийдвэр гаргана. Уг төслийг хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр гарсан тохиолдолд Байгаль орчны яам, аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар төсөл хэрэгжүүлэгчид зөвшөөрлийн гэрчилгээ олгоно. Зөвшөөрлийн гэрчилгээ олгох журмыг Байгаль орчны яам батлан мөрдүүлнэ.

16. Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагааныхаа явцад хэрэгжүүлэх байгаль орчны төлөвлөгөө, мониторингийн хяналтын хөтөлбөрийг боловсруулж зөвшөөрөл олгосон байгууллагатай тохиролцон мөрдөж ажиллана.

17. Байгаль орчны төлөвлөгөө, мониторингийн хөтөлбөрийн хэрэгжилтэд Байгаль орчны яам, аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

18. Үнэлгээ болон шүүмж хийгч, шийдвэр гаргагч аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаандаа олон нийтийн саналыг авч тусган хэрэгжүүлэх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ:

а) үнэлгээ, шүүмж, шийдвэртэй танилцах боломжийг олон нийтийн төлөөлөгчдөд олгох;

б) нарийвчилсан үнэлгээний явцад олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал, шүүмжлэл, зөвлөмж болон нэмэлт мэдээллийг боломжит хэлбэрээр авч тайланд тусгах;

в) төслийн талаар шаардлагатай мэдээг нийтэд зарлан мэдээлж байх.

19. Олон нийтийн байгууллага, иргэд нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэлгээний ажлын явц, зөвлөмжийн хэрэгжилтэд сайн дурын хяналт тавьж болно.

20. Үнэлгээтэй холбогдсон судалгаа шинжилгээний ажил, тайлан, зөвлөмж нь шинжлэх ухааны үндэслэл бүхий бөгөөд үнэн бодит нотолгоонд тулгуурласан байна.

21. Нарийвчилсан үнэлгээг зураг төсөл боловсруулах явцад хийж гүйцэтгэх зарчмыг баримталбал зохино.

22. Нарийвчилсан үнэлгээний ажлын зардлыг тухайн төслийн төсөвт өртөгт багтаан төлөвлөнө. Гүйцэтгэлийг энэ журмын 12-т заасан нарийвчилсан үнэлгээний ажлын гэрээгээр дүгнэнэ.

23. Шаардлагатай тохиолдолд энэ журмын 22-т заасан үнэлгээний ажлын зардалд Байгаль орчны яам шүүлт хийж болно.

Гурав. **Үнэлэх ажлыг эрхлэгч**

24. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх ажлын хүрээнд өгөх ерөнхий, нарийвчилсан үнэлгээний талаархи тайланд шүүмж бэлтгэх, төслийг хэрэгжүүлэх, эсэх тухай шийдвэр гаргах, зөвшөөрлийн гэрчилгээ олгох ажлыг Байгаль орчны яам, аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар эрхэлнэ.

25. Аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын түвшинд хийгдэх үнэлгээнд хамаарах төслийн ангиллыг энэ журмын 5-д заасан ангилалд тодотгон тусгана.

26. Үнэлгээнд хамаарах Засгийн газрын төсөл, арга хэмжээний жагсаалтыг Байгаль орчны яам, Үндэсний хөгжлийн газар хамтран батална.

27. Шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь аймаг, нийслэл (хот)-ийн Засаг даргын Тамгын газарт, аймаг, нийслэл (хот)-ийн Засаг даргын Тамгын газар нь Байгаль орчны яаманд тус тус өөрийн хийсэн үнэлгээг оруулж магадлан шалгуулж, баталгаажуулж болно.

28. Нарийвчилсан үнэлгээг нйм үнэлгээ хийх эрх бүхий бөгөөд төсөл хариуцагчаас үл хамаарах хөндлөнгийн аж ахуйн нэгж, байгууллага хийнэ. Нөлөөлөх байдлын үнэлгээ хийх эрхийг Байгаль орчны яамнаас аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх эрх олгох журам, шалгуур үзүүлэлтийг холбогдох яам, тусгай газартай зөвшилцөн Байгаль орчны яамнаас тогтооно.

Дөрөв. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, үнэлгээтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

29. Тухайн төсөл хэрэгжүүлэгч нь энэхүү журмын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Байгаль орчны яам, аймаг, нийслэл (хот), сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар дор дурдсан арга хэмжээ авна:

а) үнэлгээ хийлгэлгүйгээр төсөл хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын энэ талаархи үйл ажиллагааг зогсоох тухай саналыг шүүхэд гаргаж шийдвэрлүүлэх;

б) олгосон зөвшөөрөлд заасан нөхцөл, болзол болон нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийг биелүүлээгүй тохиолдолд төсөл хэрэгжүүлэгчид олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох;

в) гэм буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага ногдуулах.

30. Ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний үндэслэл, дүн, шүүмжийн дүгнэлт, шийдвэртэй холбогдон төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ, шүүмж гаргагч, бусад талуудын хооронд гарсан маргааныг үнэлэх ажлыг эрхлэгчийн дээд шатных нь байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хянаж шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрөл маргалдагч тал гомдлоо шүүхэд гаргаж шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 124

ЗӨВЛӨМЖ, ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Экспорт, импортын барааны чанарыг баталгаажуулах, хяналтыг сайжруулах талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан зөвлөмж болон энэ асуудлаар Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Экспорт импортын бараа (бүтээгдэхүүн)-ны чанарын хяналтын ажлыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг 1 дүгээр хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай.

2. Экспорт импортын барааны чанарын хяналтын ажлыг зохицуулах зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

3. Чанарын хувьд тусгай шаардлага тавигдаг бараа (бүтээгдэхүүн)-г гадаадаас худалдан авах нөхцөлд чанарын баталгааг нь үг бараг үйлдвэрлэгч буюу нийлүүлэгч тал харицуцдаг зарчмыг баримтлан гадаад худалдааны гэрээ, хэлэлцээрт энэ талаар тодорхой тусгадаг журамд энэ оны 8 дугаар сарын 1-нээс шилжих нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Хүнсний бүтээгдэхүүний стандарт, чанар, эрүүл ахуйн үзүүлэлтийн мэдээллийн автоматжуулсан сан байгуулах ажлыг төслийн хэлбэрээр гүйцэтгэх арга хэмжээ авахыг Шинжлэх ухаан, боловсролын яам (Н. ӨЛЗИЙХУТАГ), Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН)-т даалгасугай.

5. Мал, амьтан, ургамлын зүйл, эм, хүнсний бараа, химийн бодис импортлох, худалдахтай холбогдсон бүртгэл хөтлөх, зөвшөөрөл олгох журмыг бүхэлд нь хянаж, боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Худалдаа, үйлдвэрийн яам (Ц. ЦОГТ), Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА), Хүнс, хөдөө аж ахуйн яам (Ц. ӨӨЛД), Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН)-т даалгасугай.

6. Бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, салбар хоорондын хөндлөнгийн хяналтыг сайжруулахтай холбогдуулан стандартчилал, хэмжил зүйн болон бусад сорилт туршилтын лабораториудыг орон нутагт тодорхой үе шаттайгаар байгуулж, техникийн түвшинг нь дээшлүүлж ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, үүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил жилийн төсөвт нь тусгаж байх арга хэмжээ авахыг Сангийн сайд (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга **Ч. УЛААН**

Засгийн газрын 1994 оны 124 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	— Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга
Орлогч дарга	— Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн ерөнхий захирал
Гишүүд	— Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга;
	— Хилийн цэргийг удирдах газрын дэд дарга;
	— Стандарт, хэмжил зүйн улсын ерөнхий байцаагч;
	— Улсын эрүүл ахуй, халд-

вар судлалын хяналтын газрын дарга;
— Улсын мал эмнэлгийн ерөнхий газрын дарга;
— Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын албаны дарга;
— Худалдаа, үйлдвэрийн яамны Хянан байцаах газрын дарга;
— Эм, био бэлдмэлийн улсын хяналтын төв лабораторийн эрхлэгч;
— Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газрын дарга;
— түс газрын эдийн засгийн хэлтсийн дарга;

Нарийн бичгийн дарга — Үндэсний стандартчилал, хэмжил зүйн төвийн стандарт, хэмжил зүйн хяналтын хэлтсийн дарга.

Засгийн газрын 1994 оны 124 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нийтлэг зүйл

1. Түс улсад импортоор оруулах болон гадаад орнуудад экспортлох барааны чанар, хэрэглээний шинж байдалд төрийн хяналт тавих мэргэжлийн хяналтын байгууллага, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, өөрийн орны холбогдох хууль тогтоомж болон гадаад орны байгууллага,

аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ контрактын шаардлага хангахуйц барааг улсын хилээр нэвтрүүлэх үед буюу нутаг дэвсгэрийн гүнд мэргэжлийн хяналтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахад уг зөвлөлийн үйл ажиллагааны зорилт оршино.

2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нь Засгийн газраас батална. Зөвлөлийн хуралдаанд үйлдвэрлэл, мэргэжлийн холбоод, нийгэмлэгийн төлөөлөгчдийг тэдгээрийн удирдлагатай тохирсны үндсэн дээр оролцуулж болно.

3. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж экспорт, импортын барааны чанарын хяналтын ажлын явц, үр дүнг хэлэлцэн шаардагдах арга хэмжээг авч мэргэжлийн хяналтын холбогдох албадад үүрэг даалгавар өгч байна.

4. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа протокол гаргах бөгөөд үйл ажиллагаандаа Үндэсний хөгжлийн газрын тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

5. Зөвлөл нь үйл ажиллагаагаа мэргэжлийн хяналтын байгууллага, албад, тэдгээрийн харьяа аймаг, суман дахь албадаар дамжуулж явуулна.

Түүнчлэн зөвлөлийн эрхлэх ажлын хүрээний асуудлаар аймаг дахь мэргэжлийн хяналтын албадын үйл ажиллагааг аймгийн Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга (захирал), хилийн боомт, гарц дээрх албадынхыг хилийн хамгаалалтын албаны дарга тус тус зохицуулна.

6. Зөвлөл нь ажлаа хагас жилээр төлөвлөн зохиосон ажлынхаа тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт оруулж байна.

Зөвлөлийн эрх, үүрэг

1. Экспорт, импортын барааны чанарын төрийн болон мэргэжлийн үлсын хяналт тавих үүрэг бүхий төв, орон нутгийн байгууллага, албадын ажлын зааг, хуваарийг судлан тэдгээрийн уялдааг хангах, хариуцан хяналт тавих объектын давхардлыг арилгах санал боловсруулж шийдвэрлүүлэх;

2. Импортын бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шинжилгээ, сорилт хийх ажилд мэргэжлийн экспертүүд, холбогдох лабораторийг оролцуулах, өөрийн оронд мэргэжлийн лаборатори байхгүй тохиолдолд гадаад орны эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах асуудлыг шийдвэрлэх;

3. Экспортод гаргах бүтээгдэхүүн түүхий эдийн чанарын талаар бэлтгэн нийлүүлэх гэрээ, контрактад заасан шаардлага хангагдаж байгаа эсэх болон гаргах гэж байгаа бүтээг-

дэхүүн, түүхий эдийн зэрэг дугаар, ангилалт, ялгалт, савлалт, баглаа боодол нь үндэсний стандартын түвшинд хийгдэж чадсан эсэхэд мэргэжлийн хяналтын холбогдох байгууллагаар иж бүрэн дүгнэлт гаргуулж, чанарын баталгаатай нийлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч байх;

4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1994 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 1 дүгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх болон харилцан нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын талаар гадаад орнуудтай байгуулсан хэлэлцээрийн биелэлтийг хангах талаар мэргэжлийн байгууллага, холбогдох яам, тусгай газар, аймаг, нийслэл (хот)-ийн Засаг даргын Тамгын газрын зүгээс зохион байгаа ажилд хяналт тавьж холбогдох үүрэг даалгавар өгч байна.

5. Хүний амь нас, эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд нөлөөлж болзошгүй бүтээгдэхүүн нь зохих шаардлага, эрүүл ахуйн нормд тохирч буй эсэхийг гэрчилж, худалдан борлуулахыг зөвшөөрсөн баталгаа, чанарын хяналтын гэрчилгээ, шинжилгээний дүнгийн үзүүлэлт, маягтыг ижилсгэсэн нэгдмэл загварт оруулж боловсронгуй болгох, тэдгээрийг гааль, хилийн цэргийн холбогдох байгууллагуудад мэдэгдэж мөрдүүлэх;

6. Экспорт, импортын бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж чанарын баталгаа гаргах ажлын тарифыг барааны үнийн дүнгийн тодорхой хувиар тогтоон баталж мөрдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 125

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн хэрэгжилтийн явцын тухай Эрүүл мэндийн сайд П. Нямдаваагийн сонсголыг авч хэлэлцээд Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу төрөөс харицуцах эмнэлгийн төлбөргүй тусламжийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхэд гарч буй гажуудлыг таслан зогсоож, улсын эмнэлгийн байгууллагуудаас эм хангамжийн хийгээд эрчим хүчний байгууллагад төлөх өрийг энэ оны 3 дугаар улиралд багтаан барагдуулахыг бүх шатны төсвийн захирагч, эрхлэгч нарт даалгасугай.

2. Төрийн өмчийн аж ахуйн нэгж болон төсөвт байгууллагад ажиллагчдын эрүүл мэндийн даатгалын хураамжийг тухайн нэгж, байгууллага нь нэгтгэн хурааж даатгагчид шилжүүлж байх, ажиллагчдынхаа хөдөлгөөний талаарх болон шаардлагатай бусад мэдээ, тайлангийн нэг хувийг эрүүл мэндийн даатгалын байгууллагад тухай бүр гарган өгч тооцоо хийж байхыг төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амыг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, төрөөс хураамжийг нь харицуцах иргэдийн бүртгэл, хөдөлгөөний талаарх мэдээг эрүүл мэндийн даатгалын байгууллагатай улирал бүр тохиролцож байхыг бүх шатны Засаг даргын Тамгын газарт харицуулсугай.

4. Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг шуурхай авч үзэж шийдвэр-

лэж байхыг Сангийн сайд Д. Даваасамбуу, Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**
Эрүүл мэндийн сайд **П. НЯМДАВАА**
Сангийн сайд **Д. ДАВААСАМБУУ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 7 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 128 | Улаанбаатар хот

ШИНЭЭР БАЙГУУЛАГДСАН АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХОТ, ТОСГОДЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1-д заасныг болон Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 6-д заасныг үндэслэн «Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай» Монгол Улсын Их Хурлын 1994 оны 53 дугаар тогтоолын зааltыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинээр байгуулагдсан Дархан-уул, Орхон, Говьсүмбэр аймгийн удирдлагын орон тоог Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 1, Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд захиргааны хэлтсийн дарга 1 байхаар тогтоосугай.

2. Дархан-уул, Орхон, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а) засаг захиргааны хэлтэс (цэрэг, иргэний хамгаалалтын штаб, аж ахуйн тасагтай):

б) санхүү, эдийн засгийн хэлтэс (Говьсүмбэр аймагт статистикийн тасагтай);

в) үйлдвэр, хот байгуулалтын хэлтэс;

г) нийгмийн бодлогын хэлтэс;

д) статистикийн хэлтэс (Дархан-уул, Орхон аймагт).

3. Дээрх 3 аймгийн Засаг даргын дэргэд Татварын хэлтэс, Цагдаагийн хэлтэс (газар)-тэй байхаар тогтоосугай.

4. Нутаг дэвсгэр, хүн ам, эдийн засаг, үйлдвэрлэлийн хэмжээ, хүрээнээс шалтгаалан Дархан-уул аймгийн Засаг даргын Тамгын газрыг 74 хүртэл, Орхон аймгийнхыг 60 хүртэл, Говьсүмбэр аймгийнхыг 35 хүртэл орон тоотой (нормативаар ажиллах орон тоо орохгүйгээр) байхаар тогтоосугай.

5. Аймгийн төв болон Хэнтий аймгийн Бэрх, Хэрлэн, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хөтөл, Өвөрхангай аймгийн Хархорин хотуудыг аймгийн зэрэглэлтэй хот байхаар тогтоосугай.

6 Дархан-уул, Орхон, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нь тухайн аймгийн төв-хотын захирагч байхаар, бусад аймгийн төв-хотуудын хувьд түүний орлын байгаа сумын Засаг дарга нь хотын захирагч байхаар тогтоосугай.

7. Тогтоосон орон тоо, цалингийн сангаас дулаан, цахилгаан, ус, хот байгуулалт, инженерийн шугам сүлжээний ажил хариуцуулахаар 6 хүртэл ажилтны орон тоо, цалингийн санг аймгийн төв, хотуудын захирагчийн ажлын албанд шилжүүлэн ажиллуулахыг нийт аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

8. Хүн амын тоо, байршил, иргэдэд үйлчлэх ажлын хэмжээ, онцлогийг харгалзан Дархан-уул аймгийн Дархан, Орхон аймгийн Баян-өндөр сумын Засаг даргын Тамгын газрын орон тоог урьд нь ажиллаж байсан хороодын захиргааны орон тоог хямдруулах чиглэлээр тусгайлан хянаж тогтоохыг Дархан-уул, Орхон аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

9. Сум, багийн төв болж байгаа тосгоны хувьд түүний орлын байгаа тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга тосгоны захирагч байх нь зүйтэй гэж үзсүгэй.

10. «Зарим хот, хороодыг сумдад нэгтгэх тухай» Монгол Улсын Их Хурлын 1994 оны 36 дугаар тогтоолыг үндэслэн дор дурдсан арга хэмжээ авсугай:

а) зарим хот, хороодыг засаг захиргааны хувьд тухайн сумдад нэгтэн харьяалуулсантай холбогдуулан тэдгээр хот,

хороодын одоогийн орон тоо, цалингийн сан хямдруулах замаар тухайн багийн Засаг даргын болон хот, тосгоны захирагчийн ажлын албыг зохион байгуулахыг Баян-өлгий, Булган, Говь-алтай, Дорноговь, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

б) хот, тосгодын оршин суугчдад үзүүлэх нийтийн аж ахуйн үйлчилгээ, нийгэм, соёлын байгууллагын санхүүжилт, барилга, хот байгуулалтын асуудал, барилга байгууламжийн ашиглалт, эзэмшилтийн байдалд хяналт тавих ажлыг тухайн хот, тосгоны захирагчид хариуцуулсугай;

в) Хөтөл хот, Хялганат тосгоны иргэдийн санал, хүсэлтэд анхааралтай хандаж эмнэлэг, сургууль, соёлын үйлчилгээг тасалдуулахгүй явуулах, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах асуудлыг хамтран шийдвэрлэж ажиллахыг Булган, Сэлэнгэ, Дархан-уул, Орхон аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

11. Энэ тогтоол болон «Аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай» Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 64 дүгээр тогтоолын 4, 6 дугаар зүйлийг үндэслэн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрыг зохион байгуулахыг шинээр томилогдох Засаг дарга нарт даалгасугай.

12. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Дархан, Эрдэнэт, Чойр хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны бүтцийг шинэчлэн тогтоох тухай» Засгийн газрын 1993 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 144 дүгээр тогтоол, «Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай» 1994 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 5 дугаар зүйлийн, «Дархан, Эрдэнэт хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны» гэсэн хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцож; «Хүн амын нийгмийн баталгааг хангах зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 69 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт (Төсөвт байгууллагын ажилтны хөдөлмөрийн хөлсний сүлжээг хэрэглэх журам)-ын 2 дугаар зүйлийн «Б-1» гэсэн хэсгийн «баг, хорооны Засаг дарга,» гэсний дараа «тосгоны захирагч,», «Б-4» гэсэн хэсгийн «сумын Засаг дарга,» гэсний дараа «аймгийн зэрэглэлтэй хотын захирагч,» гэсэн нэмэлт тус тус оруулсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**
Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

АХМАД ДАЙЧДАД НЭГ УДЛАГИЙН ТУСЛАМЖ ОЛГОХ, ТОГТООЛЫН ЗААЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Халх голын ялалтын 55 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Засгийн газрын комисс, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Халхын голын 1939 оны байлдаанд оролцсон ахмад дайчдад 1994 оны 8 дугаар сард багтаан 5000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг орон нутгийн төсвөөс олгохыг аймаг, нийслэл (хот)-ийн Засаг дарга нарт даалгасугай.

2. «Амьдрал ядуу, нэн бага орлоготой өрх, иргэд болон ахмад дайчдын талаар авах зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын 1993 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 123 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн «а» заалтын «. . . тэтгэврээс өөр орлогогүй, өрхийн дотор хөдөлмөрийн чадвартай хүнгүй . . .» гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Монгол Улсын шадар сайд Ч. ПҮРЭВДОРЖ

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. ГОМБОЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Радио долгион ашиглалтын асуудлыг хуулиар зохицуулах хүртэл түр мөрдүүлэхээр «Монгол Улсын радио долгионы ашиглалтын дүрэм»-ийг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Дэд бүтцийн хөгжлийн сайд **Р. САНДАЛХААН**

Засгийн газрын 1994 оны 139 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН РАДИО ДОЛГИОН АШИГЛАЛТЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын радио долгион ашиглалтын дүрмийн зорилт нь радио долгионыг тэгш эрхтэй, үр ашигтай ашиглах, зохицуулахад оршино.

2. Энэхүү дүрэм нь олон улсын радио холбооны дүрмийн дагуу радио албадад хуваарилсан долгионы зурвасуудыг үр ашигтай хуваарилах, төлөвлөх, зохицуулах, долгион ашиглах этгээдэд эрх олгох, хураамжийн нэгдсэн бодлого явуулах болон радио долгион ашиглахтай холбогдсон хууль тогтоомж. дүрэм, журам зөрчих явдалтай тэмцэх, харилцааны радио станц, радио телефон, радио телевизийн нэвтрүүлэх болон хүлээн авах станц, сансрын холбооны станц, радио сонирхогчдын станцууд (цаашид радио төхөөрөмж гэнэ)-ыг

байгуулах, ашиглахад долгион ашиглах эрхийн зөвшөөрөл олгох, хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

3. «Радио долгион» гэж 3000 ГГц хүртэлх үелзлийн цахилгаан соронзон долгионыг хэлнэ.

«Радио телефон» гэж радио долгион ашиглан аливаа мэдээллийг хүлээн авах, дамжуулахад зориулагдсан холбооны тоног төхөөрөмжийг хэлнэ.

ХОЁР. ЭРХ ОЛГОХ

4. Радио төхөөрөмж ашиглах долгионы эрх авах хүсэлтэй дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд Дэд бүтцийн хөгжлийн яаманд энэ дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу өргөдөл гаргана.

Энэ заалт нь зөвсөгт хүчин, бусад цэрэг болон аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах байгууллагуудад хамаарахгүй.

5. Дор дурдсан радио төхөөрөмжийг зөвшөөрөл авахгүйгээр ашиглаж болно. Үүнд:

а) техникийн стандарт хангасан 26, 9 МГц-ээс 27, 2 МГц-ийн зурваст ажилладаг гаралтын чадал нь 0,5 ваттаас ихгүй иргэний зориулалттай радио станц;

б) техникийн стандарт хангасан гаралтын чадал нь 0,01 ваттаас ихгүй радио станц.

6. Радио төхөөрөмжийг гадаадаас авчрах, үйлдвэрлэх зэрэг ажиллагаа явуулахаас өмнө тухайн төхөөрөмжийн долгионыг урьдчилан тохирсон байна.

7. Дэд бүтцийн хөгжлийн яам нь хүлээж авсан өргөдлийг дор дурдсан шаардлагын дагуу 14 хоногийн дотор шалгана. Үүнд:

а) радио төхөөрөмжийн байгууллагын зураглал хийгдсэн эсэх;

б) тодорхойлсон үелзлүүд нь ашиглах боломжтой эсэх;

в) төлөвлөгдсөн үйлчилгээг явуулах нөхцөл хангалттай эсэх;

г) радио төхөөрөмж байгуулахад зайлшгүй шаардлагатай бусад нөхцөлүүд хангагдсан эсэх.

8. Өргөдлийг шалгаад энэ дүрмийн 7 дугаар зүйлд заасан шаардлагууд хангагдсан нөхцөлд өргөдөл гаргагчид урьдчилсан эрхийн зөвшөөрөл олгоно. Уг зөвшөөрөлд:

а) байгууллагын ажил дуусах хугацаа;

б) цацралтын хэлбэр, үелзлийн хэмжээ;

в) дуудлагын нэр;

г) хүчин чадал;

д) ажиллахыг зөвшөөрсөн цаг зэргийг тусгасан байна.

9. Уьдчилсан эрхийн зөвшөөрөл авсан этгээдийн хүсэлтээр радио станц байгуулж дуусах хугацааг сунгаж болно.

10. Урьдчилсан эрхийн зөвшөөрөл авсан этгээд радио төхөөрөмж байгуулах зураг болон бусад зүйлд өөрчлөлт хийх бүртээ зөвшөөрөл авч байна.

11. Энэ дүрмийн 8 дугаар зүйлийн дагуу урьдчилсан эрхийн зөвшөөрөл авсан этгээд радио станц байгуулах ажлаа дууссаны дараа энэ тухайгаа Дэд бүтцийн хөгжлийн яаманд бичгээр мэдэгдэж шалгуулна.

12. Радио төхөөрөмж нь шаардлагатай нөхцөлүүдийг хангасан байвал радио долгион ашиглах эрхийн зөвшөөрлийг 2 жилээс илүүгүй хугацаагаар энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэж олгоно. Зөвшөөрлийг жил жилээр сунгах бөгөөд радио төхөөрөмжийг нэвтрүүлэг хийх зорилалтаар ашиглах нөхцөлд үйлчилгээ явуулах газруудыг уг зөвшөөрөлд нэмж тусгана.

Радио долгион ашиглах эрхээ хасуулсан бол түүнээс хойш 1 жилийн дотор дахин долгион ашиглах эрхийн зөвшөөрөл олгохгүй.

13. Радио станц байгуулах хугацаа дууссанаас хойш энэ тухайгаа 14 хоногийн дотор мэдэгдээгүй бол өргөдөл гаргагчид долгион ашиглах эрхийн зөвшөөрөл олгохгүй байж болно.

14. Эрхийн зөвшөөрөл авсан этгээд радио төхөөрөмж ажиллаж эхэлсэн хугацааг 7 хоногийн дотор Дэд бүтцийн хөгжлийн яаманд бичгээр мэдэгдэнэ.

15. Эрхийн зөвшөөрөл авсан этгээд радио төхөөрөмжийнхөө ажиллагааг 1 сараас илүү хугацаагаар зогсоох бол энэ тухайгаа Дэд бүтцийн хөгжлийн яаманд бичгээр мэдэгдэнэ.

16. Эрхийн зөвшөөрөл авсан этгээд радио холбооны зорилалт, газар зүйн байршил болон радио төхөөрөмжид өөрчлөлт хийх шаардлага гарвал дахин зөвшөөрөл авна.

17. Радио төхөөрөмжийг цаашид ашиглахгүй болсон тухайгаа бичгээр мэдэгдэж нэг сарын дотор зөвшөөрлөө буцааж өгнө.

ГУРАВ. РАДИО ТӨХӨӨРӨМЖ

18. Дамжуулах төхөөрөмжийн цацаргаж байгаа долгионы зөвшөөрөгдсөн зурвас, тогтворжилт зэрэг нь радио төхөөрөмжийн техникийн шаардлагыг хангасан байвал зохино.

19. Радио төхөөрөмжийн ажиллагаа нь хүний бие болон хүрээлэн байгаа орчинд ямар нэгэн хор хохирол учруулахгүй байх талаар урьдчилан холбогдох арга хэмжээг авсан байна.

20. Аливаа дамжуулах радио төхөөрөмж нь үелзэл, түүний тогтворжилт зэргийг хэмжих багажтай байна.

21. Сансрын хиймэл дагуулын радио төхөөрөмж нь алсын удирдлагаар чадлаа хязгаарлах болон цацалтаа зогсоох боломжоор хангагдсан байна.

ДӨРӨВ. РАДИО ТӨХӨӨРӨМЖИЙН АЖИЛЛАГАА

22. Радио төхөөрөмжийг эрхийн зөвшөөрөлд заасан зориулалтаар ажиллуулах, байгалийн гамшиг, осолтой холбогдсон мэдээлэл дамжуулахаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

23. Хуулинд өөрөөр заагаагүй бол аливаа этгээд бусдын ашиглаж байгаа радио холбоогоор дамжиж байгаа мэдээллийн нууцыг задалж түүнд садаа учруулж болохгүй.

24. Аливаа радио төхөөрөмж эзэмшигч нь радио долгион ашиглах эрхийн зөвшөөрөл, цагийн хуваарь, төхөөрөмжийн заавар, ажил, үйлчилгээний дэвтэр, харилцагч газрын жагсаалт зэрэг баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна.

ТАВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

25. Радио цацалтыг зохицуулах, хүн ам болон нийгмийн амгалан тайван байдлыг хангах үүднээс Дэд бүтцийн хөгжлийн яамнаас урьд нь олгосон эрхийн зөвшөөрөлд заасан радио төхөөрөмж эзэмшигчийн ашиглаж байгаа үелзэл, хүчин чадал, газар зүйн байршил зэргийг өөрчилж болно.

26. Шаардлагатай гэж үзвэл Дэд бүтцийн хөгжлийн яамнаас мэргэжлийн хэсэг томилон радио төхөөрөмжийн баримт бичиг, ажиллах цагийн хуваарь, үелзэл, хүчин чадал зэргийг шалгуулж, зөрчил илэрсэн тохиолдолд ажиллагааг нь түр зогсоох хүртэл арга хэмжээ авна.

27. Байгалийн гамшиг тохиолдсон буюу тохиолдох гэж байгаа үед Дэд бүтцийн хөгжлийн яамнаас аливаа радио төхөөрөмжөөр шаардлагатай бүх төрлийн радио мэдээллийг явуулах ажлыг зохион байгуулж радио төхөөрөмж эзэмшигчтэй хамтран ажиллана.

28. Радио төхөөрөмж эзэмшигч нь энэ дүрэм болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Дэд бүтцийн хөгжлийн яамнаас үг радио төхөөрөмжийн ажиллагааг түр зог-

соох, эсвэл ажиллах цагийн хуваарь, үелзэл, хүчин чадлыг багасгах буюу хязгаарлаж болно.

29. Радио төхөөрөмж эзэмшигч нь дор дурдсан зөрчил гаргасан тохиолдолд Дэд бүтцийн хөгжлийн яамнаас радио долгион ашиглах эрхийн зөвшөөрлийг хүчингүй болгоно. Үүнд:

а) хууль бус аргаар эрхийг үнэмлэх олж авсан;

б) хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр радио төхөөрөмжийг 3 сараас дээш хугацаагаар ажиллуулаагүй;

в) радио төхөөрөмждөө зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт хийж ашигласан;

г) тогтоосон хязгаарлалт, норм хэмжээг мөрдөөгүй;

д) зөвсөгт хүчин, бусад цэрэг болон аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах байгууллагын ашиглаж байгаа радио төхөөрөмжид санаатайгаар саад шуугиан оруулах, сонсох зэрэг зорилгоор зөвшөөрөлд заасан зориулалт бусаар радио төхөөрөмжийг ашигласан.

30. Радио долгион ашиглах эрхийн зөвшөөрөл нь хүчингүй болсон тохиолдолд Дэд бүтцийн хөгжлийн яамнаас радио төхөөрөмжийн ажиллагааг зогсооно. Энэ тохиолдолд эрхийн зөвшөөрөл эзэмшигч радио станцынхаа антенныг татан буулгах үүрэгтэй.

31. Радио чиглэл хайгч төхөөрөмж, радио долгионы хяналт шалгалтын станцаас 1 км зайд болон түүний цахилгаан соронзон талбайд саад учруулж болзошгүй газарт барилга байгууламж барих гэж байгаа этгээд энэ тухайгаа Дэд бүтцийн хөгжлийн яаманд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.

32. 10 КГц-ээс дээш үелзэлд ажилладаг холбоо, эмнэлэг, эрдэм шинжилгээ, сорилт, туршилтын зэрэг өндөр үелзлийн төхөөрөмжүүдийг ашиглах этгээд Дэд бүтцийн хөгжлийн яамнаас долгион ашиглах эрхийн зөвшөөрөл авна.

33. Тоног төхөөрөмж өвлөж буюу шилжүүлэн авсан этгээд энэ тухай баримт бүхий хүсэлтээ Дэд бүтцийн хөгжлийн яаманд бичгээр өгч эрхийн зөвшөөрөлдөө тодотгол хийлгүүлнэ.

34. Радио долгионы ашиглалтад Дэд бүтцийн хөгжлийн яамны радио долгионы асуудал хариуцсан ажилтан хяналт тавина. Энэ ажилтан нь улсын байшаагчийн эрхтэй байна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

35. Радио холбооны албанд ажилладаг аливаа этгээд энэ дүрмийн 2 дугаар зүйлд заасан тохиолдол гарсан үед

хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр радио холбоогоор үйлчлээгүй буруутай бол 1 жилээс дээшгүй хугацаагаар долгион ашиглах эрхийг нь хасна.

36. Радио долгионоо урьдчилан тохироогүйгээр гадаад орноос авчирсан, үйлдвэрлэсэн радио төхөөрөмжид долгионы зохицуулалт хийх боломжгүй байвал түүнийг тус улсын нутаг дэвсгэрт ашиглахыг хориглоно.

37. Долгион ашиглах эрхийн зөвшөөрөлгүй ашиглаж байгаа радио төхөөрөмжийн ажиллагааг зогсоож, зөрчлийг арилгасны дараа түүнийг ашиглах эсэхийг шийдвэрлэнэ.

38. Радио долгионы ашиглалтын журмыг зөрчсөн дор дурдсан тохиолдолд гэм буруутай хүмүүст улсын байцаагч Монгол Улсын Захиргааны харилцлагын тухай хуулийн 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу харилцлага хүлээлгэнэ:

1) өөрийн ашиг сонирхлоор бусдын эрх ашгийн эсрэг радио холбооны төхөөрөмжүүдээр аливаа хуурамч мэдээлэл дамжуулсан;

2) энэ дүрмийн 4 дүгээр зүйлд заасан зөвшөөрөл авалгүй радио станц байгуулж ажиллуулсан;

3) радио долгион ашиглах эрхийн зөвшөөрөлд заагдсанаас бусад зорилго, үйлчилгээнд радио төхөөрөмжийг ашигласан;

4) зөвшөөрөлгүйгээр радио төхөөрөмжийн байрлал, эд анги, үелзэл, дуудлага, ажлын төрөл, хүчин чадлыг өөрчилсөн;

5) үелзлийн тогтворжилт, зурвасын өргөн зэрэг чанарын үзүүлэлтийг хангаагүй радио төхөөрөмжийг ажиллуулсан;

6) энэхүү дүрмийн 14, 15, 16, 17, 29, 30, 32, 33 дугаар зүйлд заасныг биелүүлээгүй.

ДОЛОО. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

39. Монгол Улсын нутаг дэвсгэрт радио төхөөрөмж эзэмшигчдээс долгион ашиглалтын үйлчилгээний хөлс авна. Энэ заалт зөвсөгт хүчин, бусад цэрэг болон ажүулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах байгууллагуудад хамаарахгүй.

40. Долгион ашиглалтын үйлчилгээний хөлсийг Дэд бүтцийн хөгжлийн яамнаас нэгдсэн журмаар тогтооно.

41. Радио долгион ашиглалтын үйлчилгээний хөлсийг зохих дансанд оруулна. Долгион ашиглалтын үйлчилгээний хөлсийг чөлөөт валютаар төлж болно.

42. Долгион ашиглалтын үйлчилгээний хөлсийг Дэд бүтцийн хөгжлийн яам радио долгионыг төлөвлөх, хуваарилах, зохицуулах, хяналт, шалгалт хийх зэрэг үйл ажиллагаа, техникийн баазыг бэхжүүлэх, боловсронгуй болгоход чиглэгдсэн арга хэмжээнүүдэд зарцуулна.

Монгол Улсын радио долгион ашиглалтын дүрмийн 1 дүгээр хавсралт

РАДИО СТАНЦ АШИГЛАХЫГ ХҮСЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭЭС ГАРГАХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Асуулт	
1. Радио станц ашиглах зорилго	
2. Радио төхөөрөмж эзэмшигчийн нэр, хаяг, регистрийн дугаар	
3. Хэрэглэх радио төхөөрөмжийн зориулалт, явуулах үйлчилгээний төрөл	
4. Радио төхөөрөмжийн газар зүйн байршил	
5. Радио долгион цацаргах хэлбэр, шаардлагатай үелзэл, хүчин чадал, маяг	
6. Радио станцын ажиллах шаардлагатай цаг	
7. Радио станцыг ажиллуулж эхлэх ба дуусгахаар төлөвлөж байгаа хугацаа	
8. Радио төхөөрөмжийн байгуулалтын зураглал	

Тайлбар: Агаарын хөлөг, усан онгоц, сансрын хиймэл дагуулын радио төхөөрөмжийн долгион ашиглах эрхийн зөвшөөрөл авахыг хүссэн этгээд энд заасан зүйлүүдээс гадна эзэн, үйлчилгээний зорилго, төрөл, нислэг хийх, явах газрууд байнгын зогсоол, бүртгэгдсэн тэмдэг, хиймэл дагуултай холбогдох баримтууд, хиймэл дагуул хөөргөхөөр төлөвлөсөн хугацаа, байршил зэргийг мэдэгдэнэ.

Харьяалах газрын тамга.

Хариуцагчийн гарын үсэг

. . . он . . . сар . . . өдөр

Монгол Улсын радио долгион ашиглалтын дүрмийн 2 дугаар хавсралт

РАДИО ДОЛГИОН АШИГЛАХ ЭРХИЙН ЗӨВШӨӨРӨЛ

. . . оны . . . дугаар Дугаар Станцын дуудлага

. . . . . .

. . . . . .

сарын . . . -ны өдөр

Ажиллах үелзэл

. . . . . .

. . . . . .

Монгол улсын Дэд бүтцийн хөгжлийн Яам

Эзэмшигчийн нэр, хаяг, регистрийн дугаар

Станцын төрөл, чадал
Байршил

Зорилалт

Эрхийн бичиг
Ажиллах цаг

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

ЗААВАРТ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«Заавар батлах тухай» Засгийн газрын 1993 оны 1 дүгээр сарны 23-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан «Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар»-т дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

а) 2 дугаар зүйлийн «е» заалтын «. . . Тамгын газар» гэсний дараа «. . , хот, тосгоны захирагч» гэж нэмэх;

б) 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг «Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тамга, тэмдгийг Засаг дарга, тэдгээрийн орлогч, хот, тосгоны захирагчийн тамга, тэмдгийг хот, тосгоны захирагч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамгыг Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн дарга, нарийн бичгийн дарга, Иргэдийн Нийтийн Хурлын тамгыг Хурлын Тэргүүлэгчдийн даргын гарын үсэг зурсан бичиг баримт дээр дарна» гэж өөрчлөх;

в) 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн «. . . Засаг дарга» гэсний дараа «. . , тосгоны захирагч . . .» гэсэн хэсэг нэмэх;

г) 6 дугаар зүйлийн «в» заалтын «. . . Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, . . .» гэсний дараа «хотын захирагч,» мөн заалтын «. . . гэсэн бичээстэй байна» гэсний өмнө «, . . , хотын захирагчийн тамга нь « . . . хотын захирагч» гэсэн хэсэг тус тус нэмэх;

д) 6 дугаар зүйлийн «г» заалтыг «баг, хорооны Засаг дарга, Иргэдийн Нийтийн Хурал, хот, тосгоны захирагчийн тамга, сум, дүүргийн хэлтэс, тасаг, хот, тосгоны захирагчийн ажлын албаны тэмдэг нь 4,0 х 4,0 х 1,0 см хэмжээтэй, тамганы гол хэсэгт соёмбо байрлуулсан байна. Баг, хорооны Засаг дарга, Иргэдийн Нийтийн Хурал, хот, тосгоны захирагчийн тамганд «. . .-сум (дүүрэг)-ын . . . дугаар баг (хороо)-ийн

Засаг дарга», «. . . сум (дүүрэг)-ын . . . дугаар баг (хороо)-ийн Иргэдийн Нийтийн Хурал», «. . . аймгийн . . . сумын . . . хот (тосгон)-ын захирагч» гэсэн үгийг соёмбын хоёр галд тэгш байрлуулан бичнэ» гэж өөрчлөх.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Монгол Улсын шадар сайд Л. ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

СУМАНГ УЛСЫН БААТАР С. ТӨМӨРБААТАРЫН НЭРЭМЖИТ БОЛГОХ ТУХАЙ

Соёлын яам, Хилийн цэргийг удирдах газрын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Халх голын байлдааны үеэр дайсны халдлага, довтолгооноос улсынхаа хилийг баатарлагаар хамгаалж байгуулсан гавьяаг нь алдаршуулах зорилгоор Дорнод аймгийн Сумбэр сум дахь хилийн 24 дүгээр хорооны Эрс уулын 6 дугаар сумang улсын баатар Самдангийн Төмөрбаатарын нэрэмжит болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Соёлын сайд Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 145 | Улаанбаатар хот

ЗААВАР БАТЛАХ ТУХАЙ

Хорих байгууллагын болон Хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хорих байгууллагын ажилтанд хоригдолтой ажилласны нэмэгдэл олгох зааврыг хавсралтын ёсоор баталж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ
Хууль зүйн сайд Н. ЛУВСАНЖАВ
Сангийн сайд Д. ДАВААСАМБУУ

Засгийн газрын 1994 оны 145 дугаар тогтоолоор батлав.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАНД ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАСНЫ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЗААВАР

1. Хорих байгууллагад хоригдолтой байнга ажилладаг ажилтанд нэмэгдэл тогтоох, олгох, хасахад энэхүү зааврыг баримтална.

2. Хорих ангид ажиллаж байгаа ахлагч, офицер, Хорих байгууллагуудыг удирдах газрын шуурхай эрэн сурвалжлах-мөрдөн хөөх албаны ажилтанд хоригдолтой ажилласны нэмэгдлийг сар бүтэн үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Хорих ангийн дэглэмийн төрөл, алба	Хувь
1. Жирийн дэглэмтэй хорих ангид	3
2. Чанга дэглэмтэй хорих ангид	4
3. Онцгой дэглэмтэй хорих ангид	5
4. Гянданд	6
5. Хугацаагүй хорих тусгай салбарт	7
6. Шуурхай эрэн сурвалжлах-мөрдөн хөөх албанд	6

3. Хоригдолтой ажилласны нэмэгдлийг ажилд томилсон тушаал гарсны дараа сарын нэгнээс эхлэн тооцож олгоно.

4. Хорих байгууллагын ажилтан нь өөр дэглэмтэй хорих ангид томилогдох, албан тушаал өөрчлөгдөх, шилжих, ажлаас халагдах тухай бүр тушаал гаргаж дараа сарын нэгнээс эхлэн нэмэгдлийн өөрчлөлтийг тооцно.

5. Нэмэгдлийг албан томилолттой, чөлөөтэй, өвчтэй, ээлжийн амралттай байсан, ажил тасалсан зэргээр хоригдолтой шууд ажиллаагүй хугацаанд олгохгүй.

6. Хорих байгууллагын ажилтан албан хариуцлага алдсан, оргодол алдсан бол 6 сар хүртэл хугацаагаар Хорих байгууллагуудыг удирдах газрын болон хорих ангийн даргын тушаалаар нэмэгдлийг нь хасч болно.

7. Хоригдолтой ажилласны болон тусгай албаны нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

8. Уг зааврыг зөв мөрдөж байгаа эсэхэд Хорих байгууллагуудыг удирдах газар хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

ЗАРИМ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

«Валютын зохицуулалтын тухай хууль» батлагдсантай холбогдуулан уг хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 1994 оны 37 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газар (Сайд нарын Зөвлөл)-ын хэвшилтэд дурдсан тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Сангийн сайд **Д. ДАВААСАМБУУ**

Засгийн газрын 1994 оны 150 дугаар тогтоолын хавсралт

ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

А. Сайд нарын Зөвлөлийн

1. «Гадаад валют, гадаад валютаар худалдах бараг дугаардуулагчдад хүлээлгэх харилцлагын тухай» 1968 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 401 дүгээр тогтоол

2. «БНМАУ-ын валютын төлөвлөгөөг зохион журмыг өөрчлөх тухай» 1970 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 346 дугаар тогтоол

3. «Заавар батлах тухай» 1982 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 122 дугаар тогтоол

4. «Нисэх онгоцны суудал ашиглалтыг сайжруулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай» 1988 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 118 дугаар тогтоолын 3 дугаар зүйл

5. «Гадаадад зарим хувийн гуйвуулга хийхэд авах шимтгэлийн хувь хэмжээ тогтоох тухай» 1989 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 224 дүгээр тогтоол

Б. Засгийн газрын

6. «Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай» 1990 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 153 дугаар тогтоолын 5 дугаар зүйл

7. «Түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай» 1990 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 179 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл

8. «Жижиг үйлдвэр хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай» 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 37 дугаар тогтоолын 11, 12 дугаар зүйл

9. «Хэрэглээний хоршооны үйл ажиллагааг өргөтгөх талаар авах зарим арга хэмжээний тухай» 1991 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл

10. «Хөдөө аж ахуйн байгууллагын хүсэлтийн тухай» 1991 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 77 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл

11. «Улаанбаатар хотын газрын үнэлгээ, газар ашиглаcны төлбөр тогтоох тухай» 1991 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 136 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн «. . . чөлөөт валютаар . . .» гэсэн хэсэг

12. «Тогтоолд өөрчлөлт оруулах тухай» 1992 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 49 дүгээр тогтоол

13. «Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай» 1992 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн «г» заалт

14. «Төгрөгийн хөрвөх чадварыг сайжруулах зарим арга хэмжээний тухай» 1992 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 84 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хуяглан хүргэлт, хяналт хамгаалалтад зориулж машин техник, тоног төхөөрөмж авахад болон Багануурын хорих ангийн хоригдлын байрыг өргөтгөх, хугацаагүй хорих тусгай салбарын байр барихад шаардагдах хөрөнгийг хянан үзэж 1995 оны төсвийн хөрөнгө оруулалтад тусгах арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН), Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д даалгасугай.

2. Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Дарьт дахь хорих ангийг энэ оны 10 дугаар сард багтаан чанга дэглэмтэй хорих анги болгон зохион байгуулах, цагдан хоригдогчдыг Хорих байгууллагуудыг удирдах газрын харьяа нэгдсэн эмнэлэгт эмчлэх журам гаргаж мөрдөх, урьдчилан хорих байрын эмнэлгийн тасгийг өргөтгөх арга хэмжээ авахыг Цагдаагийн ерөнхий газар (Б. ПҮРЭВ), Хорих байгууллагуудыг удирдах газар (Г. ДЭНДЭВ)-т тус тус даалгасугай.

3. Дарьтад чанга дэглэмтэй хорих анги байгуулагдаж байгаатай холбогдуулан хамгаалалтын салбарыг шинээр зохион байгуулах арга хэмжээ авахыг Цагдаагийн ерөнхий газар (Б. ПҮРЭВ), Хууль зүйн сайд Н. Лувсанжав, Сангийн сайд Д. Даваасамбууд даалгасугай.

4. Дарьт дахь чанга дэглэмтэй хорих ангийг хамгаалах дотоодын цэргийн салбарт 8 га эдэлбэр газар олгохыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга (И. НЯМБУУ)-д үүрэг болгосугай.

5. «Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 1994 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зохицуулалт хийх тухай» Засгийн газрын 1994 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 122 дугаар тогтоолын хавсралтын 35-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар олгох 12 сая төгрөгийг хугацаагүй хорих ялыг эдлүүлэх гяндангийн барилга, дулааны шугам, нэгдсэн эмнэлэг болон хүүхдийн хорих ангийн байрыг

засварлах, Мөнгөнморьтын хорих ангийг нүүлгэн шилжүүлэхэд зохицуулан зарцуулахыг Хорих байгууллагуудыг удирдах газар (Г. ДЭНДЭВ)-т зөвшөөрсүгэй.

6. Амгалан дахь төвлөрсөн хорих ангид захиалга өгч хоригдлуудыг ажлын байраар хангах арга хэмжээ авахыг нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**
Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн бэлгэ тэмдгийн тухай Монгол Улсын хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн сүлд, туг, далбаа энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрөл олгох журмыг хавсралтын ёсоор батал-сугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**
Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

Засгийн газрын 1994 оны 152 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН СҮЛД, ТУГ, ДАЛБААГ ЭНГЭРИЙН БОЛОН ДУРСГАЛЫН ТЭМДЭГ, ЗУРАГТ ХУУДАС, ТӨРӨЛ БҮРИЙН ШОШГО, БУСАД ЗҮЙЛ ДЭЭР ДҮРСЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрөл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр зохих журмын дагуу дүрсэлж болно.

3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга тухай бүр олгоно.

4. Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр зураглал, дүрслэл, дардас, оёдол зэрэг хэлбэрээр дүрсэлж болно. Гэхдээ төрийн сүлдийг өнгө ялгах буюу ялгахгүйгээр, төрийн тугийг зөвхөн Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 8 дугаар зүйлд, Төрийн далбааг зөвхөн Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан өнгөөр тус тус дүрсэлнэ.

5. Төрийн сүлдийг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр өнгө ялган дүрслэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.

6. Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр зохих зөвшөөрлийн дагуу дүрслэхдээ түүний хэмжээнээс үл хамааран Үндсэн хуульд хавсаргасан эх загварт заасан тэг, харьцааг чанд баримтална.

7. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь дор дурдсан материалыг бүрдүүлсний үндсэн дээр төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх хүсэлтээ эх загварын

хамт тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлж хянуулан зөвшөөрөл авна:

а) Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн холбогдох заалт болон энэхүү журамд нийцүүлэн үйлдсэн эх загвар (биетээр буюу зургаар);

б) төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийг шошго, бусад зүйл дээр дүрслэх шаардлага, ач холбогдол, дүрслэх арга хэлбэр, хэмжээ, үйлдэх материал, ур хийцийг тодорхойлсон танилцуулга.

8. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь төрийн сүлд, туг, далбааг дээр нь дүрслэх энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйлийн эх загварыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлагын дагуу хянаж тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг хүсэлтийг хүлээн авснаас хойш 2 долоо хоногт багтаан зөвшөөрөл олгох буюу зохих хариу өгнө.

9. Төрийн сүлд, туг, далбааг зохих зөвшөөрөлгүйгээр энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, шошго, бусад зүйл дээр дүрслэх, эсвэл эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн эх загварыг өөрчлөн дүрслэхийг хориглоно.

Батлагдсан эх загварыг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл дахин хянуулж зөвшөөрөл авна.

10. Төрийн сүлд, туг, далбааг барааны тэмдэг, төрөл бүрийн бараа, хүвцас, сав суулга, гэр ахуйн болон албан конторын тавилга, өрөө тасалгааны хана, урилга, гудамжны чимэглэл, зам, талбай, барилга байшин, гэр, хашаан дээр болон агуулга, зориулалттай нь шууд холбоогүй ном, хэвлэл дээр дүрслэхийг хориглоно.

Түүнчлэн төрийн сүлд, туг, далбааг орлого олох зорилгоор дүрслэхийг хориглоно.

11. Гадаадын байгууллага, иргэн, харьяалалгүй хүн төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрөл авахдаа энэхүү журмыг баримтална.

12. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, энэхүү журмыг зөрчиж Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зураг хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрсэлсэн этгээдэд Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Халдварт өвчинтэй тэмцэх, уг өвчнөөс сэргийлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үйл ажиллагаа, зохион байгуулалт нь давхардаж байгааг харгалзан Халдварт өвчин судлалын төв, Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэг, Улсын эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын газар, Эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институт, Арьс өнгөний эмгэг судлалын төвийг тус тус татан буулгаж, улсын хэмжээнд халдварт өвчинтэй тэмцэх, уг өвчнөөс сэргийлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, эмнэлэг, үйлчилгээ, үйлдвэрлэл, хяналтын ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Эрүүл ахуй, халдвар, нян судлалын үндэсний төвийг клиникийн эмнэлэгтэйгээр байгуулах, Арьс өнгөний клиникийн эмнэлгийг Арьсны өвчин судлалын төв болгон өөрчлөхийг Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА), Нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ)-д зөвшөөрсүгэй.

2. Менингококк халдварын гаралтыг хязгаарлаж зогсоох зорилгоор 1994 онд нийслэлийн 1—15 насны бүх хүүхдийг вакцинжуулах, өвчний голомт бүхий газарт уг өвчнөөс сэргийлэх боломжит арга хэмжээг авч үр дүнг тооцсоны үндсэн дээр 1995 онд багтаан улсын хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулахыг Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА)-д даалгасугай.

3. Менингококк халдварыг оношлох, эмчлэх, сэргийлэхэд хэрэглэх эм, бэлдмэлийг гадаад орноос худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж өгөхийг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН), Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ), Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА)-д, уг өвчнөөр өвчлөгчдийг эмчлэхэд зориулан 1994 оны эхний хагаст Халдварт өвчнийг анагаах клиникийн эмнэлэгт зарцуулсан болон энэ онд нэмж шаардагдах хөрөн-

гийг тооцож нийслэлийн 1994 оны төсвөөс зохицуулан гаргахыг нийслэлийн Засаг дарга (Н. БААСАНЖАВ)-д тус тус даалгасугай.

4. Арьс өнгөний эмгэг судлалын төвийн байрлаж байсан байрыг эрүүл мэндийн үйлчилгээний зориулалтаар ашиглуулахаар дүүдлагын худалдаагаар борлуулахыг нийслэлийн Засаг дарга (Ц. БААСАНЖАВ), Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА)-д зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Эрүүл мэндийн сайд **П. НЯМДАВАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

СУРГУУЛИЙГ УЛСЫН БААТАР Д. ДАНЗАНВААНЧИГИЙН НЭРЭМЖИТ БОЛГОХ ТУХАЙ

Соёлын яам, Дорноговь аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Эх орноо батлан хамгаалахад байгуулсан алдар гавьяаг нь мөнхжүүлэх зорилгоор Дорноговь аймгийн Иххэт сумын 8 жилийн дунд сургуулийг Монгол Улсын баатар Дашийн Данзанваанчигийн нэрэмжит болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Соёлын сайд **Н. ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 155 | Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

«Зарим нэр төрлийн бараат улсын хилээр нэвтрүүлэхийг журамлах тухай» Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 7 дугаар заалтын «. . . мах, үр тариа, тэжээл» гэсэн хэсгийг 1994 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Худалдаа, үйлдвэрийн сайд **Ц. ЦОГТ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 8 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 156 | Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХИЙН БИЧГЭЭР ХИЙХ ХУВЬЧЛАЛЫН АЖЛЫГ ДУУСГАХТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийх хувьчлалын ажлыг энэ онд багтаан үндсэнд нь дуусгахаар тооцож зохион

байгуулалтын дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-т даалгасугай:

а) өмч хувьчлах хөтөлбөрт их хувьчлалд хамруулахаар тусгагдсан боловч одоогоор хувьчлагдаагүй байгаа үйлдвэрийн газруудаас хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлах хөрөнгийн хэмжээг үйлдвэр бүрээр гарган нийтэд мэдээлж, хувьчлах шийдвэрийг энэ оны 11 дүгээр сард багтаан гаргах;

б) дээрх үйлдвэрийн газруудын ажиллагчдаас үйлдвэрийнхээ хувьцааг эзэмшихийг хүссэн хүмүүс болон бусад иргэдээс тухайн үйлдвэрийн газрын хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдан авах захиалгыг энэ онд багтаан авч, 1995 оны 3 дугаар сард багтаан арилжаалан баталгаажуулж дуусгах;

в) төрийн өмчийн эзэмшилд байгаа орон сууцаа өмчлөн авахыг хүссэн иргэдээс хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн «ягаан» тасалбарыг нь орон сууц хувьчлах үед нөхөн тооцоохоор урьдчилан авах талаар тусгай журам гаргаж хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэд илүүдэл «ягаан» тасалбараа өөр хоорондоо худалдаалах хялбарчилсан нөхцөл боломжоор хангах;

г) зарим үйлдвэр, аж ахуйн газар, барилга байгууламжийг бэлэн мөнгөөр худалдаж, түүнээс орсон орлогыг хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон нийгмийн арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр болгон төвлөрүүлэн зарцуулах.

2. Иргэд хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн «цэнхэр» тасалбараараа үйлдвэрийн газрын хувьцааг захиалж авах, «ягаан» тасалбараа орон сууцныхаа төлбөрт оруулан ашиглахад нь тэдэнд зохих туслалцаа үзүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран цаг алдалгүй зохион байгуулахыг Засгийн газрын Өмч хувьчлалын комисс (Л. ЭНЭБИШ)-т, энэ ажлын явц, үр дүнг болон иргэдэд шаардлагатай бусад мэдээллийг тухай бүр зарлан нийтэлж ажиллахыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газар (Б. ӨВГӨНХҮҮ), «Засгийн газрын мэдээ» сонины редакци (Х. ЦЭВЛЭЭ)-д тус тус үүрэг болгосугай.

3. Их хувьчлалын хүрээнд хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдах улсын үйлдвэрийн газруудыг хувьчлах гөслийг яаралтай боловсруулж зохих шатны өмч хувьчлалын комиссоор хянуулж шуурхай шийдвэрлүүлэх арга хэмжээ

авч, хяналт тавьж ажиллахыг холбогдох сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлалыг явуулж дуусгахад яам, тусгай газар, нутгийн захиргааны байгууллагууд, аймаг, нийслэлийн өмч хувьчлалын комиссын хариуцан гүйцэтгэх ажлыг тодотгон, нарийвчилсан график-төлөвлөгөө гарган өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллан хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийх хувьчлалын ажлыг хэрхэн зохион байгуулж дуусгасан тухай дунг 1995 оны 1 улиралд Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын шадар сайд, Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын дарга Л. Энэбишид үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Монгол Улсын шадар сайд **Л. ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр Улаанбаатар

Дугаар 161

сарын 8-ны өдөр хот

ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН СУДАЛГААНЫ АЛБАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ

Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл хайгуул, эрдэс түүхий эдийн баазыг өргөжүүлэх зориулалтаар улсын төвлөрсөн төсвөөс олгож байгаа хөрөнгийн ашиглалт, ажлын үр дүн муудаж, геологийн судалгааны бодлого, ажлын зохион байгуулалт алдагдаж байгаа нь лус улсын эдийн засгийн хүч чадлыг бэхжүүлэх хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болохыг тэмдэглэж, геологи, эрдэс баялгийн судалгааны албаны зохион байгуулалтыг боловсронгуй болгох шаардлагыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дор дурдсан арга хэмжээг энэ оны 9 дүгээр сарын 1-нээс авч хэрэгжүүлэхийг Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд Б. Жигжидэд даалгасугай:

а) Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологийн судалгааны бодлого, төлөвлөлтийн газар (департамент)-ыг геологи, эрдсийн баялгийн судалгааны талаархи бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй Геологийн алба (департамент) болгон өргөтгөн зохион байгуулах;

б) Геологи, эрдэс баялгийн хүрээлэн, Геологийн төв лаборатори, Улсын геологийн фондыг төрийн өмчийн аж ахуйн нэгж хэлбэрээр яамныхаа харьяанд ажиллуулах;

в) Геологи хайгуулын ажил хийх төсөл гаргах, уг төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулан сонгож гэрээ байгуулах, геологийн судалгааны ажлын арга технологийг боловсруулж, түүний мөрдөлт, хэрэгжилтэд хяналт тавих, геолсги, хайгуулын ажлын тайланг гаргуулж шалган дүгнэлт өгөх үүргийг Геологи, эрдсийн баялгийн хүрээлэнд хариуцуулах.

2. Эрчим хүч, геологи, уул уурхайн яамны Геологийн судалгааны бодлого, төлөвлөлтийн газар (департамент)-ыг Геологийн алба (департамент) болгон зохион байгуулсантай холбогдуулан «Яам, газрын удирдлагын орон тоо, бүтцийг тогтоох, зардлын төсвийн хязгаар, цалингийн санг батлах тухай» Засгийн газрын 1994 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан тус яамны орон тоог 3 хүнээр, сарын цалингийн санг 50 (тавь) мянган төгрөгөөр, зардлын төсвийн хязгаарыг 349 (гурван зуун дөчин ес) мянган төгрөгөөр 1994 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн нэмэгдүүлэхийг Сангийн сайд Д. Даваасамбуу д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд **Б. ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр | Дугаар 163 | Улаанбаатар хот

ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ДООД ТҮВШИН, ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСНИЙ ДООД ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өрхийн нэг хүнд ногдох амьжиргааны баталгаажих доод түвшинг хотод 4200, хөдөөд 3700 төгрөгөөр тогтоосугай.

2. Амьжиргааны баталгаажих доод түвшинтэй уялдуулан төр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 32 төгрөг 82 мөнгөөр шинэчлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Хүн амын нийгмийн баталгааг хангах ээлжит арга хэмжээний тухай» Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 184 дүгээр тогтоолын 1, 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд — **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд — **Э. ГОМБОЖАВ**

Сангийн сайд — **Д. ДАВААСАМБУУ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 164 | Улаанбаатар хот

АРХИВЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

«Архивын талаар авах арга хэмжээний тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1994 оны 103 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Архивын салбарт шинэчлэл хийх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд Монгол Улсын архивын тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 1995 оны хаврын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх бэлтгэлийг энэ онд багтаан хангах арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Н. Лувсанжавт даалгасугай.

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийг 1995 онд зохион явуулсугай.

Үүнтэй холбогдуулан уг үзлэгийг зохион явуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж Засгийн газарт 1994 онд багтаан танилцуулахыг Хууль зүйн сайд Н. Лувсанжавт үүрэг болгосугай.

3. Архивын баримтыг хадгалах, сэргээн засварлах, хамгаалалтын хувь бий болгох, мэдээлэл хайх ажилд орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх арга хэмжээг 1995 оноос эхлэн дэс дараатай авч хэрэгжүүлэхийн хамт архивын албаны тогтолцоог боловсронгуй болгох саналыг энэ онд багтаан бэлтгэж Засгийн газарт оруулахыг Хууль зүйн сайд Н. Лувсанжавт, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Улсын архивын хэрэг эрхлэх газрын жил жилийн төсөвт тусгаж байхыг Сангийн яам (Д. ДАВААСАМБУУ)-д тус тус даалгасугай.

4. Архив, албан хэргийн мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг Хууль зүйн болон холбогдох бусад яам, газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, боловсролын яам (Н. ӨЛЗИЙХУТАГ)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хууль зүйн сайд **Н. ЛУВСАНЖАВ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 165

ХААЛТТАЙ БҮСИЙН ТУХАЙ

«Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль»-ийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мал, амьтан, тэдгээрээс хүнд халдварлах өвчний үүсгэгчээр үйлдвэрлэл, туршилт явуулдаг Биокомбинат, Мал эмнэлгийн эм, бэлдмэл шалгах улсын нэгдсэн лабораторийн эзэмшилд олгосон 20 га дэвсгэр нутгийг хаалттай (хорио цээрийн) бүс болгосугай.

2. Биокомбинат, Мал эмнэлгийн эм, бэлдмэл шалгах улсын нэгдсэн лабораторийн хаалттай (хорио цээрийн) бүсийн хилийг нарийвчлан тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. Өөлд, нийслэлийн Засаг дарга Ц. Баасанжав нарт даалгасугай.

3. Хаалттай (хорио цээрийн) бүсэд мөрдөх журмыг хавсралтын ёсоор батлаж, түүнийг Биокомбинат, Мал эмнэлгийн эм, бэлдмэл шалгах улсын нэгдсэн лабораторийн хаалттай бүсэд мөрдүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц. ӨӨЛД

Засгийн газрын 1994 оны 165 дугаар тогтоолын хавсралт

ХААЛТТАЙ (ХОРИО ЦЭЭРИЙН) БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмаар мал, амьтан, тэдгээрээс хүнд халдвар лах өвчний үүсгэгчээр үйлдвэрлэл, туршилт явуулдаг хаалттай (хорио цээрийн) бүсэд орших аж ахуйн нэгж, байгууллага, ажиллагчдын болон хаалттай бүсэд орж, гарахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулна.

2. Хаалттай бүс нь хашаатай, харуултай байх бөгөөд уг бүсэд хүн, машин техник оруулах, гаргахдаа заавал ариутгал, халдваргүйжүүлэлтийн цэгээр дамжуулна.

Хоёр. Нутагт нь хаалттай бүс тогтоосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хаалттай бүсэд орших байгууллага, мэргэжлийн алба, ажилтны хүлээх үүрэг

3. Нутагт нь хаалттай бүс тогтоосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга, түүний Тамгын газар дараахь үүрэг хүлээнэ:

а) халдварт өвчний хор хөнөөл, хаалттай бүсэд мөрдөх журмын талаар өөрийн харьяалах нутаг дэвсгэрт яриа танилцуулга хийх;

б) хаалттай бүс бүхий нутаг дэвсгэрийн хилийн заагт хаалттай бүсэд орших байгууллагын хүч хөрөнгөөр анхаарууллын тэмдэг тавиулж, харуул, хамгаалалт ажиллуулах;

в) хаалттай бүсэд мөрдөх журмын биелэлтийг шалгаж хангуулах;

г) хаалттай бүсэд орших байгууллагын эзэмшилд өгсөн газрын хэмжээ, байршилд хяналт тавих;

д) хаалттай бүсээс халдвар алдсан тохиолдолд хорио цээр тогтоон, хүн хүч, хөрөнгө гаргаж халдвар тархаахгүй байх, сэргийлэх арга хэмжээг хүн, мал эмнэлгийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх, шаардлагатай үед зохих журмын дагуу дайчилгаа явуулах.

4. Нутагт нь хаалттай бүс тогтоосон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн мал эмнэлгийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

а) энэхүү журмын биелэлтэд дангаар буюу харьяалагдах засаг захиргааны нэгжийн Засаг даргын Тамгын газар, хаалттай бүсэд оршдог байгууллагын удирдлагтай хамтарч хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

б) халдварт өвчний хор хөнөөл, хаалттай бүсийн онцлогийн талаар нийтэд мэдээлж, халдвараас сэргийлж хамгаалах арга хэмжээ авахуулах;

в) хаалттай бүстэй хил залгаа нутаг дэвсгэрт оршдог болон хаалттай бүсийн аж ахуйн нэгж, байгууллагатай байнгын харилцаатай байдаг байгууллага, иргэдийн мал, тэжээвэр амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад жил бүр бүрэн хамруулах;

г) хаалттай бүсээс халдвар алдсан тохиолдолд энэ талаар харьяалагдах засаг захиргааны нэгжийн Засаг дарга, түүний Тамгын газар, дээд шатны мал эмнэлгийн байгууллагад 12 цагийн дотор мэдээлсэн байхын зэрэгцээ хорио цээрийн арга хэмжээ авахуулах үндэслэл, шаардлагыг гаргаж, халдвар тархаахгүй байх, сэргийлэх арга хэмжээ авах.

5. Хаалттай бүсэд орших аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага дараахь үүрэг хүлээнэ:

а) албан ажлаар яваа хүмүүсийг болон үйлдвэрлэл, туршилтын ажилд хэрэглэгдэх тээврийн хэрэгслийг хаалттай бүсэд оруулах зөвшөөрөл олгох;

б) хөдөлмөрийн нөхцөлийн болон няхтай ажиллах журам тогтоож, байгууллагадаа сахиулж мөрдүүлэх;

в) хаалттай бүсийн онцлог, тэнд мөрдөх журмын талаар ажиллагчдад албан ёсоор танилцуулах, хаалттай бүстэй хил залгаа нутагт оршин суугчид, ажил төрлийн харилцаатай хүмүүсийн дунд сурталчилгаа явуулах;

г) хаалттай бүсээс халдвар алдсан тохиолдолд тухайн шатны Засаг дарга, мал эмнэлгийн зохих байгууллагад 12 цагийн дотор мэдэгдсэн байхын хамт хүн хүч, хөрөнгийг зохих журмын дагуу гаргаж, холбогдох байгууллагатай хамтран халдвар тархаахгүй байх, сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

д) хаалттай бүсэд орсон мал, амьтныг нядлуулж, зохих журмын дагуу бутлан боловсруулах, эсвэл булж устгуулах арга хэмжээ авч, учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр төлүүлэх;

е) хаалттай бүсийн хилийн зааг, уг бүсэд нэвтрэх цэг, зурвасын дагуу анхааруулсан тэмдэг тавихын хамт хамгаа-

лалтын найдвартай хашаа барихулж, түүний бүрэн бүтэн байдлыг хангуулах;

ж) хаалттай бүсэд орох хаалганы дэргэд байнгын ажиллагаатай харуул хамгаалалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн цэг ажиллуулах;

з) хаалттай бүсэд ажиллагчдыг эмнэлгийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулж эмчийн хяналтад байлгах;

и) халдварт өвчний үүсгэгчийн үйлдвэрлэлийн болон туршилтын омгуудыг тусгай томилсон хүнд хариуцуулж, омог хадгалах байрыг мэргэжлийн комиссын онцгой хяналтад байлгах;

к) ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөлийн болон нянтай ажиллах журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авах.

6. Хаалттай бүсийн харуул дараахь үүрэг гүйцэтгэнэ:

а) хаалттай бүсэд тусгай үнэмлэх, зөвшөөрөлтэй хүмүүсийг нэвтрүүлэх;

б) автомашин, тээврийн бусад хэрэгслийг хаалттай бүсэд оруулах, гаргахдаа байгууллагын удирдлагаас өгсөн албан ёсны зөвшөөрөл байгаа эсэхийг шалган ариутгал халдваргүйжүүлэлтийн цэгээр дамжуулах бөгөөд ялангуяа гадагш гарах тээврийн хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж, эд зүйлийг заавал ариутгал халдваргүйжүүлэлтэд оруулах;

в) албан үүргээ гүйцэтгэж яваа мал эмнэлгийн улсын байцаагч, хүн эмнэлгийн түргэн тусламж, гал сөнөөгч, цагдаагийн болон иргэний хамгаалалтын байгууллагын ажилтан нарыг унаа, машинтай нь саадгүй оруулах;

г) хаалттай бүсийн хилээр зөвшөөрөгдсөнөөс бусад мал, хаалттай бүсэд нэвтэрч орж ирсэн мал, амьтныг буцааж гаргахгүйгээр заавал ариутгал халдваргүйжүүлэлтэд оруулах, амьтан нэвтрүүлэхгүй байх асуудлыг бүрэн хариуцаж, зохих журмын дагуу нядалж устгуулахад хяналт тавих.

Гурав. **Хаалттай бүсэд ажиллах журам**

7. Хаалттай бүс бүхий нутаг дэвсгэрт дор дурдсан зүйлийг хориглоно:

а) тусгай үнэмлэх, зөвшөөрөлгүйгээр хүн, машин, техник нэвтрүүлэх;

б) үйлдвэрлэл, туршилтад хэрэглэж байгаагаас бусад мал, амьтан оруулах, дамжин өнгөрүүлэх;

в) мал, амьтны гаралтай түүхий эд бэлтгэх;

г) нийтийн хэрэглээний зориулалтаар хүнс болон бусад төрлийн үйлдвэрлэл, худалдаа зохион байгуулах;

д) үйлдвэрлэл, туршилтын байранд тэнд үүрэг гүйцэтгэхээс бусад хүнийг тусгай хувцас, халдвар хамгааллын хэрэгсэлгүйгээр оруулах, ажиллуулах;

е) үйлдвэрлэл, туршилтад хэрэглэж буй мал, амьтны байр, хашаа, саравч, тоног төхөөрөмжийг өөр зориулалтаар ашиглах;

ж) 16-гаас доош насны хүүхдийг хаалттай бүсэд оруулах;

з) нийтийн тээврийн болон бусад үйлдвэрлэл, туршилтын зориулалттай техник хэрэгслийг арилгаж, халдваргүйжүүлэлгүйгээр гадагш гаргах;

и) хаалттай бүсийн хамгаалалтын хашааг зөвшөөрөлгүйгээр томсгох буюу багасгах, байрлалыг өөрчлөх.

8. Хаалттай бүсэд ажиллагчид дараахь журмыг мөрдөж ажиллана:

а) тусгай үнэмлэхтэй байх бөгөөд хаалттай бүсэд нэвтрэхдээ түүнийгээ харуулын албанд заавал шалгуулж байх;

б) мал, амьтнаас хүнд халдварладаг өвчний үүсгэгч, хор, халдвартай материалтай ажилладаг хүмүүс мэргэжлийн диспансерийн үзлэг, шинжилгээнд жил бүр орж урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн байх;

в) халдвартай материалтай ажиллаж буй үед аюлын байрнаас гарч явах, бусадтай уулзахыг цээрлэх.

9. Хаалттай бүсэд байгаа лабораторид ажиллагчид дараахь журмыг мөрдөж ажиллана:

а) халдварт өвчний үүсгэгчийн омог, түүний өсгөврийг хадгалах, зөөвөрлөх, бүртгэх, шалгах, тэдгээртэй ажиллахдаа хамгаалах хувцас, хэрэгсэл хэрэглэж лабораторийн ажиллагааны горим болон нягтай ажиллах журмыг чанд биелүүлэх;

б) гоц халдварт өвчний үүсгэгчтэй ажилладаг лаборатори, цех, тасаг бүр осол гарсан үед яаралтай тусламж үзүүлэхэд хэрэглэх иж бүрэн эмийн сантай байх;

в) холбогдох бүртгэл, судалгааг зохих шаардлагын дагуу хөтлөх;

г) осол гарсан тохиолдолд энэ тухай цех, тасаг, лабораторийн эрхлэгч болон байгууллагын захиргаанд мэдэгдэн шуурхай арга хэмжээ авахуулах;

д) мал, амьтныг үйлдвэрлэл, туршилтын зориулалтаар халдварлуулах, халдварлуулсан мал, амьтныг маллах, тэжээх, нядлах, устгах, үхсэн мал, амьтны сэг зэм, тэдгээрт хэрэглэж байсан ус, тэжээлийн үлдэгдлийг хийж зөөвөрлөлөхөд зориулалт бүхий төмөр хайрцаг, бусад тоног төхөө-

роммж, арилтгал, халдваргүйжүүлэлтийн бодис зэргээр хангасан байхын дээр уг ажлыг тусгайлан бэлтгэсэн байр, тасалгаанд зохих хамгаалах хувцас, хэрэгсэл бүхий мэргэжлийн хүмүүсээр гүйцэтгүүлэх;

е) цэвэрлэгээ, арилтгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохих шаардлагын дагуу хийх.

10. Аж ахуйн нэгж, байгууллага, ажиллагчдын хүлээх үүрэг:

а) хаалттай бүсэд мөрдөх журмыг сахин биелүүлэх;

б) хаалттай бүсэд зөвхөн харуулын байраар дамжиж, зохих зөвшөөрөлтэйгээр нэвтрэх;

в) засаг захиргаа, мал эмнэлэг, хаалттай бүсийн байгууллагын удирдлага, мал эмнэлгийн улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

г) хаалттай бүсэд мал, амьтан оруулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх.

11. Хаалттай бүсэд мөрдөх журмын биелэлтэд тухайн шатны Засаг дарга болон хаалттай бүсэд орших байгууллагын удирдлага, мал эмнэлгийн улсын байцаагчид хяналт тавина.

Дөрөв. **Хариуцлага**

12. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол уг этгээдэд Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр | Улаанбаатар хот

Дугаар 171

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Нийгмийн даатгалын тухай хуулиудыг мөрдөх бэлтгэлийг хангах, «Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай» Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 61 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны харьяа Улсын нийгэм хангамжийн газрыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар болгон зохион байгуулахын хамт аймгуудын нийгэм хангамжийн хэлтэс болон нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Налайх, Багануур дүүргийн нийгэм хангамжийн хэлтсүүдийн одоогийн орон тоонд багтаан аймаг, нийслэл, дээрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийг энэ оны 10 дугаар сард багтаан зохион байгуулж ажиллуулахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Сум, нийслэлийн Багахангай, Гачуурт, Жаргалант, Туул дүүрэгт нийгмийн даатгалын байцаагч ажиллуулахын хамт хүн амын тоо, аж ахуйн нэгжийн төвлөрөл, даатгалын байцаагчийн ажлын ачааллаас хамааруулан 3 ба түүнээс олон ажилтантай сум, дүүрэгт нийгмийн даатгалын тасаг байгуулж ажиллуулахыг сум, нийслэлийн холбогдох дүүргийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Сангийн сайд Д. Даваасамбуу нарт даалгах нь:

а) нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангах, нийгмийн даатгалын дэвтэр, гэрчилгээ, бүртгэлийн маягт зэргийг хэвлүүлэх, нийгмийн даатгалын ажилтнууд, ажил олгогчдын семинар зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн тооцоог хянаж санхүүжүүлэх арга хэмжээ авсугай;

б) орон тоо, зардлыг нэмэгдүүлэхгүй байх шаардлагыг харгалзан нийгмийн халамжийн үйлчилгээний асуудлыг төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад харицуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг төсвөөс санхүүжүүлж байсугай.

4. «Нийгмийн даатгалын тухай» Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг болон 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн «Нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм»-ийг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

5. «Нийгмийн даатгалын тухай» Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын дэргэд ажиллах нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрүүг хянаж шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөл (орон тооны бус)-ийн дүрмийг 2 дугаар хавсралтын ёсоор баталж 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

6. «Нийгмийн даатгалын тухай» Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгүүдэд заасныг үндэслэн нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн бүрэлдэхүүн, дүрмийг 3, 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Үүнтэй холбогдуулан Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдэд хуралдаж асуудал шийдвэрлэхэд оролцсон цаг тутамд тооцож олгох цалингийн нэмэгдлийн хэмжээг Засгийн газраас тогтоосон төр, аж ахуйн нэгжийн ажилтан болон иргэдийн хоорондын гэрээгээр ажиллагчдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоох тухай Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны саналыг зөвшөөрсүгэй.

7. «Нийгмийн даатгалын тухай» Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн «Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм»-ийг 5 дугаар хавсралтын ёсоор баталж 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

8. Аймгийн болон нийслэлийн дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд ажиллах эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссыг энэ оны 12 дугаар сард багтаан зохион байгуулж ажиллуулахын хамт сумдад эмнэлэг хөдөлмөрийн байгууллага байгуулах асуудлыг тэдгээрийн хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөлтэй уял-

дуулан шийдвэрлэж байхыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожавт; Эрүүл мэндийн яамны харьяанд байсан «Мэргэжлийн өвчин судлалын төв»-ийг үндсэн болон эргэлтийн хөрөнгө, төсвийн хамтаар Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын харьяанд шилжүүлж, уг төвд мэргэжлийн өвчнийг эмчлэн сэргийлэх үүргийн дээр эмнэлэг хөдөлмөрийн магадалгааны арга зүй, зохион байгуулалтын ажлыг нэмж хариуцуулан ажиллуулахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Эрүүл мэндийн сайд П. Нямдаваа нарт даалгасугай.

9. «Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай» Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн «Үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох байнгын комисс (орон тооны бус)-ын дүрэм»-ийг 6 дугаар хавсралтын ёсоор батлаж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

10. «Нийгмийн даатгалын тухай» Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн «Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг өмчлөлийн хэлбэрээс үл хамааран 2,0 хувиар төлөх ажил олгогчийн үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний чиглэл»-ийг 7 дугаар хавсралтын ёсоор батлаж, 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

Үүнтэй холбогдуулан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний дээр дурдсан чиглэлд хамаарах ажил олгогчийн жагсаалтыг батлаж мөрдүүлэхийг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожавт зөвшөөрсүгэй.

11. Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд Э. Гомбожавт даалгах нь:

а) нийгмийн даатгалын дэвтэр, гэрчилгээ, тайлан, бүртгэлийн болон хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох шийдвэрийн маягт, түүнчлэн тэтгэмж олгох эмнэлгийн хуудас, тэдгээрийг хэрэглэх журам, аргачиллыг батлаж 1994 оны 12 дугаар сард багтаан хэвлүүлэн зохих байгууллагуудад хүргэх арга хэмжээ авсугай;

б) аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, тасгийн ажилтнууд болон ажил олгогчдын семинарыг холбогдох яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран нийслэлд болон Ховд, Завхан, Дорнод, Дундговь, Орхон, Дархан-уул аймагт бүсчилсэн байд-

лаар 1994 оны 12 дугаар сарын 15-ны дотор багтаан зохион байгуулсугай;

в) олон улсын байгууллага, хандивлагч орнуудын хөрөнгө, техникийн туслалцаатайгаар нийгмийн даатгалын бүртгэл, тайлан, мэдээллийн ажлыг компьютержүүлэх, нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх ажлыг холбогдох яамдтай хамтран зохион байгуулж, ээлж дараатай хэрэгжүүлсүгэй;

г) нийгмийн даатгалын талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аргачлал, гарын авлагаар аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг хангаж ажилласугай.

12. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

а) аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумдын нийгмийн даатгалын тасгийн дарга, байцаагчдыг хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын зохих шатны байгууллагатай зөвшилцөн 1994 оны 12 дугаар сард багтаан томилон ажиллуулсугай;

б) дэвсгэр нутгийнхаа хэмжээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийгмийн даатгалын байгууллагыг мэдлэг чадвар сайтай, үнэнч шударга ажилтнаар бэхжүүлэх, тэднийг хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нөхцөлөөр хангах арга хэмжээ авахын хамт нийгэм хангамжийн хэлтэс, тасгуудад байгаа үндсэн ба эргэлтийн хөрөнгийг нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлэн өгч эзэмшүүлсүгэй;

в) нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, иргэдийг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, иргэдийг нийгмийн даатгалд хамруулах арга хэмжээ авсугай.

13. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамтай хамтран зохион байгуулахыг Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газар (Б. ӨВГӨНХҮҮ), «Засгийн газрын мэдээ» сонины редакцид үүрэг болгосугай.

14. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын «Дүрэм батлах тухай» 1991 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 51 дүгээр тогтоол, «Дүрэм батлах тухай» 1991 оны

5 дугаар сарын 3-ны өдрийн 140 дүгээр тогтоол, «Дүрэмд өөрчлөлт оруулах тухай» 1992 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 110 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд **Э. ГОМБОЖАВ**

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА, БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

Нэг. **Нийтлэг үндэслэл**

1. Энэ дүрмийн зорилт нь Монгол Улсын нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж хяналт тавих, даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг тогтоож цаг тухайд нь олгох, улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах, нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулахад оршино.

2. Улсын нийгмийн даатгалын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааг нийгмийн даатгалын тухай хууллиуд болон энэ дүрмээр зохицуулна.

3. Нийгмийн даатгалын байгууллага, байцаагч үйл ажиллагаандаа хууль дээдлэх, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэх, бүсдын нөлөөнд үл автах зарчим баримтална

4. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос санхүү-

жүүлнэ. Улсын нийгмийн даатгалын бүх шатны байгууллагаа төсөвтэй байна.

55. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр нийгмийн даатгалын байгууллагаас гаргасан шийдвэрийг нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талууд дагаж мөрдөнө.

56. Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, тэдгээрийн ажилтан нь нийгмийн даатгалын хяналтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангаж нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авч ажиллах үүрэгтэй.

7. Нийгмийн даатгалын бүх шатны байгууллага нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, шинтгэлийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвийн татаас, нийгмийн даатгалын сангуудын зарлага, санхүүжилтийн талаар Сангийн яам, орон нутгийн санхүү, татварын албад, Монгол банк, арилжааны банктай ажлаа нягт уялдуулан мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэргээр хамтран ажиллана.

Хоёр. **Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага, зохион байгуулалт**

8. Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын нийгмийн даатгалын тасаг (ажилтан)-аас бүрдэнэ.

9. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар (цаашид «газар» гэх) нь биеэ даасан үйл ажиллагаа явуулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний; аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс нь тэдгээрийн Засаг дарга болон Газрын; дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумын нийгмийн даатгалын тасаг (ажилтан) нь тухайн шатны Засаг дарга болон аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсийн удирдлагын дор тус тус ажиллана.

10. Газар нь орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

11. Газрын даргыг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн; аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсийн даргыг Газрын даргатай зөвшилцөж аймаг,

нийслэлийн Засаг дарга; дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сумдын нийгмийн даатгалын тасгийн дарга (ажилтан)-ыг аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсийн даргатай зөвшилцөж тухайн шатны Засаг дарга тус тус томилно.

Газрын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байхын тулд Газрын даргын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

12. Бүх шатны нийгмийн даатгалын байгууллага нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий нийгмийн даатгалын байцаагчтай байна.

Газрын дарга нь нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагч байна.

13. Газар, аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс орон тооны бус байцаагч ажиллуулж болно. Орон тооны бус байцаагч ажиллуулах журмыг Газар тогтооно.

14. Бүх шатны нийгмийн даатгалын байгууллага нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Нийгмийн даатгалын улсын байцаагч үнэмлэхтэй байх бөгөөд хувийн тэмдэг, торгуулийн хуудас хэрэглэнэ.

Гурав. Газрын үүрэг, эрх

15. Газар нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, нийгмийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аргачлал, журам гаргах;

б) нийгмийн даатгалын сангууд (тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн ослын, мэргэжлээс шалтгаалсан өвчний, эрүүл мэндийн, ажилгүйдлийн даатгалын)-ыг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

в) нийгмийн даатгалын доод шатны байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж хяналт тавих, шалган зааварлах, тэргүүний арга барилыг сурталчлах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

г) улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийж, санал боловсруулах;

д) нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдал, үр дүнг судалж боловсронгуй болгох санал боловсруулах;

е) эрдэм шинжилгээ, боловсрол, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран буюу дангаараа нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, иргэдийг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох арга хэмжээ авах;

ж) нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын зардлын тайлан тэнцэл, бүртгэлийн маягт, нийгмийн даатгалын дэвтэр, бүртгэлийн гэрчилгээ, даатгалын гэрээ, байцаагчийн торгуулийн хуудас, эмнэлгийн хуудас, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоосон акт, шимтгэл ногдуулах, төлөх, тайлагнах баримт бичгийн загвар, маягтыг боловсруулж батлуулах;

з) ажил олгогч, даатгуулагчаас шимтгэлийг бүрэн төлүүлэх, тооцоо хийх, бүртгэлд тусгах, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төлбөрийг зохих журмын дагуу шуурхай олгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

и) ажил олгогч, даатгуулагчийн өргөдөл, гомдол, мэдээллийг хянаж шийдвэрлэх;

к) даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөл, хэмжээ, хугацаанд хяналт тавьж, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлыг удирдан зохион байгуулж, шалган зааварлах;

л) нийгмийн даатгалын байгууллагыг өндөр мэргэжил, мэдлэгтэй, үнэнч шударга, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдгээрийн мэргэшлийг дээшлүүлэх;

м) даатгалын сангуудын жилийн орлого, зарлагын төсөв, даатгалын санд улсын төсвөөс олгох татаас болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийг жил бүр зохиож улсын төсвийн төсөлд тусгуулах;

н) нийгмийн даатгалын төвлөрсөн санд улсын төсвөөс шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг аймаг, нийслэлийн даатгалын санд цаг тухайд нь хүргэж, зарцуулалтад хяналт тавих;

о) нийгмийн даатгалын сангуудын болон нийгмийн даатгалын байгууллагын төсөвт зардлын нэгдсэн тайланг улирал бүр, мэдээг сар бүр гаргаж, санал, дүгнэлтийн хамт холбогдох байгууллагад танилцуулах;

и) нийгмийн даатгалын байгууллагуудыг мэдээллийн сүлжээнд оруулах, цахим тооцоолох техник хэрэгслээр хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

р) нийгмийн даатгалын байгууллага, түүний ажилтны бүрүүгаар ажил олгогч, даатгуулагчийн гаргасан зардлыг хууль заасан журмын дагуу гаргуулах.

16. Газар нь дор дурдсан эрх эдэлнэ:

а) анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс хөдөлмөрийн хөлсний орлогыг тодорхойлох боломжгүй болсон ажил олгогчид түүнтэй адилтгах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ажил олгогчийн төлдөг шимтгэлийн хэмжээтэй адилаар шимтгэл ногдуулах;

б) тогтоосон хугацаанд шимтгэл төлөөгүй ажил олгогчийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг хууль тогтоомжид заасны дагуу түр зогсоох;

в) нийгмийн даатгалын байцаагчаас тавьсан актад заасан шимтгэл, алданги, хүү, торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол уг шимтгэл, алданги, хүү, торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих хууль тогтоомжийн дагуу гаргуулах;

г) илүү төлсөн шимтгэлийг дараагийн сар, улирал, жилийн төлбөл зохих шимтгэлд суутган тооцох буюу шимтгэл төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эргүүлж олгох;

д) шимтгэл, алданги, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн, шимтгэлийн мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй ажил олгогчид хууль заасан хариуцлага хүлээлгэх;

е) аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын сан түс бүрийн зарцуулагдаагүй үлдэгдлийг зайлшгүй шаардлагатай тохиолдолд төвлөрүүлэн авч нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах;

ж) нийгмийн даатгалын тухай хууль заасны дагуу хөрөнгийн боломжид тулгуурлан тодорхой төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах;

з) аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсээс гаргасан шийдвэр болон байцаагчийн тавьсан шалгалтын акт үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

и) нийгмийн даатгалын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг ажил олгогч болон даатгуулагчаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

к) нийгмийн даатгалын алба, даатгалын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх болон даатгалын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргах;

л) нийгмийн даатгалын байгууллагын ажилтнаас шалгалт авч ажилдаа тэнцэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхийн гадна тэднийг ажлын үр дүнг нь харгалзан хууль тогтоомжид заасны дагуу шагнаж урамшуулах;

м) олон улсын хөдөлмөрийн байгууллага, нийгэм хамгамжийн холбоо болон гадаадын бусад байгууллага, орнуудтай нийгмийн даатгалын асуудлаар ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах.

117. Нийгмийн даатгалын байгууллага дараахь асуудлаар шүүхэд нэхэмжлэл буюу гомдол гаргана:

а) шимтгэл, торгууль, алдангийг бүрэн буюу хагас хэмжээгээр төлөөгүй, нийгмийн даатгалын хууль тогтоомж ноцтой зөрчсөн ажил олгогчийн хөрөнгөөс төлбөр гаргуулахаар;

б) албан үүргээ гүйцэтгэхэд нь нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, түүнийг үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, амь бие, эрүүл мэндэд нь хохирол учруулсан гэм буруутай этгээдэд зохих хууль тогтоомжийн дагуу шийтгэл хүлээлгэхээр.

Дөрөв. Аймаг, нийслэл, дүүрэг, сумын нийгмийн даатгалын хэлтэс, тасаг (ажилтан)-ийн үүрэг, эрх

118. Аймаг, нийслэл, дүүрэг, сумын нийгмийн даатгалын хэлтэс, тасаг (ажилтан) дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, даатгуулагч болон цэргийн албан хаагчдад тэтгэвэр, тэтгэмж тогтоон олгох, үйлчилгээний төлбөр өгөх ажлыг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлэх;

б) тухайн нутаг дэвсгэр дэх ажил олгогч, даатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэлийг зохих хугацаанд нь даатгалын сан тус бүрт оруулах, нийгмийн даатгалын тухай

хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн үүргийн дагуу олгох тэтгэвэр, тэтгэмж болон цэргийн тэтгэвэр, тэтгэмжид зориулж улсын төсвөөс олгох татаасыг авч даатгалын сангуудын эрлогыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

в) тухайн нутаг дэвсгэр дэх ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын гэрчилгээ, дэвтэр олгож, бүртгэл хөтлөх;

г) тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, дутагдал зөрчлийг арилгах, тэргүүний арга барил болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах;

д) нийгмийн даатгалын сангуудын тайлан, мэдээ, нийгмийн даатгалын холбогдолтой мэдээллийг тогтоосон журмын дагуу Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт гаргаж өгөх;

е) нийгмийн даатгалын байгууллагыг үнэнч шударга, санхүү, нийгмийн даатгал, бүртгэлийн ажлын зохих мэдлэгтэй, дадлага туршлагатай, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх;

ж) нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийг зохих журмын дагуу захиран зарцуулах;

з) даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөл, хэмжээ, хугацааны талаарх мэдээлэл, тодорхойлолтыг хянаж, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлыг шалган зааварлах;

и) даатгалын сангуудын жилийн орлого, зарлагын төсөв, даатгалын санд улсын төсвөөс олгох татаас болон нийгмийн даатгалын байгууллагын төсвийг жил бүр зохиож хугацаанд нь Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт ирүүлэх;

19. Аймаг, найслэлийн нийгмийн даатгалын хэлтэс нь энэ дүрмийн 16 дугаар зүйлийн «е», «ж», «з», «к»-д зааснаас бусад заалт, 18 дугаар зүйлд заасан эрхийг эдлэхийн хамт дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сум, дүүргийн нийгмийн даатгалын тасаг (ажилтан)-аас гаргасан шийдвэр болон байцаагчийн тавьсан актыг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг цуцлах эрхтэй.

20. Дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, сум, дүүргийн нийгмийн даатгалын тасаг (ажилтан) нь энэ дүрмийн 16 дугаар зүйлийн «а», «б», «в», «г», «и»-д заасан эрхийг

эдлэхийн хамт байцаагчийн тавьсан шалгалтын актыг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг цуцлах эрхтэй.

Тав. Нийгмийн даатгалын байцаагчийн үүрэг, эрх, хариуцлага

21. Нийгмийн даатгалын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) шимтгэл төлөх, тэтгэмж олгохтой холбогдсон бүртгэл хөтлөх, мэдээ, тайлан гаргах ажлыг ажил олгогч тогтсосон хугацаанд гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах;

б) шимтгэл ногдох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг ажил олгогч үнэн зөв тодорхойлж, ногдсон шимтгэлээ төлсөн эсэхийг шалгаж шимтгэлийг хугацаанд нь даатгалын сан тус бүрт оруулах, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

в) ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын дэвтэр, гэрчилгээ, олгох, олгосон шимтгэлийг дэвтэрт бичих, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгох, төлбөр өгөх ажлыг зохион байгуулж гүйцэтгэх;

г) Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар болон аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тогтоолт, олголтод баримтын шалгалт хийх;

д) даатгалын сангуудын орлого, зарлагын төсвийг жил бүр хугацаанд нь боловсруулж сум, дүүрэг, аймаг, нийслэлийн жилийн төсөвт тусгуулах, улирал, жилийн тайлан тэнцэл, сарын мэдээг зохих журмын дагуу гаргах;

е) нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, таниулах, даатгуулагчдыг нийгмийн даатгалын талаар зохих мэдлэгтэй болгох.

22. Нийгмийн даатгалын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а) шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон данс бүртгэл, тайлан тэнцэл болон санхүүгийн бусад баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулан авах;

б) нийгмийн даатгалын хяналт шалгалтад шаардагдах магадалгаа баримтын хуулбарыг ажил олгогчийн харилцагч банк, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулах;

в) шимтгэл оногдох орлого нууcныг гэрчлэх баримтыг ажил олгогч болон даатгуулагчаас түр хугацаагаар хураан авах, хуулбарлах;

г) ажил олгогч болон даатгуулагчид «Нийгмийн даатгалын тухай Монгол Улсын хууль»-ийн 20 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх;

д) албан үүргээ гүйцэтгэх явцад даатгуулагч, ажил олгогчоос хууль бус үйл ажиллагааг явуулж байгаа нь илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх;

е) ажил олгогч нь бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод оногдох шимтгэлийг суутган авч нийгмийн даатгалын санд төлөөгүй байвал түүнийг ажил олгогчийн хөрөнгөөс гаргуулах.

23. Шимтгэл төлөгчийн хууль бус үйл ажиллагааг нуух, шимтгэлийн орлогыг хувийн зорилгодоо ашиглах, хээл хахууль авах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан тушаалтны үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нийгмийн даатгалын байцаагчид хууль тогтоомжид заасан сахилгын, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

24. Нийгмийн даатгалын байцаагчийн үйл ажиллагааны талаар шимтгэл төлөгч гомдлоо зохих шатны нийгмийн даатгалын байгууллага болон шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь шимтгэл төлөхийг зогсоох үндэслэл болохгүй. Гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор барагдуулна.

25. Нийгмийн даатгалын байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, өндөр мэдлэг дадлагатай, итгэл найдвар хүлээлгэх боломжтой, нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын саналыг үндэслэн Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайдын шийдвэрээр нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгоно.

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АЖИЛ ОЛГОГЧ, ДААТГУУЛАГЧ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХООРОНД ГАРСАН ЗӨРҮҮГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ГОМДЛЫН ШААРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

1. Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан зөрүүг хянаж шийдвэрлэх Гомдлын шаардлагын зөвлөл (цаашид «зөвлөл» гэх)-ийн үндсэн зорилго нь нэг талаас ажил олгогч, даатгуулагч, нөгөө талаас нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан санаалын зөрүүг хууль тогтоомжид нийлүүлэн хянан шийдвэрлэж ажил олгогч, даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад оршино.

2. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд орон тооны бус зөвлөл ажиллана.

3. Зөвлөл нь нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

4. Зөвлөл нь тогтоол, тэмдэглэл гаргах бөгөөд түүнийг даатгалын харилцаанд оролцогч талууд хэрэгжүүлэх үүрэгтэй.

5. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх зөвлөл нь аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх зөвлөлийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

6. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх зөвлөл нь Газрын даргын өмнө, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх зөвлөл нь тухайн шатны Засаг дарга, нийгмийн даатгалын хэлтсийн даргын өмнө тус тус ажлаа харицуцна.

7. Зөвлөлийн гишүүнээр ажилладаг нийгмийн даатгалын бус байгууллагын хүмүүст зөвлөлийн хуралд оролцсон цаг, ажлын үр дүнг харгалзан шагнал олгоно. Шагналын хэмжээ, журмыг нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлтэй зөвшилцөн Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга батална.

8. Зөвлөл нь тогтоосон журмаар хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн

9. Зөвлөл нь дарга, гишүүн бүгд 5—7 хүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлд нийгмийн даатгал, санхүү, эдийн засаг, хуулийн мэргэжлийн ажилтан орсон байна. Зөвлөл нь нарийн бичгийн дарга (орон тооны бус)-тай байна.

10. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх зөвлөлийн дарга, гишүүдийг газрын дарга батална. Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын зөвлөлийн дарга нь тухайн шатны нийгмийн даатгалын хэлтсийн дарга байх бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүнийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тус тус батална.

Гурав. Зөвлөлийн хуралдаан

11. Зөвлөл нь сард 1—2 удаа буюу ажлын шаардлага гарсан үед хуралдана. Зөвлөлийн хуралдааныг дарга удирдана. Зөвлөлийн дарга эзгүй тохиолдолд зөвлөлийн гишүүдийн аль нэг нь Зөвлөлийн даргын шийдвэрээр түүнийг орлоно.

12. Зөвлөлийн дотоод ажлыг зөвлөлийн дарга эрхлэх бөгөөд хуралд оруулах асуудлын бүрдлийг хариуцан хянаж бэлтгэнэ.

13. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж албажуулна.

14. Зөвлөл нь гомдол гаргагчаас ирүүлсэн материалыг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хуралдаанаараа хэлэлцэнэ. Хуралдаанд оролцсон зөвлөлийн гишүүдийн олонхийн саналд үндэслэн тогтоол гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

Санал зөрүүтэй байгаа гишүүн өөрийн саналыг зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд бичүүлэх буюу саналаа бичгээр гаргаж хуралдааны баримт бичигт хавсаргаж болно.

15. Зөвлөлийн хуралдааныг гишүүнийг гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдах бөгөөд зөвлөлийн хуралдаанд гомдол гаргагчийг шаардлагатай бол биеэр оролцуулна. Мөн холбогдох байгууллагын ажилтныг зөвлөлийн хуралдаанд оролцуулж болно.

Дөрөв. **Зөвлөлийн үүрэг, эрх**

16. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) ажил олгогч, даатгуулагчийн гомдлыг харьяаллын дагуу хүлээн авч шийдвэрлэх;

б) зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийг гомдол гаргагч (ажил олгогч, даатгуулагч)-д тайлбарлаж таниулах;

в) ажил олгогч, даатгуулагч иргэдээс буцааж өгөхөөр авсан бичиг баримтыг асуудал шийдэгдсэний дараа нэн даруй эргүүлж өгөх;

г) зөвлөлийн гишүүд нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сайтар судалж мэдсэн байхын хамт тэдгээрийг хэрэгжүүлэх, ажил олгогч, даатгагч, даатгуулагчдад тайлбарлаж сурталчлах, гарсан шийдвэрийнхээ үндэслэлийг ойлгуулах, маргаантай асуудалд зарчимч шударгаар хандаж шийдвэрлэх.

17. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а) маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай бичиг баримт, мэдээ, судалгааг холбогдох ажил олгогч болон даатгуулагч, даатгагчаас гаргуулж авах;

б) гомдол гаргагч болон холбогдох байгууллага, иргэдээс тайлбар, тодорхойлолт гаргуулж авах, санал, хүсэлтийг нь сонсох, мэргэжилтэн урьж зөвлөлгөө авах;

в) нийгмийн даатгалын байгууллагын болон байцаагчийн шийдвэрийг хууль зүйн үндэстэй гэж үзвэл ажил олгогч, даатгуулагчийн гомдлыг хэрэгсэхгүй болгоно. Хэрэв гомдол гаргагчийн гомдол нь хууль зүйн үндэстэй нь нотлогдвол түүнд оногдуулсан шимтгэл, хүү, торгуулийг чөлөөлөх, буруу тогтоож олгосон тэтгэвэр, тэтгэмжийг шинэчлэх, гаргасан зардлыг нь олгуулах асуудлыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагад тавих;

г) тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн эрх үүсэх үндсэн нөхцөл, болзол болон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн хэмжээний талаар гарсан маргааныг холбогдох бичиг баримтыг үндэслэн зохих хууль тогтоомжид нийцүүлэн хянаж шийдвэрлэх;

д) тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг нөхөн олгох, түдгэлзүүлэх, зогсоох. ажил олгогч, даатгуулагчийн буруутай үйл ажиллагаанаас болон хуурамч бичиг баримт бүрдүүлснээс шалтгаалан буруу тогтоогдсон тэтгэвэр, тэтгэмжийг өөрчлөн тогтоож олгох, суутгал хийх;

е) хөдөлмөрийн болон даатгалын дэвтэр нь зохих журмын дагуу хөтлөгдөөгүй тохиолдолд нотлох баримтыг хянаж

түүний ажилласан хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээг тогтоох;

ж) зөвлөлөөр хэлэлцэж буй асуудал гэмт хэргийн шинжтэй бол түүнийг хууль тогтоомжийн дагуу шүүхэд шилжүүлж хянуулах.

18. Ажил олгогч, даатгуулагч дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

а) ажил олгогч, даатгуулагч нь нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэсгүй гэж үзвэл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гомдлоо зөвлөлд гаргах;

б) гарсан гомдолтой холбогдох акт, бичиг баримттай танилцах;

в) зөвлөлийн хуралдаанд биеэр оролцож санал хүсэлтээ гаргах;

г) зөвлөлийн хуралдаан болохоос өмнө санал зөрүүтэй асуудлынхаа талаар амаар буюу бичгээр тайлбар, тодорхойлолт гаргаж өгөх;

д) зөвлөлийн хуралдааны тогтоол тэмдэглэлтэй танилцах;

е) зөвлөлийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд гомдлоо гаргах;

ж) нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн тавьсан акт, оногдуулсан хүү, торгуулийг зөвлөлийн хуралдаанаас хүчингүй болгосон тохиолдолд гомдол гаргагч хүү, торгуульд төлсөн зардлыг буцааж олгохыг шаардах;

з) зөвлөлийн дарга, гишүүдийн аль нэг нь шалгагч, гомдол гаргагчийн төрөл садан байгаа буюу эсвэл уг гомдлын талаар шалгаж акт, хүү, торгууль тавьж байсан бол түүгээр маргааныг шалгаж шийдвэрлүүлэхээс татгалзах;

и) ажил олгогч, даатгуулагч нь зөвлөлд хянан хэлэлцэгдэж байгаа асуудлын талаар нотлох баримт материал болон зөвлөлийн дарга, гишүүд түүнчлэн асуудлыг шалган магадлаж байгаа хүмүүст шаардлагатай тайлбар, тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ (ОРОН ТООНЫ БУС)-ИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийгмийн даатгалын Үндэсний (орон тооны бус) зөвлөл (цаашид «Зөвлөл» гэнэ)-ийн зорилго нь нийгмийн даатгалын үйл ажиллагаанд даатгагч, даатгуулагч, ажил олгогчийн тэгш оролцоог хангах, нийгмийн даатгалын хөгдолтой хууль тогтоомжийн биелэлт болон даатгалын ангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих, нийгмийн даатгалын асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж аргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад руулж шийдвэрлүүлэх, нийгмийн даатгалыг хэрэгжүүлэхэд эшино.

2. Зөвлөл нь нийгмийн даатгалын хуулийг болон энэхүү урмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулах бөөд түүнийг Засгийн газраас томилсон дарга толгойлно.

3. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд түүнийг влөлийн дарга даргална. Ажлын шаардлагыг харгалзан влөлийн дарга ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж лно.

4. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүйн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хуралдааны тэмдэгнийг нарийн бичгийн дарга (орон тооны бус) хөтлөх ба тэмдэглэлийг хурлын дарга зөвшөөрч гарын үсэг зурна.

5. Зөвлөл нь эрхэлж буй аливаа асуудлаар туслалцаа, өлгөө авах зорилгоор хуралдаанд мэргэжлийн хүмүүг зохих журмын дагуу оролцуулж болно.

6. Зөвлөл нь нийгмийн даатгалын асуудлаар зөвлөмж ах бөгөөд түүнийг даатгалд оролцогч талууд хэрэгжүүүрэгтэй.

. Зөвлөл нь тогтоосон журмаар хийгдсэн тэмдэг, албан ийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

. Зөвлөл биеэ даасан төсөвтэй байна. Төсвийг Зөвлөсаналыг үндэслэн Сангийн яам хянан баталж, нийгдаатгалын албаны төсөвт зардлаас гаргаж санхүүнэ

Хоёр. **Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн**

9. Зөвлөлийн дарга нь нийгмийн даатгалын асуудал эр-
хэлсэн Засгийн газрын гишүүн байна. Зөвлөлийн дарга, бү-
рэлдэхүүнийг Засгийн газар батална. Зөвлөлийн дарга нь
нийгмийн даатгалын асуудлаар Засгийн газрын өмнө, ги-
шүүд нь Зөвлөлийн даргын өмнө тус тус харилцаг
хүлээнэ.

10. Зөвлөл нь дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

а) даатгагчийг төлөөлсөн 5 гишүүн (Хүн амын бодлого
хөдөлмөрийн, Сангийн, Эрүүл мэндийн, Хууль зүйн яам
даатгагч түүний эрх ашгийг төлөөлсөн байгууллагаас ту
бүр 1 гишүүн);

б) ажил олгогчийг төлөөлсөн 5 гишүүн;

в) даатгуулагчийг төлөөлсөн 5 гишүүн.

11. Эрүүл мэндийн даатгалын асуудлаар салбар зөвлө
тэй байж болно. Зөвлөлийн үйл ажиллагааг Иргэний эрүү
мэндийн даатгалын хууль тогтоомжоор зохицуулна.

Гурав. **Зөвлөлийн үүрэг, эрх**

12. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн би
лэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлаг
байдалд хөндлөнгийн хяналт тавих;

б) нийгмийн даатгалын үйл ажиллагааны талаар ни
мийн даатгалын байгууллагын тайлан, мэдээллийг сонс
хэлэлцэх, санал дүгнэлт гаргах, шаардлагатай асуудл
холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

в) эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хийг
ажил олгогч, даатуулагч болон нийгмийн даатгалын б
гуулагын хооронд гарсан саналын зөрөөг хянаж шийд
лэх гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллага
хяналт тавьж, иргэдээс гаргасан гомдлыг барагдуулах з
хэмжээ авах;

г) нийгмийн даатгалыг хэрэгжүүлэх ажилд ажил олг
даатгуулагч, иргэд, олон нийтийн болон Засгийн газрын
байгууллагын идэвхтэй оролцоог хангуулах.

13. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а) нийгмийн даатгалын үйл ажиллагааг боловсро
болгох талаар санал боловсруулж холбогдох байгууллг
оруулах;

б) нийгмийн даатгалын асуудлаар зөвлөмж гаргах;

в) нийгмийн даатгалын сан түс бүрийн жилийн орлого, зарлагын төсвийг хянаж санал өгөх;

г) нийгмийн даатгалын сангийн тайлан тэнцлийг улирал бүр хэлэлцэж дүгнэлт гаргах;

д) нийгмийн даатгалын төв байгууллагын даргыг томилуулахх асуудлаар Засгийн газрын холбогдох гишүүнтэй өвшилцөх;

е) гамьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан тэтгэвэрийн хэмжээг өөрчлөх индексийн талаар санал гаргах;

ж) ажил олгогч, даатгуулагч, даатгалын байгууллагаас нийгмийн даатгалын хуулиудыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцаж, илэрсэн дутагдлыг арилгуулах талаар зөвлөмж, чиглэл өгөх;

з) даатгалын гэрээний нөхцөл, журам, загварыг батлан мөрдүүлэхэд санал өгөх;

и) даатгалтай холбогдсон мэдээ, тайлан, судалгааг ажил олгогч, даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагаас гаргуулан авах.

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ (ОРОН ТООНЫ БУС)-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга	— Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүн амын хөдөлмөрийн сайд
2. Даатгагчийг төлөөлсөн гишүүд:	— Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны Хөдөлмөрийн газрын ерөнхий захирал; — Сангийн яамны Төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн газрын дарга;

	— Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн эдийн за саг, хамтын ажиллагаан газрын ерөнхий захирал;
	— Хууль зүйн яамны Эрх зүйн ажлын хэлтсийн дарга;
	— Улсын нийгмийн даатга лын ерөнхий газрын дарг
3. Даатгуулагчийг төлөөлсөн гишүүд:	— Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэ ерөнхийлөгч;
	— мөн холбооны ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга;
	— мөн холбооны хуулийн мэргэжилтэн;
	— Монголын чөлөөт үйлд вэрчний эвлэлүүдийнн нэгд сэн холбооны дэд зохицуу лагч;
	— Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн
4. Ажил олгогчийг төлөөлсөн гишүүд:	— Монголын хувийн үүйлдвэ рийн эздийн холбооны дэ ерөнхийлөгч;
	— Монголын үйлдвэрлээл, үйлчилгээний хоршооодын холбооны дэд ерөнхийлөгч
	— Монголын Хөдөө ажк ахуй хоршоологчдын үндэсний холбооны ерөнхий зөөвлө лийн дарга;
	— Төвийн эрчим хүчний сис темийн дарга;
	— Улаанбаатар төмөр замы хэрэг эрхлэх газрын дэ дарга

5. Нарийн бичгийн дарга — Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын хэлтсийн дарга

Тайлбар: Олон нийтийн байгууллагаас Зөвлөлийн бүрэлдэхүүнд оролцох гишүүдийг тухайн байгууллагын удирдлагатай урьдчилан тохиролцсон болно.

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. **Нийтлэг үндэслэл**

1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (цаашид «комисс» гэнэ)-ын зорилго нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас хэсэгчлэн) алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн тусгай нөхцөл өгтоох асуудлыг магадлан шийдвэрлэхэд оршино.

2. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс ажиллана.

Сумаанд эмнэлэг хөдөлмөрийн комисс байгуулан ажиллуулж болно.

3. Комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалын тухай болон цэргийн албатгэвэр, тэтгэмжийн тухай хуулиуд, энэ дүрмийг мөрдлөг болгоно.

4. Комисс нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, хэвлэлээ хуудас хэрэглэнэ.

5. Комисс нь хуулийн дагуу эрх хэмжээнийхээ асуудлаар шийдвэр гаргах бөгөөд түүнийг даатгалын харилцаанд оролцогч талууд биелүүлэх үүрэгтэй.

Хоёр. **Комиссын бүрэлдэхүүн**

6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст нарийн мэргэжлийн эмч, нийгмийн даатгалын болон ажил олгогч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөгч орно.

7. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүний дарга, гишүүдийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга томилно.

Төв комисс нь орон нутгийн комиссыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах эмнэлэг хөдөлмөрийн магаадалгааны талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэнэ. Төв комиссын дарга, нарийн бичгийн дарга орон тооны байнга.

8. Аймаг, нийслэлийн дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 5—7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд комиссын дарга, гишүүдийг тухайн Засаг дарга, эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисстой тохиролцсоны үндсэн дээр Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатомилно.

9. Суманд эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс байгуулах бол уг комиссын дарга, гишүүдийг аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, тухайн сумын Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга томилно.

10. Аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магаадлах комиссын дарга, нарийн бичгийн дарга орон тооныы бус байна.

Гурав. **Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, түүний хувь хэмжээ, хугацааг тогтоох**

11. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгааныг ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас гэж ангилна.

12. Хөдөлмөрийн чадвар алдаж тахир дутуу болсныг хөдөлмөрийн чадвараа бүрэн, хагас (хэсэгчлэн) алдсанн гэж ангилан тогтооно.

113. Тахир дутуу болсныг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хэдэн хувиар хөдөлмөрийн чадвар алдсан болохыг энэ дүрмийн 11 дүгээр зүйлд заасан шалтгаан тус бүрээр тогтооно.

114. Тахир дутуу болсон даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан байдлыг дор дурдсан хувь, хэмжээг харгалзан тогтооно:

а) хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан тохиолдолд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсанд;

б) хөдөлмөрийн чадвараа 10—70 хүртэл хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвараа хагас (хэсэгчлэн) алдсанд тооцно.

115. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан байдалд байгаа хугацааг эхний удаад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол 6—24 сараар, хөдөлмөрийн чадвараа хагас алдсан бол 3—12 сараар тус тус тогтооно. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэх хүртэл дээрх хугацааны дотор хөдөлмөрийн чадвар алдсан хугацааг сунгаж болно. Харин даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэхгүй нь тогтоогдвол түүний тахир дутуу болсныг хугацаагүйгээр тогтоож болно.

Дөрөв. **Комиссын үүрэг, эрх**

116. Комисс дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас (хэсэгчлэн) алдсан шалтгааныг тогтоох;

б) хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас (хэсэгчлэн) алдсан хугацааг тогтоох;

в) ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоох;

г) ажилтны эрүүл мэндэд харшлах байдлыг харгалзан хөдөлмөрийн нөхцөлийг эхний удаа 6 сар хүртэл хугацаагаар өөрчлөх, шаардлагатай бол уг нөхцөлийг бүрэн өөрчлөхөөр шийдвэрлэх;

д) өвчин архаг шинж даамжрахаас сэргийлэх үүднээс ажлын ачааллыг багасгах шаардлагатай тохиолдолд даатгуулагчийн ажлын цагийг 6 сар хүртэл хугацаагаар богиносгож 6 цагаар тогтоох шийдвэр гаргах;

е) иргэний бүрэн хараагүй, дүлий болон одой болохыг тогтоох;

ж) төрөлхийн болон 16 нас хүрээгүй байхдаа тахир дутуу болсныг тогтоох;

з) төв комисс нь аймаг, нийслэлийн дүүрэг, сумын комиссын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдгээрийнн ажлыг шалган зааварлах;

и) төв комисс нь улсын хэмжээний эмнэлэг хөдөлмөрийнн магадлалын ажлын тайлан, мэдээг нэгтгэн дүгнэлт гаргах.

17. Комисс дор дурдсан эрх эдэлнэ:

а) даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа бүрэн болонн хагас (хэсэгчлэн) алдсан хугацааг дуусахаас 14 хоногийнн өмнө түүнийг комиссын хуралд орохыг шаардах;

б) комиссын шийдвэрийг ажил олгогч, даатгуулагч хэрэхэн хэрэгжүүлж байгааг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгахх арга хэмжээ авах;

в) хүндэтгэх, шалтгаангүйгээр хөдөлмөрийн чадвар алдсанаа тогтоолгоогүй даатгуулагчдад эмнэлэг хөдөлмөрийнн магадлал явуулахаас татгалзах;

г) комиссын ажилд нарийн мэргэжлийн эмч нарыг оролцуулах болон эмнэлгийн багаж хэрэгслийг үнэ төлбөргүйгээр түр ашиглах;

д) хүндэтгэх шалтгаанаар эмнэлэг хөдөлмөрийнн магадалгаа тогтоолгож чадаагүй даатгуулагчийн тахир дутууу болсныг нөхөн тогтоох;

е) төв комисс нь аймаг, дүүрэг, сумын комиссын гаргаасан шийдвэр буруу байвал түүнийг өөрчлөх, хүчингүй болгох.

Тав. Комиссын ажиллах журам

18. Эмнэлэг хөдөлмөрийн магадалгаа тогтоолгох асуудлыг эмнэлгийн байгууллагын эмчилгээний чанарын хяналлтын комиссын шийдвэрийг үндэслэн даатгуулагч, ажил олгогч хариуцна.

19. Комисс нь долоо хоногт нэг удаа хуралдана.

Комиссын хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүйй нь оролцсон нөхцөлд хийнэ.

20. Комисс нь аймгаас алслагдсан сумдад нүүдлийнн хурал хийж үйлчилж байна.

21. Комисс нь эмнэлэг хөдөлмөрийн магадлал тогтоохдоо өвчний оношийн үндэслэлийг бүрэн гаргаж, эмчлэгч

эмчээ, эмнэлгийн чанарын хяналтын комиссын саналыг харгалзсан гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.22. Орон нутгийн комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй даатгуулагч нь дээд шатны комисст гомдлоо гаргаж болно. Туххайн комисс даатгуулагчийн гомдлыг хүлээн авсан өдрөөс хойшш 14 хоногийн дотор шалгаж барагдуулна. Дээд шатны комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй даатгуулагч гомдлоо шүүхэд гаргаж болно.

2.23. Комиссын шийдвэрт комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, тэмдэг дарна.

2.24. Комисс нь үйл ажиллагааныхаа тайланг эмнэлэг хөдөлмөрийн магадлах дээд шатны комисст ирүүлнэ.

2.25. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт ажлаа тайлагнана.

2.26. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв болон орон нутгийнн комиссын гишүүдэд ажлын болон ажлын бус цагаар хурралдаж ажилласны хөлс олгох бөгөөд түүний хэмжээг Хүүш амын бодлого, хөдөлмөрийн сайд Сангийн яамтай тохирролцон тогтоно.

Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫГ СУДЛАН ТОГТООХ БАЙНГЫН КОМИСС (ОРОН ТООНЫ БУС)-ЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үйлдвэрлэлийн ослыг судлан тогтоох байнгын комисс (цаашид «комисс» гэнэ)-ын зорилго нь даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж эрүүл мэндээр хохирсон болон амь насаа алдахад хүргэсэн үйлдвэрлэлийн ослын шалтгааныг судлан тогтооход оршино.

2. Комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Хөдөлмөрийн хууль, Нийгмийн даатгалын тухай хуулиуд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар гарсан бусад хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдлөг болгоно.

3. Сум, дүүргийн Засаг дарга нь даатгуулагч, ажил олгогчийн эрх ашгийг нутаг дэвсгэрийн хэмжээнд төлөөлж чадах байгууллагын удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр комиссын бүрэлдэхүүнийг батална. Комисс нь даатгагч, даатгуулагч, ажил олгогчийн эрх ашгийг төлөөлсөн тэнцүү тооны төлөөлөгчдөөс бүрдсэн 6—9 гишүүнтэй байна.

Комиссыг сум, дүүргийн Засаг даргын орлогч ахалж, комиссын өдөр тутмын ажлыг орон тооны бус нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулна. Комиссын нарийн бичгийн дарга нь даатгагч байгууллагын төлөөлөгч байна.

4. Дараахь нөхцөл байдалд үйлдвэрлэлийн хүчин зүйлийн үйлчлэлд өртөж гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд оруулан тооцно:

а) ажлын үндсэн байрандаа буюу бусад газарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа, эсхүл ажлын байр, цэг, салбарын хооронд байнга явж ажлаа гүйцэтгэгч ажлын цагаар аливаа тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байгаад өртсөн осол;

б) ажлын байраа орхих боломжгүй ажил үүрэг гүйцэтгэгч ажлын байрандаа амарч байхдаа, эсхүл ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхлэн цэгцлэх, ажлын хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед гарсан осол;

в) ажилдаа ирэх буцах замдаа аливаа тээврийн хэрэгслээр буюу явган явж байхдаа өртсөн осол;

г) хөдөлмөрлөх үүргээ биелүүлж байх үедээ байгаль, цаг уурын гэнэтийн аюул, мал, амьтны халдлагад өртсөн, түүнчлэн цацраг идэвхит болон химийн хорт бодисын нөлөөнд нэрвэгдсэн зэрэг осол.

5. Хөдөлмөрийн хэт тааламжгүй нөхцөл, түүхий эд, материалын бохирдолтоос болж гарсан хордлогыг мэргэжлийн хяналтын холбогдох албадын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн осолд тооцож болно.

6. Албан үүргээ гүйцэтгэхийн тулд гадаад, дотоодод бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчиж явахдаа осолд орж нас барсан, тахир дутуу болж хөдөлмөрийн чадвараа алдсан

даатгуулагчид мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн үйлдвэрлэлийн ослын актыг комисс нөхөн тогтооно.

7. Дараахь нөхцөл байдалд гарсан ослыг үйлдвэрлэлийн осолд оруулж тооцохгүй:

а) ажил олгогч болон байгууллагын захиргааны шийдвэргүйгээр дур мэдэн үндсэн үүрэгт ажлаасаа өөр ажил үүрэг гүйцэтгэж байгаад өртсөн осол;

б) ажлын болон ажлын бус цагаар машин, тоног төхөөрөмжийг ашиглаж хувийн зорилготой үйлдвэрлэл явуулж байгаад өртсөн осол;

в) ажлын байрандаа мансуурулах бодис, согтууруулах ундаа хэрэглэснээс болж гарсан осол;

г) ажлын байраа орхиж явсан, аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөнөөс болж гарсан осол;

д) гэмт хэрэг хийх үедээ өөрийн биед гэмтэл учруулсан;

е) даатгуулагчийн өөрийн нь биенийн эрүүл мэндийн байдлаас болж ажил үүргээ гүйцэтгэж байхдаа архаг өвчний улмаас нас барсан буюу тахир дутуу болсон.

Хоёр. Комиссын үүрэг, эрх

8. Комисс нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а) сум, дүүргийн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагаас осол гарсан тухай мэдээ хүлээн авмагц 48 цагийн дотор газар дээр нь хүрэлцэн очиж үйлдвэрийн ослыг судлан тогтоох;

б) даатгуулагчийн осолд өртсөн тухай гомдол, санал хүсэлтийг хүлээн авч магадлан шалгаж шийдвэрлэх;

в) шалтгааныг нь судлан тогтоосон ослын акт, дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гарсан үйлдвэрлэлийн ослын тайланг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт жил жилийн эцэст гаргаж өгч байх.

9. Комисс дор дурдсан эрх эдэлнэ:

а) комиссын гишүүд нь үүргээ гүйцэтгэхийн тулд үйлдвэрлэл, ажлын байранд нэвтрэн орж осол гарсан нөхцөл байдалтай биечлэн танилцах;

б) ослын шинж байдлаас хамаарч мэргэжлийн хяналтын албаны байцаагчдыг удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр ослын шалтгааныг судлан тогтоох ажиллагаанд оролцуулах;

в) осолдогч болон осол гарах үед байсан гэрчийн эцгээд,

ргэжлийн хүмүүс, удирдах ажилтнуудаас ослын талаар дүүлэг авах, санал дүгнэлт гаргуулах;

г) зайлшгүй шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагаас ажиллах байр, техник хэрэгсэл, уналгаар хангуулах.

Гурав. Комиссын ажиллах журам

10. Комисс энэ дүрэмд хавсаргасан загвар маягтын гуу үйлдвэрлэлийн осолд акт тогтоох ба үйлдвэрлэлийн : ослын талаар дүгнэлт гаргана. Ослын акт болон дүгнэл- ослын шалтгааныг судалж тогтооход оролцсон комиссын шүүд гарын үсэг зурж, сум, дүүргийн Засаг даргын Там, н газрын тэмдэг дарна.

11. Комиссын акт, дүгнэлтийг 3 хувь үйлдэж даатгагч, атгуулагчид тус бүр нэг хувийг өгч үлдэх хувийг комисс дгална.

12. Комиссын шийдвэрийн талаар гарсан гомдол, мараныг хөдөлмөрийн хяналтын алба, шүүхийн байгууллагад зьж хянан шийдвэрлүүлж байна.

13. Үйлдвэрлэлийн осол гарснаас хойш 6 сарын хугацаа гөрсөн бол уг ослын шалтгааныг нөхөн сэргээж тогтоохгүй.

Хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛД ГАРСАН ОСЛЫН АКТ

№ . . . он . . . сар . . . өдөр

1. Аж ахуйн нэгжийн нэр, хаяг . . . . . .
2. Осол гарсан цех, хэсгийн нэр . . . . . .
3. Осол гарсан . . он . . сар . . өдөр . . цаг . . минут
4. Осолд хүргэсэн шалтгаан . . . . . .
5. Ослын улмаас хариуцлага хүлээлгэх гэм буруутай хүмүүсийн тухай дүгнэлт: . . . . . .
6. Осолдогчийн талаар гаргасан эмнэлгийн дүгнэлт: . . .

7. Осолдогчийн оршин суугаа газрын хаяг . . .

8. Осолдогчийн тодорхойлолт:
Овог нэр
Нас хүйс
Боловсрол
Шимтгэл төлж ажилласан хугацаа . . .
үүнээс осолдох үед гүйцэтгэж байсан ажил мэргэ
лээрээ ажилласан хугацаа . . . .
Ам бүл, гэр бүлийн байдал . . . .
. . . . . .

9. Комиссын шийдвэр . . . . . .
. . . . . .

Акт тогтоосон комиссын . . . . .
гишүүд: . . . . .
. . . . . .

Засгийн газрын 1994 оны 171 дүг
тогтоолын 7 дугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ӨМЧЛӨЛИЙН ХЭЛБЭРЭЭС ҮЛ ХАМААРАН 2 ХУВИАР ТӨЛӨХ АЖИЛ ОЛГОГЧИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ

I. Эрчим хүч, геологи, уул уурхайн салбар

1. Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуул
гүүгээх ажил;
2. Нүүрс олборлох ажил;
3. Бүх төрлийн ашигт малтмал олборлох, баяжуул
ажил;
4. Уул уурхай, эрчим хүчний барилга байгууламж, т

төхөөрөмжийн үгсралт, засварын болон сэлбэг үйлдвэрийн ажил;
5. Геологи хайгуулын ажил.

II. Зам, тээвэр, холбооны салбар

6. Нефть бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээх, хадгалах чилгээ;
7. Иргэний агаарын тээврийн үйлчилгээ, тээврийн хэлийн засварын ажил;
8. Төмөр замын үйлчилгээ, зүтгүүр, замын засварын ал;
9. Авто тээврийн үйлчилгээ
10. Усан тээврийн үйлчилгээ, тээвриін хэрэгслийн засын ажил;
11. Зам засвар, арчлалтын болон гүүрийн барилгын ал;
12. Авто болон бүх төрлийн машин механизм засварлах, ах ажил;
13. Холбох байгууламж ашиглалтын болон хот хоорон холбооны сүлжээний ашиглалт, холбооны үйлчилгээ.

III. Барилгын салбар

14. Барилгын материалын үйлдвэрлэл;
15. Барилга-угсралт, засал чимэглэл, засварын ажил;

IV. Хүнс, хөдөө аж ахуйн салбар

16. Биобэлдмэл үйлдвэрлэх, бактер шинжлэх ажил;
17. Мал зүй, мал эмнэлгийн ажил үйлчилгээ;
18. Газар тариалангийн ажил;
19. Саалийн механикжсан ферм, гахай, шувууны аж й эрхлэх ажил;
20. Гурил, тэжээлийн үйлдвэрлэл;
21. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
22. Яс өлөн гэдэс боловсруулах болон спирт, архи, пиво үйлдвэрлэл.

V. Хөнгөн үйлдвэр, нийтийн аж ахуй, үйлчилгээний салбар

23. Зоос, гоёлын зүйлийн үйлдвэрлэл;
24. Арьс шир, эсгий, нэхий, ноос, ноолуур боловсруулах, эр бэлэн бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэл;

25. Шил, шаазан, ваар керамик эдлэлийн үйлдвэрлэл;

26. Шүдэнз, лаа, савангийн үйлдвэрлэл;

27. Мод бэлтгэх, боловсруулах ажил.

VI. ЭМНЭЛЭГ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР

28. Эмийн үйлдвэрлэл;

29. Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах, хортон мэрэгчид устгах, халдваргүйжүүлэх ажил;

30. Вирус, халдвар, нян шавьж, эмгэг, эс, дархлал судлах, биохими, хими, эмийн шинжилгээний ажил;

31. Төрөл бүрийн ном, онин, сэтгүүл хэвлэх ажил;

32. Архивын ажил;

33. Кино үйлдвэрлэх, хилс боловсруулах ажил;

34. Реклам чимэглэлийн үйлдвэрлэл;

35. Ус хангамж, цэвэрлэгээний байгууламжид гүйцэтгэх ажил;

36. Лифтийн засвар үйлчилгээний ажил.